



ХУУЛЬ САХИУЛАХЫН
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2016 №3 (57) 14 дэх жилдээ



СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Б.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улсын Дээд Шүүхийн шүүгч, доктор (Ph.D),
профессор

Б.БАТЗОРИГ

Доктор (Ph.D), дэд профессор

Б.БОЛДБААТАР

Монголын Криминологичдын холбооны гүйцэтгэх
зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор

Н.ГАНБАДРАЛ

Доктор (Ph.D), дэд профессор

Ж.ДОЛГОРСҮРЭН

Доктор (Sc.D), профессор

Н.ЖАНЦАН

Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D),
профессор

О.ЗОРИГТ

Доктор (Ph.D)

А.ЛХАГВА

Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D),
профессор

Г.ЭРДЭНЭБАТ

Улсын Ерөнхий Прокурорын орлогч

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.ГАНТУЛГА

Доктор (Ph.D)

Б.ЭНХБОЛД

Доктор (Ph.D)

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

С.ГАНТУЛГА

Доктор (Ph.D)

ЭХ БЭЛТГЭГЧ ДИЗАЙНЕР

Х.БАДНААЖОНОН



Гарчиг

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Оффшор бүс дэх гэмт явдалтай тэмцэх олон улсын хамтын ажиллагаа
Ч.Нямсүрэн 4
- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэнд төрийн мониторингийг тогтоох асуудлыг шийдвэрлэх зарим арга замууд
Э.Болор-Эрдэнэ 11
- Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход тулгамдаж буй асуудлууд **Г.Баттулга** 16

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Эрүүгийн хуулийн шинэчлэл ба хөөн хэлэлцэх хугацаа **О.Амарсайхан** 21
- Монгол улсад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт ялоногдуулж буй практик, анхаарах асуудал **Б.Энхболд, Б.Нарангарав** 26

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Хууль сахиулах хүрээнд эрүүгийн процессын албадлага хэрэглэх ажиллагаа: онол, практикийн зарим асуудал **Д.Баярсайхан** 33
- Chinese case law? Practice and theory of the criminal guiding case system
Wenbo Pan 39
- Полиграф и его использование в республике Беларусь **Князев Владимир Михайлович** 44

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Криминалистикийн хэлний тухай асуудал **Б.Лхагвасүрэн** 49
- Хууль сахиулах үйл ажиллагаанд полиграфын үр дүнгашиглах боломж **Б.Цолмон** 53
- Шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэхэд тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам **Т.Очирбат** 59

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Цагдаагийн байгууллагад хийгдэж буй шинэтгэл, түүний үр нөлөөний талаарх олон нийтийн хандлага **Б.Баянмөнх** 65
- Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, сайжруулах арга зам **П.Энхтогтох** 71
- Хууль сахиулах байгууллагын тулгамдсан асуудалд олон нийтийн санаа бодлыг тусгахад анхаарах асуудлууд **Ч.Даваасүрэн** 76



ОФФШОР БҮС ДЭХ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

INTERNATIONAL CO-OPERATION IN COMBATING CRIMINAL ACTIVITIES IN OFFSHORE ZONES

Ч.НЯМСҮРЭН

Улсын Дээд шүүхийн Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга,
хууль зүйн ухааны доктор, цагдаагийн
бэлтгэл хурандаа

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд оффшор бүсийн ойлголт, үйл ажиллагааны онцлог, оффшор бүсийг ашиглан үйлдэж байгаа гэмт явдал, төрөл, түүнтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааны хэлбэр, түүний дотор мэдээллийн аналитик шинжилгээ, мэдээлэл солилцооны асуудлыг авч үзэж, оффшор бүсэд үйлдэх гэмт хэргийг урьдчилан сэргийлэх таслан зогсоох талаар санал дэвшүүлжээ.

Abstract: This article explores the concept of the offshore zone, its characters, conducts of criminal activities using offshore zones, types of the criminal activities and international co-operation as a combat mechanism with special attention to information analysis and information exchange and offers recommendations on fighting and preventing crimes conducted in offshore zones.

Түлхүүр Үгс: Оффшор, оффшор компани, оффшор данс, оффшор бүс дэх гэмт явдал, олон улсын хамтын ажиллагаа, аналитик тагнуул.

Key words: Offshore, offshore companies, offshore accounts, criminal activities in offshore zones, international co-operation, ana-

lytic intelligence.

Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн нийгэмлэг "Panama Papers"-ийн нууц материалуудыг дэлгэж, дэлхийн томоохон улс төрчид, бизнесмэнүүдийн эзэмшдэг оффшор данс, компаниудыг илчилсний дотор Монголын 50 гаруй иргэний оффшор данстай холбоотой гэх мэдээлэл ил болсон нь манай улсаас зөвхөн "хүн", "түүхий эд" гадагш урсаж, гадаадын хөрөнгө оруулалтын тусламжтайгаар байгалийн боловсруулаагүй баялгийг зөөвөрлөж байсан гэсэн бидний төсөөлөл "оффшор" гэсэн шинэ үзэгдэлтэй тулгарч, "хөрөнгө" гадагшилж байсныг саяхнаас ойлгож, нийгэм даяар нэг хэсэг шуугьж байснаа төдхөн намдаж эхлэв.

Оффшорын бүс нь зөвхөн эдийн засаг, эрх зүйн багш нарын амнаас оюутны ширээн дээр харь үзэгдэл мэтээр цөөхөн сонсож, хууль тогтоогчийн түвшинд анзаарагдахгүй, мэдсэн ч үл хөндөгдөх түвшинд байсан бол өнөөдөр асуултын тэмдэг бус харин тулгамдсан асуудал болоод байна.

Оффшор¹ (оффшор бүс) – энэ нь дүрмийн сангийн болон татварын доод түвшин, компанийн бүртгэлийн хялбарчилсан тогтолцоо, гүйлгээний өндөр нууцлалтай бизнесийн татай нөхцөлд дулдуйдсан нутаг дэвсгэр гэж ойлгож болно.

Оффшор бүсийн хамгийн гол онцлог шинж нь:

- Өмч хамгаалалт;
- Компанийн үүсгэн байгуулагчдын болон санхүүгийн гүйлгээний тухай мэдээллийн нууцлалыг өндөр түвшинд хангах баталгаа;
- Аж ахуйн нэгжийн бүртгэл болон татвар, нягтлан бодох бүртгэл, удирдлагын процедур энгийн хялбар;
- Ихэвчлэн валютын эргэлтийн сул хяналт зэргийг дурдаж болно.

Оффшор бол англи хэлний offshore буюу "эргээс гадуур", "хилийн цаана" гэдэг үгнээс гаралтай бөгөөд татвар төлөвлөлтийн нэг арга юм. «Off-shore»-ын зэрэгцээ "On-shore" буюу "эрэг дээр" гэсэн нэр томьёо бий. Эдгээр нэр томьёо ойлголтыг ашиглах боловч, хууль тогтоомжид тэр бүр хэрэгдэдэггүй.² Харин гадаадын бүтээлүүдэд tax havens, offshore zones, offshore jurisdictions, low-tax countries гэсэн нэр томьёо цөөнгүй дайралдана.

Оффшор гэсэн нэр томьёо өнгөрсөн зууны 50-иад оны үед АНУ-ын зүүн эргийн нэг сонинд анх дурдагдсан түүх бий. Тэр үед га-

¹ Англ. off-shore - нь страны, на расстоянии от берега.

² Жишээ нь Англи, Уэльс болон Шотландад бүртгүүлсэн компани нь өөрийн орны хуулийн этгээд (on-shore company), өөр улсад (АНУ, Герман, Кипр болон Багамын арал гэх зэрэг) бүртгүүлсэн компанийг гадаадын хуулийн этгээд (off-shore company) гэж тооцно.



зар зүйн байрлалыг сонгох замаар засгийн газрын хяналтаас зайлсхийсэн санхүүгийн байгууллагын тухай яригдаж эхэлсэн байна. Өөр үгээр хэлбэл, компани АНУ-ын засгийн газар хяналт тавих зохицуулалт хийдэг нутаг дэвсгэрийг татварын тааламжтай дэглэм бүхий нутаг дэвсгэрт шилжүүлэн байршуулах замаар АНУ тухайн салбарт оффшор ашиглаж эхлэх нэг ёсны анхдагч болсон гэж үздэг.

Оффшор ашиглах нь орчин үеийн үзэгдэл биш бололтой. Эртний Афин импорт, экспортод хоёр хувийн татвар ногдуулах үеэс грекийн болон финикийн худалдаачид татвараас зайлсхийхийн тулд татвар хураамжийн бүсээс хорин миль тойрч явах болсон төдийгүй, мөдхөн хөрш жижиг арлууд нь татвар хураамжаас зугтах оромж төдийгүй, Афинд хууль бус бараа нэвтрүүлэх агуулах болон хувирсан түүх байна. XV зууны үед Фландр нь дотоодын болон гадаадын бараанд тавих хязгаарлалт, татвар бага олон улсын худалдааны төв болон хөгжжээ.

АНУ нь XVIII зуунаас татвараас зайлсхийж ирсэн түүхтэй байна. Англиас ногдуулсан импортын татвараас зайлсхийхийн тулд америкийг колоничлогчид өөрсдийн худалдааг Латин америкийг дамжуулан хийж байжээ.

Орчин үеийн оффшор бүс байгуулах зорилго нь санхүүгийн бизнесийг татахад чиглэж буй нь нууц биш ээ. Швейцар нь гадаадын капиталыг орогнуулах, мөнгө солилцооны төв төдийгүй, санхүүгийн нууцлалын орчин үеийн загвар болон хөгжиж байна. XVIII зуунд Швейцарын Женев хотын Зөвлөл нь банкны эздээс үйлчлүүлэгчдийнхээ дансыг хөтлөх, хотын Зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр дансны нууцыг нарийн чанд хадгалах хууль баталж хэрэгжүүлжээ.

Өнгөрсөн зууны 30-аад онд Германд өрнөсөн нийгэм-улс төрийн өөрчлөлт, 1934 онд баталсан Банкны нууцын тухай Швейцарын хуулийг (1971 онд нэмэлт өөрчлөлт орсон) батлан гаргасан зэрэг нь Швейцарийг дэлхийн санхүүгийн нууц төв болгон хөгжүүлэхэд гол нөхцөл болсон. Чухамдаа дэлхийн хоёрдугаар дайны үед европын олон тэр бум доллар Швейцарын банкнуудад аюулгүй хадгалагдаж байж.

Сүүлийн үед бусад зарим улс орнууд санхүүгийн нууцлалын тухай швейцар маягийн хуулиудыг батлан хэрэгжүүлж, олон улсын капиталыг татахаар өрсөлдөж байна. Олон улс орнууд оффшор дансыг тогтвортой орлогын эх сурвалж болсон санхүүгийн бизнес хэмээн хүлээн зөвшөөрч, идэвхтэй хөгжүүлж, санхүүгийн бизнесийг татах идэвхтэй бодлого явуулж байна.

Оффшор бүсийн талаар албан ёсны бүртг-

эл байхгүй боловч, оффшор бүсийн тодорхой үйл ажиллагааны талаар ОУВС болон гадаадын улс орнуудын төв банкнууд хяналт тавихыг оролдож байна.

Өрсөлдөх чадвар султай арлын улс орнуудад тухайн үйл ажиллагаа нь эдийн засгийг хөгжүүлэх санхүүгийн нөөцийг татахаар зөвшөөрсөн цорын ганц хэрэгсэл нь болж байна.

Оффшор компаниуд нь татвар төлөвлөлтийн ил тод хэрэгсэл болохын хамт мөн түүнийг татвараас хууль бусаар зайлсхийх болон гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг ил болгох зорилгоор ашиглах нь цөөнгүй байна. Олон улсын худалдааны практикт оффшор компаниудыг хууль ёсны гүйлгээ хийхэд өргөнөөр ашиглана.

Оффшор байгууллага нь дэлхийн санхүүгийн хэлцлийн бараг тал хувийг эзэлдэг өргөн хүрээтэй бизнесийг хамарч байна. АНУ-ын Сенатын дэргэдэх мансууруулах бодис, терроризмтой тэмцэх дэд хорооны мэдээгээр жилд дундажаар 320-550 тэр бум доллартай тэнцэх "бохир мөнгө" эргэлддэг бөгөөд тэдгээрийн ихэнх хэсэг нь оффшор бүсээр дамждаг байна.³ АНУ-д жилд 300 тэр бумаас илүү доллар татвараас зугтаж, гадаадын санхүүгийн төвийн оффшор компаниудад байршиж байна.

Хөгжиж буй улс орнууд шинэ төрлийн гэмт явдал, түүний дотор авилгаас урьдчилан сэргийлэх зорилгоор оффшор компаниудын хууль бус гүйлгээ ашиглахаас сэргийлэхийг оролдож байна.

Ийнхүү оффшор бүс нь дэлхийн аль ч өнцөгт хүссэн нэгний хууль ёсны болон хууль бус зорилгоо хэрэгжүүлэх боломж болон хувирчээ.

Иймд оффшор данс эзэмшигчийн зорилгыг дотор нь: 1) гэмт хэрэг үйлдэхтэй холбоогүй; 2) оффшор бүсийг татвараас зугтах тухайлбал, оффшор фирмээр зуучлуулан бартерын, худалдааны, үнэт цаасны, үүргийн төлбөрийн гүйлгээ хийх, өөрийгөө санхүүжүүлэх зорилгоор ашиглах; 3) санхүүгийн бус эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотой гэж ангилан авч үзэж болно.

1. Бизнес эрхлэгчид оффшор зоныг гэмт хэргийн зорилгогүй, ихэвчлэн татварын төлөвлөлтийн, өөрөөр хэлбэл, татварын төлбөрийг хуулийн дагуу зөв оновчтой байршуулах зорилгоор ашигладаг. Татварын төлөвлөлт нь хуулийн дагуу татварын таатай орчинд аливаа хэлцэл хийхэд чиглэнэ.

Оффшор бүсийг ашиглах өөр нэг чухал шалтгаан бол бизнесийн активыг хамгаалах, улс төрийн болон эдийн засгийн тогтворгүй улс орнуудтай бизнесийн үйл ажиллагаа

³ Оффшорные холдинговые компании на рынке ценных бумаг // www.pnalog.ru/



явуулахад тэдгээрийн экспроприацийн эрсдэлийг бууруулахад оршино. Мөн бизнестэй холбоогүйгээр оффшор бүсийг ашиглах, тухайлбал, иргэний шүүн таслах ажиллагаа, түүний дотор гэр бүлийн хэрэг маргааны зарим талууд ашиглах тохиолдол цөөнгүй гардаг байна.

Орчин үед ихэнх оффшор нутаг дэвсгэрт английн хууль тогтоомжийн тогтолцоо үйлчилнэ. Байнга оршин суух тухай болон резидентийн асуудлыг анх XIX зууны үед авч үзсэн бөгөөд английн шүүхийн шийдвэрээр тухайн улс оронд өөрийн бүртгэл бүхий оффшортой, тухайн улсад амьдарч байгаа захирал түүнийг төвлөх байдлаар удирддаг компанийг резидент компани гэж тооцох болжээ.

Энэ хандлагын үүднээс авч үзэхэд оффшор бүсэд бүртгэлтэй компанийг тухайн улсад бүртгэлгүй этгээд компанийг үйл ажиллагаа, орлого, татварын хяналтгүйгээр эзэмшиж байгаа компанийг резидент бус компани гэж үзэж болно.

Оффшор бүсэд ажиллаж байгаа арилжааны компаниуд нь татварыг хөнгөвчлөх, гаалийн тариф, валютын хяналт, экспорт, импортын квотоос чөлөөлөгдөх хууль ёсны бүхий л арга хэрэгслийг ашиглах эрхээ өргөн хэрэгжүүлэх боломжтой байна.

Иймд оффшор бүсийг аль ч бүс нутагт ямар ч этгээд хууль ёсны болон хууль бус зорилгоо биелүүлэхийн тулд ашиглана. Тухайлбал гэмт этгээдүүд хялбарчилсан бүртгэл, тухайн компанийг бүртгүүлсэн этгээдийн тухай нууцлал, татварын болон бусад олон тооны хөнгөлөлтийг ашиглан оффшор бүсийг мөнгө угаах суурь дэвсгэр болгож байна.

2. Оффшор нутаг дэвсгэрийг хууль ёсоор ашиглахын хамт энэ бүс нутаг нь гэмт хэрэг, залилан мэхлэхийн үүр уурхай болдог. Үүнд нөлөөлж байгаа нэг гол хүчин зүйл болох санхүүгийн дээд зэргийн нууц хадгалалт нь гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн ул мөрөө нуун дарагдуулахад тааламжтай нөхцөл болно.

Санхүүгийн нууц журам нь гэмт хэргийн ул мөрөө баллах, тухайлбал, гэмт хэрэгтнээс санхүүгийн эх үүсвэрийг илрүүлэх, мөнгөний урсгалд шинжилгээ хийх, орлого нуусан талаарх фактыг баримтжуулахад хууль сахиулах үйл ажиллагаанд ноцтой саад учруулдаг. Мөн оффшор бүсийг эдийн засгийн хууль бус үйл ажиллагаа, санхүүгийн хуурамч баримт бичгийг хууль ёсны мэт болгон хувиргахад ашиглаж байна.

Оффшор бүсэд үйлдэх гэмт явдлыг: 1) татварын гэмт хэрэг үйлдэх, нуун дарагдуулах; 2) эдийн засгийн бусад гэмт хэрэг үйлдэх, нуун дарагдуулах гэсэн үндсэн

хэсэгт ангилж болно.

Оффшор бүс нь татвараас зайлсхийх маш олон янзын боломжийг олгодог. Татварын гэмт хэрэг үйлдэх, түүнийг нуух зорилгоор түгээмэл нийтлэг хэв маягийн компаниудаас гадна мөн оффшор траст, оффшор банк, даатгалын оффшор компани болон бусад тусгай чиг үүрэгтэй компаниудыг ашиглана. Орлогын эх сурвалж нь гадаад улс оронд байгаа буюу тодорхой бус тохиолдолд энэ нь тухайн хууль зүйн орчинд татварын хариуцлагын хүрээнээс гадуур байх боломжтой. Жишээ нь гадаад худалдаа, зуучлал, зөвлөгөө үзүүлэх үйлчилгээ үзүүлэх явцад тийм нөхцөл байдал үүсдэг. Ийм арга замаар бий болсон орлого нь оффшор фирмийн дансанд орж болно.

Зарим судлаачдын үзэж байгаагаар АНУ-ын Үндэсний нийт бүтээгдэхүүний 15%, Австрали, Франц зэрэг улсад - 10%, Герман улсад - 13%, Япон улсад - 5%, Норвеги улсад - 17%, Грек улсад - 50% нь татвараас зайлсхийдэг гэжээ.⁴

Арилжааны салбарт оффшор бүсийг гэмт сэдэл бүхий дараах хэлбэрээр ашиглана.

Оффшор фирмийн зуучилсан бартерын гүйлгээ. Оффшор фирм нь бараа таваарыг бартераар солилцож байгаа хоёр фирмийн дунд зуучлагчаар оролцож болно. Энэ тохиолдолд хэлцлээс олсон үндсэн орлого олон улсын гүйлгээний явцад татварын гадна үлдэнэ.

Өрийн үүргийн гүйлгээ. Оффшор компани нь дисконтоос нэрлэсэн үнээр өрийг цаашид үргэлжлүүлэн барагдуулах зорилгоор үүргийн гүйцэтгэлийг худалдан авна. Үр дүнд нь фирмийн олсон орлого нь татвараас бүрэн чөлөөлөгдөх буюу эсхүл хамгийн бага татвар ногдох боломжтой болно.

Үнэт цаасны гүйлгээ. Оффшор компаниас үнэт цаасыг бусад этгээдэд илүү өндөр үнээр цаашид дахин худалдахын тулд олж авахад оршино.

Оффшор компани зуучилсан худалдааны гүйлгээ.

Өөрийгөө санхүүжүүлэх. Оффшор компаниас оффшор бүсийн бус харилцагч-компанид зээл олгох байдлаар илэрнэ. Зээлийг оффшор компанитай харилцан тохирсон хүүтэйгээр эргэн төлнө. Гадаадын компанид төлсөн хүү нь татвараас зайлсхийх, эсхүл оффшор зоны туйлын бага татвар ногдуулах учраас холбогдох улс орны татвар хураамж буурахад нөлөөлнө.

Авилгач албан тушаалтнуудаас мөнгөн хөрөнгийн нууц санг бүрдүүлэхэд оффшор фирмүүдийг ашиглах.

Татварын бус эдийн засгийн бусад гэмт

⁴ Д. А. Верлан. Отмывание "грязных" денег. Одесса: Астропринт, 2000. Стр.12



хэрэгт мансууруулах бодисыг хууль бусаар наймаалах, хууль бус орлогыг хуримтлуулах, угаах. Оффшор бүс нь мөнгө угаах үйл явцын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болоод байна. Энэ нь үндсэндээ хоёр шалтгаанаас хамаарч байна. Эхний шалтгаан нь хөгжиж буй улс орнуудаас (ялангуяа АНУ) улс орны дотор мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт этгээдүүдийг илрүүлэх, мөрдөн шалгах туршлагатай болсонд оршино. Хоёр дахь шалтгаан нь санхүүгийн нууц хадгалалт, гүйлгээний үр ашигтай байдал нөлөөлж байна.

Мөнгө угаах процессыг: 1) гэмт хэргийн орлогыг үнэт цаас актив худалдан авах зорилгоор оффшор бүсэд байршуулах (placement); 2) бохир мөнгөний эх үүсвэр, түүний жинхэнэ эзнийг нуух, халхавчлах (layering); 3) бохир мөнгийг аж ахуйн болон санхүүгийн хууль ёсны тогтолцоонд нэвтрүүлэх, угаах (integration) гэсэн гурван үе шатаар хэрэгжүүлнэ.

Банкны оффшор нуувч, траст, корпорацаар дамжуулан мөнгө угааснаар гэмт хэргийн замаар олсон орлого ашиг нь цэвэр, ил доллар болон хувирч байна. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис болон бусад хууль бусаар олсон олон сая долларууд оффшор байгууллагуудаар дамжин угаагдаж, дараа нь хууль ёсны бизнес, үл хөдлөх хөрөнгө олж авах зорилгоор траст, хуурамч этгээдүүдэд шилжиж байна. Оффшор бүсэд байгуулагдсан банкнуудыг бусад орны банк болон банкны бүтцийн эсрэг залилан мэхлэх гүйлгээг хийхийн тулд ашиглаж байна. Хуурамч буюу баталгаагүй вексель, хадгаламж нөөцийн сертификат болон санхүүгийн бусад хэрэгслийг гаргах явдал өргөн дэлгэрч байна. Үүнд банк болон бусад компанийн үйл ажиллагааны, тухайлбал эзэмшигчийн нууц далд, тодорхой бус байдал, банк байгуулахад хямд төсөр, дүрмийн санд тавих хууль тогтоомжийн шаардлага байхгүй, эсхүл хууль тогтоомжид тавих хэрэгжилт сул, төөрөгдөл оруулж болзошгүй нэр хаяг бүхий фирм байгуулах боломж зэрэг оффшор дэглэм зэрэг таатай нөхцөл нөлөөлж байна.

Оффшор бүсийг мөн татварын “диваажин” хэмээн нэрийдэх эд хөрөнгийн хууль бус оромжийг сурталчлахад ашиглаж байна. Банкны нууцлал өндөртэй оффшор бүсийг ашиглахдаа гэмт хэрэгтнүүд хэргийн жинхэнэ чанарыг нууна.

АНУ аливаа дансны бенефициар өмчлөгч буюу тухайн хөрөнгөөс үр ашгийг хүртэгч жинхэнэ этгээдийг тодорхой болгох, улс орнуудтай байгуулсан боловч Конгресс батлаагүй байгаа татварын хэлэлцээрийг ёсчлох ажиллагааг яравчлах, өмнө нь

татвар төлөгчийн бүртгэлд ордоггүй байсан ганц хөрөнгө оруулагчтай гадаадын хөрөнгө оруулалттай компанид заавал татварын бүртгэлийн дугаар олгож бүртгэлжүүлэх зэрэг арга хэмжээг авч байна.⁵

Хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр тэтгэмж багатай, нийгмийн уур амьсгал төдийлөн сайн бус улс орнуудын гадаад төлбөрийн чадварт хүндрэл учирсан улс орнууд оффшор бүс хөгжүүлэх сонирхолтой байдаг.

Барууны өндөр хөгжилтэй улс орнууд оффшор бүсийн, ялангуяа европын бүсийн⁶ талаар ихээхэн аядуу бодлого баримталж ирсэн боловч, үндэстэн дамжсан зохион байгуулалттай гэмт явдал, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотойгоор түүний аюул заналыг мэдэрч, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, санхүүгийн гүйлгээнд хяналт тавих талаар хүчин чармайлт гаргах болжээ.

Гэхдээ олон улсын эрх зүйн үүднээс авч үзэхэд оффшор бүс бүхий улсад сонирхогч улс орнуудаас шууд дарамт шахалт үзүүлэх нь улс орны тусгаар тогтнол бүрэн эрхийг хүндэтгэх, хөндлөнгөөс оролцохгүй байх зэрэг олон улсын эрх зүйн үндсэн зарчмыг зөрчихөд хүргэдэг.

Франц улсын хувьд Панама пейперс задрахаас өмнө Ерөнхий сайдын “эдийн засгийн ил тод байдал ба шинэтгэл” хэмээх шинэтгэлийн ажлын хүрээнд авилгатай тэмцэх байгууллагын эрх зүйн статусыг тодорхойлсон хуулийг өөрчлөн найруулж тус байгууллагад хэд хэдэн чиглэлээр өргөн эрх мэдэл олгох, мөн түүнчлэн хамгийн гол нь “шүгэл үлээгч /Whistleblower/-ийн эрх зүйн статусыг тодорхой болгож хуулийн хамгаалалтад оруулах хуулийн төслийг боловсруулаад байсан бөгөөд энэ үйл явдлын түлхэцээр Парламентын гишүүд нь уг хуулийн төслийг хэлэлцэж эхлээд байна.

Пакистан оффшор компаниудад чиглэсэн хуулийн төсөл боловсруулахаар төлөвлөсөн, холбогдох төсвийг хуваарилсан гэсэн боловч чухам ямар чиглэлээр хуулийн төслөө боловсруулах нь өнөөдөр мэдэгдэж буй мэдээллээр тодорхойгүй байна.

Япон улсын хувьд 400 орчим иргэн, хуулийн этгээд нь оффшор данстай гэсэн боловч улс төр, бизнесийн томоохон зүтгэлтэн эдгээр дунд байхгүй байгаа нь тус улсын татварын орчин харьцангуй таатай бөгөөд тогтвортой байгаагийн илрэл юм.⁷

⁵ Н.Мөнхцэлмэг. Панама пейперсийн дуулиан: оффшор данс ба гадаад улсуудын туршлага, монгол улсын эрх зүйн орчныг сайжруулах шаардлага. Судалгааны материал. // ЕТГ. 2016.

⁶ Тухайлбал, Люксембург, Лихтенштейн, Гибралтар, Кипр, Мэн арал, Гернси арал гэх зэрэг.

⁷ Н.Мөнхцэлмэг. Панама пейперсийн дуулиан: оффшор данс ба гадаад улсуудын туршлага, Монгол Улсын



Нөгөө талаас оффшор дэглэм бүхий улс орнууд нь гадаадын хөрөнгийн урсгал, хүн амын хөдөлмөр эрхлэлт зэрэг эдийн засгийн шалтгаанаар тухайн бүсийг өөрчлөх, устгах сонирхолгүй.

Ийм ч учраас холбогдох улс орнуудаас оффшор бүсийн компани, банкнуудад байгаа сэжиг бүхий хөрөнгө, гүйлгээний гэмт хэргийн гаралтай эсэх талаарх мэдээллийг олж авахад чиглэх шаардлагатай болж байгаа юм.

Олон улсын эрх зүйн талаасаа мэдээлэл авсан улс орон нь тухайн мэдээллийг санхүүгийн терроризм, гэмт хэргийн замаар олсон орлогыг илрүүлэхэд л ашиглах баталгаагаар хангах шаардлагатай болж байна. Гэхдээ зэвсэг, хүний наймаа, мөрийтэй тоглоом, бие үнэлүүлэх болон бусад гэмт үйл ажиллагаанаас олсон асар их хэмжээний мөнгө оффшор бүсээр дамжин угаагдаж байгааг тооцож хэрэгтэй болж байна. Иймд оффшор ашиглан санхүүгийн эргэлтэд орж байгаа мөнгөн хөрөнгийн "цэвэр" эсэхэд хяналт тавих шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Оффшор бүс дэх гэмт явдалтай хийх тэмцлийг олон улсын хамтын ажиллагаа: 1) хоёр талын хамтын ажиллагаа; 2) бүс нутгийн түвшинд; 3) дэлхий нийтийн гэсэн чиглэлээр хөгжиж байна.

Оффшор байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих олон улсын эрх зүйн үндэс нь:

- 1988 оны НҮБ-ын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай Венийн конвенц;
- 1999 оны санхүүгийн терроризмтой тэмцэх тухай НҮБ-ын конвенц;
- 2000 оны Үндэстэн дамжсан зохион байгуулалттай гэмт явдлын эсрэг НҮБ-ын конвенц;
- 1990 оны "Гэмт үйл ажиллагаанаас олсон орлогыг угаах, илрүүлэх, битүүмжлэх, хураан авах тухай" Европын зөвлөлийн 141 дүгээр конвенц;
- 1986 оны усан онгоц бүртгэх нөхцлийн тухай НҮБ-ын конвенц;
- "Олон улсын терроризмтой тэмцэх тухай" 1373 (2001), АНУ дахь террорист үйлдэлтэй холбоотой" 1368 (2001) НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоол;
- НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн №1617 (2005) тогтоолын дагуу НҮБ-ын гишүүн орнууд заавал биелүүлэх олон улсын стандарт болох Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг боловсруулах Бүлгийн (FATF) дөчин зөвлөмж" болон уг бүлгийн (FATF) Санхүүгийн терроризмтой тэмцэх та-

эрх зүйн орчныг сайжруулах шаардлага. Судалгааны материал. // ЕТГ. 2016.

лаарх тусгай есөн зөвлөмж;

- Олон улсын Валютын фондын Санхүүгийн терроризм болон бохир мөнгөнийг угаахтай тэмцэхэд чиглэсэн Санхүүгийн оффшор бүс дэх санхүүгийн зохицуулалтад тавих хяналтыг нэмэгдүүлэх тухай хөтөлбөр (Offshore Financial Center Program);

- Эдийн засаг хамтын ажиллагааны байгууллага, санхүүгийн тогтвортой байдлын форумын баримт бичгүүд зэрэг.

Эдүгээ оффшорын бүс дэх мөнгөн хөрөнгийг ил болгох дараах аргуудыг хэрэглэж байна:

1) Татварын бүсийн "хар жагсаалт" үйлдэх (гадаадын ихэнх улс орнууд оффшорын бүсийн байгууллагатай тэмцэх зорилгоор санхүүгийн гүйлгээнд онцгой хяналт тавихын тулд хар жагсаалт гэж нэрийдэх бүсийн нэрсийг тодорхойлно);

2) үндэсний банкны тогтолцооны хяналтаар банкны нууцлалын тогтолцоог эвдэх, устгах;

3) оффшор төвүүдэд улс төрийн дарамт шахалт үзүүлэх;

4) хэл амаа ололцохгүй байгаа бүсийн эсрэг тодорхой хориг тавих гэх зэрэг.

Дурдсан арга хэмжээнээс гадна олон улс орнууд татварын хууль тогтоомжоор оффшор ашиглах хязгаарлалт тогтоож байна.

2016 оны зургадугаар сарын 23-27-нд Парис хотноо мөнгө угаах, терроризм, цөмийн зэвсгийг санхүүжүүлэхтэй тэмцэх Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (Financial Action Task Force буюу ФАТФ)-ын ээлжит чуулган болсон бөгөөд энэ үеэр манай улсыг хяналтаас гаргаж байгаагаа дуулгажээ. Өөрөөр хэлбэл, тус чуулганаар Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны стратегийн дутагдлуудаа зассан явдлыг өндрөөр үнэлж, өөрийн хяналтаас гаргах тухай шийдвэрийг гаргасан байна.

Манай орны хувьд гадаадын оффшор бүсэд хэдэн зуун сая долларыг алдаж байгааг байгааг таашгүй. Үүнтэй эвлэрч боломгүй байна.

Манай улсад оффшорын тухай танин мэдэхүйн үр дүнд гадаадад нуусан болон гарч одсон хөрөнгийг эгүүлэн авчрах талаар нийгэмд эсрэг байр суурь ажиглагдаж байна. Нэгдүгээрт, валют, татвар, эрүүгийн хариуцлагыг нэмэгдүүлэх замаар ял зэмлэлд тулгуурласан хүчний хандлага хоёрдугаарт, гадагш гарсан буюу нуусан хөрөнгийг буцаан татах эдийн засгийн өршөөл үзүүлэх.

Олон улс оффшортой тэмцэх тэмцлийг 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын үед эхэлсэн байна. 2009 онд Эдийн засгийн хөгжил хамтын ажиллагааны байгууллагаас анх оффшор зоны хар, цагаан, саарал гэж



нэрлэх жагсаалтыг гаргаж, G20 оролцогч улс орнууд хар болон саарал жагсаалтад орсон улс орнуудын эсрэг хөрөнгө оруулахыг хориглох хүртэл хамгийн хатуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай санал дэвшүүлсэн юм.

Манай улс 2013 “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийг шинэчлэн найруулж баталсан нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон. Энэ хуульд зааснаар Монгол банкны дэргэдэх “Санхүүгийн мэдээллийн алба нь ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар ижил түвшний, гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана” гэж заасан.

Эдүгээ гадаадын улс орнууд, тухайлбал АНУ, Европын холбооны санхүүгийн байгууллага нь оффшор капитал оролцсон бүхий л хэлцэлд хяналт тавьж байна. Зарим улс орон оффшор компаниудын үйл ажиллагаанаас үүдсэн татварын алдагдлыг бууруулах талаар тусгай хууль тогтоомж батлан хэрэгжүүлж байна.

Гэвч нэг улсын хуулийн болон санхүүгийн хяналтын байгууллага дангаараа оффшор бүсийн үйл ажиллагаанд хяналт тавих, хөрөнгө мөнгө үнэт зүйлс гадаадад дүрвэх урсгалыг хааж чадах эсэх асуудал эргэлзээтэй байна.

Гадаад улс орнуудын туршлагаас харахад хууль хяналтын байгууллагууд гэмт этгээдүүдийн хөрөнгө хил гарсны дараа хэсэг хугацааны дараа илрүүлдэг, гэмт этгээдийг барих, гарсан хөрөнгийг буцаан авчрах боломж бараг үгүй болсон байдаг.

Сүүлийн 10 жилд АНУ нь олон улсын гэмт явдалтай тэмцэх нэрийдлээр Швейцар дахь банкны нууцлалын институтыг ганхуулж чадсаны үр дүнд татвараас зайлсхийгчдийн талаарх мэдээллийг олж авах боломж нээгдсэн. Мөн 2010 онд “Татварын сахилгын тухай” хуулийг батлан хэрэгжүүлснээр оффшор бүс дэх гэмт явдалтай тэмцэхэд чухал ач холбогдолтой болсон. Мөн гадаадын улс орнуудтай гадаад улс дахь дансны холбогдолтой мэдээлэл солилцох гэрээ хэлцэл хийх ажлыг өрнүүлсэн байна. Герман улс нь эхний ээлжид Швейцарын банкинд данс нээсэн немцийн үйлчлүүлэгчдийн тухай мэдээллийг “хар зах” дээрээс худалдан авсан жишээ бий. Мөн Швейцар улстай Германаас Швейцарт урсан орсон хөрөнгөнөөс нэмэлт татвар авах тухай хэлцэл байгуулжээ⁸.

⁸ <http://ipopen.ru/registracija/offshory/borba-s-offshorami-2014.html>

Дүгнэлт хийхэд оффшор бүсэд үйлдэж байгаа гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох талаарх олон улсын хүчин чармайлт нь хүсэн хүлээсэн үр дүнд хүрээгүй байна. Олон улсын шинжээчдийн үзэж байгаагаар нэгдүгээрт, төрөөс хууль бусаар хөрөнгөжих, хөрөнгө гадагш урсахаас урьдчилан сэргийлэх; хоёрдугаарт, гэрээ хэлцлийн шинжилгээг нэвтрүүлэх; гуравдугаарт, хөрөнгө орлогын мэдүүлэгт нарийн хяналт тавих, хууль тогтоож зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хүчин чармайлт тавих шаардлагатай ажээ.

Иймд тухайн бүс нутагт үйлдэж байгаа гэмт хэргийг илрүүлэхэд хамтын ажиллагааны шинэ хэлбэр, арга замыг эрж хайхад хүргэж байна.

Орчин үеийн гэмт явдалтай тэмцэх мэдээлэл-техникийн чиглэл нь дунд оффшор бүсэд үйлдэх гэмт хэрэгтэй тэмцэх (тагнуулын аналитик болон компьютерын) цогц арга хэмжээг хэрэгжүүлэхийг онцлон тэмдэглэж байна.

Хууль сахиулах байгууллагуудын аналитик тагнуулын үйл ажиллагааны талаар 1998 онд Япон улсад болсон Шинжээчдийн олон улсын зөвлөгөөн дээр алсын зайнаас, өөрөөр хэлбэл компьютерийн сүлжээний хэрэгсэл аргын тусламжтайгаар компьютерийн тогтолцоонд эрэл хайгуул хийх эрх зүйн үндэс, арга зүйн талаар авч хэлэлцээд энэ чиглэлийн хэтийн төлөвийг сайшаасан юм.

Аналитик арга хэмжээний мөн чанар нь мэдэгдэж байгаа үйл баримтын мэдээлэл, болон олж авсан мэдээлэлд аналитик боловсруулалт хийж, тагнан турших объект буюу үзэгдлийн тухай шинэ мэдлэг олж авах"-ын тулд “мэдээллийн орчинд тагнан турших ажиллагаа”-г тодорхойлоход оршино.

Тагнуулын аналитик арга хэмжээ буюу аналитик тагнуул нь нууц хяналт, ажиглалтын төхөөрөмжийн болон нууц ажилтнуудын мэдээлэл, холбоо харилцааны бүхий л сувгаар олж авсан мэдээ, мөн түүнчлэн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нийтлэл, ярилцлага, сурвалжлага, статистикийн мэдээлэл, төрийн болон төрийн бус мэдээллийн тогтолцоо, сангийн мэдээллүүдийг судлахад чиглэнэ.

Мэдээллийн хувьсгал нь оператив сонирхол бүхий мэдээллүүдийг хуримтлуулах, боловсруулах хүрээнд нэхцөл байдлыг байнга хувьсган өөрчилж байна. Мэдээлэл-шинжилгээний ажиллагаа (аналитик тагнуул) нь зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх оператив зорилтыг хангахуйц гүйцэтгэх ажлын уламжлалт хүрээнд үл хязгаарлагдах шинэ боломжуудыг нээж байна.


Нэгдүгээрт, төрийн ба төрийн бус байгууллага, хувийн секторын янз бүрийн мэдээллийг агуулсан олон зуун цахим сан бий болсон, бий болж байгаа нь аналитик тагнуулын ажиллагааг шинэ агуулгаар баяжуулж байна. Хоёрдугаарт, янз бүрийн мэдээллүүдийг боловсруулах үр нөлөөтэй арга хэрэгслийг нэвтрүүлэн ашигласнаар аналитик тагнуулыг бие даасан нэг салбар болон хөгжих боломжийг олгож байна.


Мэдээллийн технологийн хөгжлийн хамгийн сүүлийн үеийн ололтыг ашиглах үндсэн дээр аналитик тагнуулын ажиллагаа явуулах нь Интерполоос үндэстэн дамжсан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл болон хөгжиж байна.


Объектуудын хоорондох нууц холбоог илрүүлэх, илэрсэн холбоогоор нь гэмт бүлэглэлүүдийн гишүүдийн гүйцэтгэх үүрэг, байр суурийг тодорхойлох аргуудыг аль ч улсын хууль сахиулах байгууллагын аналитик салбарууд эзэмшиж эхлээд байна.


Аналитик тагнуулын нэг бүрэлдэхүүн хэсэг болох компьютерийн тагнуул нь компьютерийн тогтолцоо, сүлжээнээс мэдээлэл эрж хайх, олж авахад чиглэнэ. Энэ арга хэмжээ нь компьютерийн аппарат –программын тусламжтайгаар логик ажилбар, арга хэрэгслийг ашиглах замаар хэрэгжинэ.


Оффшор санхүүгийн бүс дэх эдийн засгийн гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох болон зохион байгуулалтын олон улсын хамтын ажиллагааны салбарт эхний ээлжид:

 Оффшор бүсийг ашиглан татвараас зайлсхийх, мөнгө угаах, авлигын гэмт хэргийг нуун дарагдуулах гэмт хэргийг илрүүлэх хүрээнд худалдааны болон банкны нууцлалын зэрэглэлийг бууруулах;


 Санхүүгийн бэлэн гүйлгээг аль болох хязгаарлах болон гаалийн хилээр бэлэн мөнгө гарах нүх сүвийг хаах;

 Сэжигтэй гүйлгээнд хийх хяналтыг сайжруулах;


 Монгол Улсын татварын хуулиар зарим төрлийн татвар төлөгч нар оффшор компани, дансыг заавал заавал мэдүүлэх журмыг тогтоох;

 Олон улсын, бүс нутгийн болон улс хоорондын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг улам хөгжүүлж, практик ажиллагаанд дэвшин орох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

 Мэдээллийг илрүүлэх, солилцох талаар улс хоорондын гэрээ хэлцэл хийх;

 Монгол улсын эдийн засгийн чөлөөт бүсүүдэд оффшор маягийн татварын

орчин бий болгох.

 Эрх зүй, зохион байгуулалтын эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд иргэний, эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох шаардлага урган гарна.



МАНСУУРУУЛАХ БОЛОН СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ЭРГЭЛТЭНД ТӨРИЙН МОНИТОРИНГИЙГ ТОГТООХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗАРИМ АРГА ЗАМУУД

Э.БОЛОР-ЭРДЭНЭ

Цагдаагийн байгууллага мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх ажилд тодорхой стратеги боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай болжээ.

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийг барьж хорих, ял шийтгэхээс илүү тэднээр дамжуулан энэ төрлийн бодисын эргэлтэнд хяналт тавих, төрийн мониторингийг нэвтрүүлэх чиглэл рүү мөрдөн шалгах ажиллагааны арга барилыг хандуулах шаардлагатай.

Тус төвөөс мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэргүүдийн статистик мэдээ, Сургалтын төвийн 2016-2017 оны сургалтын хөтөлбөр, Эрүүгийн цагдаагийн газрын Хар тамхитай тэмцэх хэлтсийн 2014, 2015 оны тайлангаас сургалт зохион байгуулсан болон хураагдсан мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэсэгт мөн ОХУ¹, АНУ², Зүүн Өмнөд Азийн Вьетнам³, Лаос⁴, Тайланд⁵, Малайз⁶, Индонез⁷ болон далайн

¹ Ерөнхийлөгч Д.Медведевийн 1998 оны стратеги батлах тухай зарилагаар хар тамхины эргэлтэнд төрийн мониторингийг нэвтрүүлэх чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудыг чиглүүлж ажиллах болжээ.

² http://www.popcenter.org/problems/drugdealing_apartments/PDFs/fcdps89.pdf

³ https://www.unodc.org/documents/southeastasiaandpacific//2012/05/ats-report-vietnam/Natl_Committee_on_Aids-ATS_prevention.pdf

⁴ <http://www.state.gov/j/inl/rls/nrcrpt/2015/vol1/238988.htm>

⁵ <https://www.brookings.edu/wp-content/uploads/2016/07/WindleThailand-final.pdf>

⁶ <http://www.adk.gov.my/web/english/drug-policy>



⁷ <http://jakartaglobe.beritasatu.com/news/indonesia-calls-new-strategy-war-drugs/>

орнууд болох Шинэ Зеланд⁸, Австрали⁹ зэрэг орнуудын мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх төрийн бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийлээ.

Монгол Улсын Засгийн газар 2000 онд “Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батласан ч хэрэгжилт, үр дүн нь хангалтгүй байгаа талаар судлаачид шүүмжлэлтэй¹⁰ ханддаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн зарилгаар 2012 онд харт амхитайтэмцэхчигүүрэгбүхийҮндэснийхор ообайгуулах, тэмцлийгэрчимжүүлэх, шинэ хөтөлбөрболовсруулахчиглэлбүхийзарлиг гаргаж байсан ч энэ байгууллага ямар эрх хэмжээтэй, үүрэг хариуцлагатай байх, ямар үйл ажиллагаа явуулж, бодистой ямар үр дүнд хүрсэн эсэх нь тодорхой бус байна.

Манай улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодистой холбоотой хэрэг 2002 онд 5 хүн 2 хэрэгт холбогдон шалгагдсан статистик үзүүлэлтээс 2016 оны эхний хагас жилд 120 хүн 147 үйлдэлтэй 52 хэрэгт холбогдон шалгагдах хүртэл жил бүр дунджаар 9 хэрэг, 35 хүнээр өссөөр байгааг бүртгэгдсэн гэмт хэргийн статистик¹¹ мэдээллээс харж болно.



Сүүлийн 3 жил буюу 2013-2015 онуудад цагдаагийн байгууллагад шалгагдсан энэ төрлийн гэмт хэрэг болон сэжигтэн, яллагдагчийн тоо ч өссөн үзүүлэлттэй байна.

⁸ <http://www.health.govt.nz/publication/national-drug-policy-2015-2020>

⁹ [http://www.nationaldrugstrategy.gov.au/internet/drugstrategy/publishing.nsf/Content/DB4076D49F13309FCA257854007BAF30/\\$File/nds2015.pdf](http://www.nationaldrugstrategy.gov.au/internet/drugstrategy/publishing.nsf/Content/DB4076D49F13309FCA257854007BAF30/$File/nds2015.pdf)


¹⁰ <http://www.bataar.mn/10042918>

¹¹ ЭЦГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсээс 2002-2016 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан статистик мэдээ



Хураагдсан мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис 2014 онд нийт дүнгээрээ 13997 грамм байсан бол 2015 онд 10177 байгаа нь буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа ч чанарын хувьд өссөн үзүүлэлттэй байгааг дараах байдлаар тайлбарлаж болно. Синтетик буюу хүчтэй үйлчилгээтэй сэтгэцэд нөлөөтэй бодис болох метамфетаминь төрлийн мөс хэмээх бодис 2014 онд 141 грамм хураагдсаж байсан бол 2015 онд 344.1 грамм, 2014 онд боловсруулсан зэрлэг олс буюу Гашиш 15 грамм хураагдаж байсан бол 2015 онд 24.5 грамм хураагдсан зэрэг чанарын хувьд нэмэгдсэн.

Түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэгт 2010 оноос хойш ял шийтгэгдсэн 49 ялтан байгаа



бөгөөд эдгээрийн 59 хувь буюу 29 ялтан 5-аас доош жил 6 сараас 3.6 жил хүртлэх (3.5 жилээр хорих ял шийтгэгдсэн 1, 3.6 жилээр хорих ял шийтгэгдсэн 1) хугацаагаар хорих ял шийтгэгдсэн ялтанууд байна.


Үүнээс гадна одоогийн байдлаар Эрүүгийн цагдаагийн газарт хар тамхины хэрэгээр шалгагдаж буй 35 сэжигтэнүүд бүгд хууль бусаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис олж авсан, хадгалсан, хэрэглэсэн хүмүүс, өөрөөр хэлбэл хөнгөн буюу хүндэвтэр хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан болсон, хүнд болон онц хүнд гэмт хэрэгтнүүдийг илэрүүлэх, үндэсний болон олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээг хянах, төрийн мониторингийг нэвтрүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагтайг илтгэнэ.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт явдалд хандах хандлагаа өөрчилж түүнийг зөвхөн гэмт хэрэг гэж харахаас илүүтэй юуны түрүүнд шийдвэрлэвэл зохих нийгмийн муу зуршил/өвчлөл гэж харах нь асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломжийг бий болгоно.

Энэ талаар бид бусад туршлага бүхий орнуудын жишгийг дагах нь зүйтэй. Тухайлбал 1971 оны 7 дугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч Р.Никсон Хар тамхи,

мансууруулах бодисын эсрэг дайн зарласан бөгөөд түүнээс хойш тус улсад энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгсдийн тоо огцом өссөн боловч асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй.

АНУ-ын Хар тамхины эсрэг зарласан дайны үр дүн



Энэ нь үр дүнтэй байж чадаагүйгээр барахгүй нийт хүн амын дунд эзлэх хоригдлын тоогоороо дэлхийд тэргүүлэх улс болгосон тул тус улсын засгийн газар энэ байдлаа хүлээн зөвшөөрч дэлхийн хамтын нийгэмлэгт дараах зөвлөмжүүдийг өгсөн байдаг.

Тэдний хууль сахиулах ажиллагаанд санал болгож буй стратеги¹² нь:

1. Засгийн газар хууль сахиулах байгууллагуудын хэдэн хүнийг баривчилж, ямар ял шийтгэл оногдуулсан гэдгээр нь энэ төрлийн гэмт явдалтай тэмцэж буй ажлыг дүгнэх биш энэ төрлийн бодисонд донтсон болон хараат болсон хүмүүсийг эмчлэх, нийгэмшүүлэх, урьдчилан сэргийлэх, иргэний болон хууль сахиулах алба хаагчдыг сурган дадлагжуулах талаар зарцуулж буй мөнгөний харьцааг өөрчлөх шаардалагтай. Өөрөөр хэлбэл төрөөс энэ төрлийн гэмт явдалтай тэмцэхэд зарцуулж буй нийт мөнгөний 2/3 нь мөрдөн шалгах, ял шийтгэл оногдуулахад зарцуулагдаж байдаг бол үлдэх 1/3-г урьдчилан сэргийлэх, хүмүүсийг мэдлэгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, эмчилгээний зардалд зарцуулагддаг гэсэн олон улсын судалгаа байдаг.

2. Эрүүл мэндийн үзлэг, оношлогоо, үйлчилгээг бодитоор бий болгож, хөгжүүлэх. Энэ нь энэ төрлийн бодисонд автсан, донтсон хүмүүсийг эмчлэх зорилгоор тухайн бодисыг олж авах, хэрэглэх явдлыг хялбарчилж, түүнд тавих хяналтыг сайжруулах, сэтгэл засал, сэтгэл зүйн эмчилгээ, зөвөлгөө өгөх явдлыг хөхүүлэн дэмжих, донтгогсод болон

12 http://www.popcenter.org/problems/drugdealing_apartments/PDFs/fcdps89.pdf



хараат болсон хүмүүсийг дорд үзэх, үзэн ядах болон төвөгшөөх сэтгэлээр бус тэдэнд үнэн сэтгэлээсээ туслах сэтгэл зүйгээр хандах явдал чухал бөгөөд үүний хамгийн гол шалгуур нь хүмүүсийн эмчилгээ, зөвөлгөө авах сайн дурын сэтгэл зүйг төлөвшүүлэх явдал хамаарна.

3. Хүүхэд залуучуудад мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын талаарх үнэн бодит мэдээллийг хүртээмжтэй түгээх. Үүний тулд хууль сахиулах байгууллага болон хамтран ажиллагч бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын хүчин чармайлт чухал бөгөөд мансууралтай тэмцэх нь юуны өмнө цагдаагийн байгууллагын дангаараа хүлээх үүрэг биш гэдэг хандлагыг төлөвшүүлэх ёстой. Төрөөс залуучууд, хүүхдүүдийн чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх, тэдэнд амьдарлын зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх талаар хичээлээс гадуурх дугуйлан, секцүүд бий болгох, авьяас чадварыг хөгжүүлэх аливаа сургалт семинар зохион байгуулах, халамжлан хүмүүжүүлэх хөтөлбөр, зуны цагт ажил хөдөлмөр эрхэлэх явдлыг дэмжих чиглэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

4. Хууль сахиулах байгууллагын хүч хэрэгсэлийг тухайн гэмт явдлын үндсэн шалтгаан болсон хүн, байгууллага, үйл явдалд чиглүүлж ажиллуулах шаардлагатай. Нийгмийн хор аюулаар харьцангуй багатай, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар олж авсан хэрэглэсэн хүмүүсийг мөрдөн шалгах нь хууль сахиулах байгууллагуудын хувьд цаг хугацаа алдаж, шоронд ял эдлэгсдийн тоог нэмэгдүүлэхээс өөр тустай зүйлгүй байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатай.

5. Олон улсын хар тамхины эргэлтийг хянах, төрийн мониторингийг нэвтрүүлэх ажилд иргэний байгууллага болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих явдал чухал бөгөөд дотоодын эрэлтийг багасгах замаар гадаадаас нийлүүлэгдэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын урсгалыг хязгаарлах боломжтой. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх шаардлагатай гэжээ.

Дүгнэлт

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодис нь дэлхий нийтийн асуудал бөгөөд дэлхийн улс гүрнүүдийн асуудлыг

шийдвэрлэх арга зам нь ижил төстэй байгаагаар тайлбарлагдана. Тэдгээрийг нэгтгэн дүгнэхэд:

1. Хамтын ажиллагаа
2. Хяналт тавих,
3. Эмчлэх, нийгэмшүүлэх,
4. Мэдлэг, боловсрол гэсэн үндсэн ойлголтуудыг тусгажээ гэж үзэж болохоор байна.

Хамтын ажиллагаа. Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлж, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хэв журам хамгаалах нь дан ганц цагдаагийн байгууллагын үүрэг хариуцлага мэтээр ойлгож ирсэн буруу хандлага манай нийгэмд амь бөхтэй оршоор байна.

Хуулийн үзэл баримтлал ч үүнийг батласан мэт, тухайлбал, Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага мөн¹³ гэж тодорхойлжээ.

Энэ ойлголт, хандлагаас үүдэлтэй цагдаагийн байгууллагын хувьд хамтын ажиллагааны түвшин өндөр биш улмаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх чиглэлээр үүрэг хүлээж ажиллаж буй цагдаагийн байгууллагын нэгжийн алба хаагчид болон энэ төрлийн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьж буй прокуроруудаас өөр үндэсний мэргэжилтэн гэхээр хүний нөөцгүй байгаа нь тэрхүү хандлагыг өөрчлөх зайлшгүй шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Үндсэн зүй тогтолын хувьд энэ нь бүх нийтийн үүрэг байх бөгөөд цагдаагийн байгууллага тэргүүлэх чиг үүрэгтэй оролцох ёстой. Хамтын ажиллагааны эхлэл эндээс тавигдах учиртай.

Хоёрдугаарт, төрийн ба төрийн бус байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцдаа мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх чиглэлд ямар үүрэг, хариуцлага хүлээж, ямар эрх эдлэх, аль байгууллага нь удирдан зохион байгуулж ажиллах, энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хүмүүст өршөөл уучлал үзүүлэх нь зөв эсэхийг нэг мөр шийдвэрлэсэн бодлогын баримт бичиг зайлшгүй шаардлагатай.

Гуравдугаарт, дотооддоо хамтын ажиллагааг сайжруулахын тулд хууль сахиулах болон шүүх, прокурорын байгууллагууд энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр шийдвэрлэх

¹³Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйл.



чиглэлээр уулзалт, семинарыг тогтмол зохион байгуулж нэгдсэн ойлголтонд хүрэх шаардлагатай. Үүнд цагдаагийн байгууллага идэвхитэй оролцож бусад байгууллагуудад хандаж уриалга, санаачилга гаргах нь зүйтэй.

Хяналт тавих. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэж буй өнөөгийн хууль сахиулах ажиллагааны практик оновчтой арга барил мөн үү? гэдэг асуултанд юуны өмнө хариулт хайх ёстой. Олон улсын практикт нэвтэрсэн хамгийн сайн туршлага бол тэдэнд хяналт тавих, төрийн мониторингийг нэвтрүүлэх явдал мөн.

Энэ ажилд цагдаагийн байгууллага тэргүүлэх чиг үүрэгтэй оролцох ёстой. Хяналтыг ил, далд 2 хэлбэрээр тавьж болно. Цагдаагийн байгууллага эрүүгийн тагнуулын ажлын түвшинг ахиулж, алба хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах, эрүүгийн тагнуулын ажлын сүлжээг энэ төрлийн бодис хууль бусаар олж авсан, хадгалсан болон хэрэглэсэн хүмүүсээр дамжуулж өрөгжүүлэх, гүйцэтгэх ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар далд хяналтын тогтолцоог бэхжүүлж болно.

Нөгөөтэйгүүр ил хяналтын тогтолцоог мөн далд хяналтын тогтолцоотой зэрэг бэхжих ёстой. Үүнийг тулд орчин үеийн цагдаагийн шинжлэх ухаанд номлож буй, бусад ороны цагдаагийн байгууллагад өргөнөөр ашиглаж буй олон нийтэд түшиглэсэн, мэдээлэлд үндэслэгдсэн цагдаагийн үйл ажиллагаа зэрэг арга барилыг үндсэн мөн чанарынх нь хувьд үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

Цагдаагийн албаны тухай хуулинд “олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа” хэмээх зохицуулалтыг хийсэн боловч “олон нийтийн цагдаагийн ажилтан” гэх нэр томъёог хуульчилж энэ хүмүүст гэмт хэрэг, зөрчилд холбогдогсдыг саатуулах, цагдаагийн байгууллагад хүргэх, торгох, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх олгосон зэрэг хууль сахиулах цагдаагийн алба хаагчдын үүргийг хүлээлгэсэн нь цагдаагийн дэд албан хаагчдыг бий болгох нөхцөл бүрдсэн. Энэ нь олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны ажиллах үндсэн механизм биш.

Энэ нь олон нийтийн хүчин туслалцааг авахын тулд тэдэнд цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам

сахиулах хандлагыг бий болгон, цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах сэдлийг төлөвшүүлэх цагдаагийн нийт алба хаагчдын үйл ажиллагааны зарчим байх үндсэн агуулгыг алдагдуулжээ. Цагдаагийн байгууллага хөрөнгө санхүү, хүний нөөцийн хувьд улсын нийт нутаг дэвсгэрт хүрч, үйлчлэх боломжгүй, харин улсын өнцөг булан бүрт хүмүүс амьдарч аж, төрж байгаа тул тэдний хүч, туслалцааг авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах урлагт алба хаагчид суралцах нь шийдвэрлэвэл зохих асуудлын нэг мөн.

Эмчлэх, нийгэмшүүлэх. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодисын хараат болсон, донтсон хүмүүсийг эмчлэх, дахин нийгэмшүүлэх нь энэ төрлийн хорт үзэгдэлтэй тэмцэх ажилд гол үүрэг гүйцэтгэх ёстой.

Нийгмийн энэ үзэгдлийг гэмт явдал гэж үзэх хандлагаа бид өөрчлөх зайлшгүй шаардлагатайг эндээс харж болно. Сэтгэцийн эмгэг судлалын төв болон Наркологийн үндэсний төвүүд үйл ажиллагаагаа явуулж байгаа ч архинд донтсон болон сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүсийг эмчлэх талаар мэргэжилтэнүүдээ бэлтгэх, зохих туршлага хуримтлуулсан ч мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодисонд донтсон, түүний хараат болсон хүмүүсийг эмчлэх, дахин нийгэмшүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, эмнэлгийн ажилтан, сэтгэл зүйч байхгүй, тоног төхөөрөмж, нөхцөл байдлын хувьд ч боломж хомс байна.

Тиймээс юуны өмнө цагдаагийн байгууллага харьяандаа иргэдэд үйлчлэх сэтгэл зүйн төвүүдийг ажиллуулах, түүнтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээг тогтоож өгөх нь үр дүнтэй байж болох юм. Дэлхийн бусад улсууд, тухайлбал Шинэ Зеландын цагдаагийн байгууллага өөрийн бүтэцийн нэгждээ хохирогчид дэмжлэг үзүүлэх нэгж ажиллуулж тэнд ажиллагсад цагдаагийн бус мэргэшсэн сэтгэл зүйч, эрх зүйч, нийгмийн ажилтанууд үүрэг гүйцэтгэж байна. Цагдаагийн энэ нэгжид туслалцаа авахаар хандсан иргэдийн өгсөн мэдээллийг хууль сахиулах үйл ажиллагаанд шууд ашиглахгүй байх зарчимтай. Тиймээс манай улсад иргэдэд үйлчлэх сэтгэл зүйн төвүүд ажиллуулахаас өмнө цагдаагийн алба хаагчдыг мэдээллийн аюулгүй байдлыг хангах урлагт сурган дадлагуулах шаардлагатай.

Мэдлэг, боловсрол. Юуны өмнө төрийн



холбогдох байгууллагын алба хаагчдыг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой бодит мэдээллээр хангаж, тэдэнд чиглэсэн зорилтот сургалтуудыг тогтмол зохион байгуулах шаардлагатай.

Цагдаагийн байгууллагын хувьд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрөө эргэж харах шаардлагатай байна.

Тухайлбал 2016 оны ЦЕГ-ын сургалтын хөтөлбөрт “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай ойлголт” хэмээх сэдэвтэй 2 цагийн сургалт зохион байгуулахаар тусгагдсан¹⁴ нь хангалтгүй. Хэдийгээр ЭЦГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсийн алба хаагчид прокурорын байгууллага, Иргэдийг хар тамхинаас хамгаалах төрийн бус байгууллагатай хамтарч цагдаагийн бусад алба хаагчид болон төрийн бусад байгууллага, сургуулийн сурагч, оюутануудад энэ төрлийн бодисын хор нөлөө, урьдчилан сэргийлэх арга зам, эрх зүйн зохицуулалтын талаар 15 удаагийн сургалтыг зохион байгуулсан ч энэ нь тухайн үеийн нөхцөл байдлаас үүдэлтэй, тохиолдлын байдлаар хийгдсэн байна.

Энэ нь сургалт явуулах ажил нь тодорхой бодлого чиглэл, зохион байгуулалтгүй, сэдэв агуулга нь хоорондын уялдаа холбоогүй явагдах үндэслэл болох бөгөөд мэдлэг олгохоос илүүтэй мэдээлэл түгээх хандлагатай болжээ гэж үзэж байна.

НҮБ-аас боловсорлыг мэдрэмжийн түвшинд олгодог болох уриалга гаргаж байсан. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх талаар алба хаагчдад мэргэшүүлэхийн тулд боловсорлыг мэдлэг, чадварын түвшинд бус мэдрэмжийн түвшинд боловсрол олгох явдал шийдвэрлэх асуудлын тоонд зүй ёсоор орно.

Нөгөөтэйгүүр олон нийтэд чиглэсэн иргэний боловсорлыг шинжлэх ухааны үндэстэй, цогцоор нь олгохгүй, зөвхөн мэдээлэл дамжуулах төдийгөөр хязгаарлах нь зарим талаараа эсрэг сурталчилгаа болох магадлалыг нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодисын талаар мэддэггүй байсан хэн нэгэн сургалтын дараагаар мэдлэгтэй болж түүнийг олж авах, хэрэглэх хүсэл эрмэлзэл

төрөх магадлалтайг судалгааны дүн¹⁵ харуулж байна.

¹⁴ЦЕГ-ын Сургалтын төвийн 2016 оны сургалтын төлөвлөгөөнөөс

¹⁵ 2013 оны 2 дугаар сард МБГ-ын 7 дугаар хэлтсийн алба хаагчдын хүүхэд залуучуудын дунд хийсэн социологийн судалгаагаар 5 оюутан сурагчдын 1 нь мансууруулах бодисыг ямар нэг хэмжээгээр хэрэглэж үзсэн 3 хүний нэг нь хэрэглэж үзэх сонирхолтойгоо илэрхийлж байсан.



ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

ISSUES IN IMPROVING WITNESS AND VICTIM PROTECTION SCHEM AND LEGAL FRAMEWORK

Г.БАТТУЛГА

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч, хошууч

Товч агуулга: Барууны гэгдэх өндөр хөгжилтэй орнуудын эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг судлан үзвэл гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх¹ зорилгоор бие даасан зохицуулалтыг бий болгож, үүний үр дүнд гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо бүрэлдсэн байна.

Энэхүү илтгэлээр манай улсад шинээр бүрэлдэн бий болж буй гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоо, практикт тулгамдаж буй асуудлыг хөндөн олон улсын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичиг, бусад орны гэрч, хохирогч хамгаалах тогтолцоо, эрх зүйн зохицуулалттай харьцуулан өөрийн үзэл бодлоо илэрхийллээ.

Abstract: Most western countries have integrated systems to provide protection and assistance to victims and witnesses. Studies show those countries have established self-regulation in order to protect and assist victims and

¹ Олон улсын түвшинд хохирогчид дэмжлэг (victim support), гэрчид хамгаалал (witness protection) гэсэн үндсэн зарчим үйлчилдэг. АНУ, Англи, Герман, Австрали, Итали, Канад, Норвеги, Испани, Румын зэрэг 40 гаруй орон үүнээс Азийн 10 гаруй оронд гэрч, хохирогч хамгаалах бие даасан байгууллага, эрх зүйн зохицуулалт бүрэлдэн олон арван хөтөлбөр хэрэгжүүлээд байна.

Эх сурвалж: Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime. UN. New York 2008, page 7-15, 97-102. <https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf>

witnesses of crime.

This paper aims to compare newly formed scheme to protect the victims and witnesses in Mongolia, legal regulations and issues with legal documents by international organizations and witness and victim protection regulations in other countries.

Түлхүүр үгс: Гэрч хамгаалах хөтөлбөр, гэрч хамгаалах тогтолцоо, гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа.

Key words: Witness protection program, Witness protection scheme, Victim and Witness assistance.

ҮНДСЭН ХЭСЭГ

НҮБ-н Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргаснаар олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна. Уг тунхаглалын 6 дугаар зүйлд “Гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”—ыг улсуудад уриалсан².

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 58/4 дугаар тогтоолоор баталсан Авилгалын эсрэг конвенци³, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 55/25 дугаар тогтоолоор баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцид⁴ “Оролцогч улс бүр энэхүү конвенцид тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон, буюу айлган сүрдүүлгээс хамгаалах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, боломжийн хэмжээнд авна. Оролцогч улс бүр энэхүү конвенцид хамаарах гэмт хэрэг, ялангуяа өшөө авах буюу заналхийллээс хохирогчийг хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх зохих арга хэмжээ авна” гэж тус тус үүрэг хүлээлгэсэн байна.

Монгол улсын нэгдэн орсон дээрх **конвенцид зааснаар оролцогч улсуудад** ² М,Ичинноров. “Гэрч, хохирогчийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах тогтолцоо бий болж байгаа нь эрх зүйн шинэтгэлийн чухал алхам мөн” Хууль сахиулахын инноваци олон улсын эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан илтгэл <http://ichinnorovm.blogspot.com/2014/11/blog-post.html>

³ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэгдэн гарсан. 2005. 855-888 дахь тал.

⁴ Монгол улс 2008 оны 5-р сарын 25-ны өдөр гарын үсэг зурж, 2008 оны 6-р сарын 26-ны өдөр соёрхон баталсан.



гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгож, Монгол Улсын Үндсэн хуулийн 10-р зүйлд заасан Монгол Улсын Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг.

Олон улсын байгууллагын гаргасан статистикийн мэдээнээс үзэхэд дэлхий дээр дөрвөн гэрчийн нэг нь байцаан шийтгэх ажиллагааны явцад өөрийн мэдүүлгээс буцдаг байна⁵. Тиймээс гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад хэргийн бодит үнэнийг тогтоох, түргэн шуурхай илрүүлэхэд бэрхшээл учирах явдал түгээмэл тохиолддог.

Үндсэн хуулийн үзэл баримтлал, түүний дагуу хийж буй төрийн байгууллын болон эрх зүйн шинэтгэл сүүлийн үед эрчимтэй хийгдэж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д " төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй" гэж заасан. Үндсэн хуулийн энэхүү заалт, төр иргэдийнхээ өмнө хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс УИХ-ын 2012 оны 37-р тогтоолоор батлагдсан "Монгол улсын Засгийн галзын 2012-2016 оны хөтөлбөр"-т гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэнэ гэжээ.

Судлаачдын үзэж байгаагаар манай улсад "жилд дунджаар 1 эрүүгийн хэрэгт хамгийн багаар тооцоход 3 гэрч, 1 хохирогч оролцдог гэж үзвэл жилд хамгийн багаар бодоход гэмт хэргийн улмаас хохирсон 5432 хохирогч, 16296 гэрч байдаг байна. Үүнээс хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон 1199 хохирогч, 3597 гэрчийг хамгаалах"⁶ шаардлагатай гэж үзсэн бол НҮБ, "Хохирогчийн эрхийн судалгааны төв" ТББ-аас хийсэн судалгаагаар гэрч, хохирогчид хамгаалалтад байдаггүйгээс амиа хорлох, гэрчийн мэдүүлгээс буцах, өөрөө хэрэгтэн болох тохиолдол олон байгааг тогтоосон. Жилд дунджаар 3000-5000 гэрч, хохирогч аюулгүй байдлын хамгаалалт авах шаардлага байгаа⁷ гэсэн судалгаагаа байдаг.

Эдгээр хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн 2013 оны 7 сарын 5-ны өдөр "Гэрч, хохирогчийг хамгаалах

тухай" хууль батлагдсан. Уг хууль батлагдсанаар гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоож, гэрч хохирогч хамгаалах тогтолцоо бүрдэх үндэс суурь нь тавигдсан юм. Хууль батлагдахаас өмнө гэрч, хохирогчийг хамгаалдаг нэгдсэн тогтолцоо байгаагүй билээ. Харин энэхүү тогтолцоо бий болсон нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж буй чухал алхам юм.

Монгол Улсын их хурлаас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Тахарын албаны тухай хуулиудыг батлан гаргаж Тахарын албаны тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон явдал нь хөндөн бичиж буй сэдвийн эрх зүйн зохицуулалт олон улсад мөрдөгдөж буй жишигт ойртож очсон гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль батлагдаж, түүнийг хэрэгжүүлэх тусгай нэгж албыг байгуулснаар Монгол улс хүний эрхийг хангах чиглэлээр олон улсын гэрээгээр хүлээнсэн үүргээ биелүүлж, Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрэлдэж эхэлсэн.

Мэдээж уг хууль хэрэгжиж ирсэн сүүлийн 2 жилийн хугацаанд практикт гарч буй нөхцөл байдалд нийцүүлэн эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгох шаардлага урган гарч байгаа бөгөөд цаашид гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

Бодит байдал ийм байхад сүүлийн үед шинээр бүрэлдэн бий болж буй гэрч, хохирогч хамгаалах бие даасан тогтолцоог тарааж, татан буулгах талаар яригдах болсон нь оновчтой шийдвэр биш гэж үзэж байна. Хохирогчийг хамгаалах тогтолцоо өмнө нь байгаагүйн улмаас хохирсон дээрээ дахин хохироод үлддэг байсан. Ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах тал дээр тодорхой ахиц гарч байсныг мэргэжлийн хүмүүс дурддаг. Энэ талаар "Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" ТББ-ын захирал Д.Энхжаргал Тахрын албыг татан буулгахыг эсэргүүцэн хийсэн тайлбартай санал нэг байна. Тэрээр "Хэрвээ гэмт хэргийн хохирогч болсон бол, тэгээд айдас, дарамтаас хамгаалах шаардлагатай тулгарч байсан бол энэ шийдвэрийг гаргаж байгаа хүмүүс, олон нийт асуудлыг арай өөрөөр харах байсан. Хармсалтай нь ийм хүмүүсийг ингэж хамгаалсан гэж олон нийтэд мэдэгдэх, тайлагнах боломжгүй байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь насаа алдах эрсдэлд хүрсэн болон зохион

⁵ Т.Оюунчимэг.Гэрч. УБ., 2014. 33 дахь тал.

⁶ М.Ичинноров. Гэрч хохирогчийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах тогтолцоо бий болж байгаа нь эрх зүйн шинэтгэлийн чухал алхам мөн. "Хууль сахиулахын инноваци" олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл. <http://ichinnorovm.blogspot.com/2014/11/blog-post.html>

⁷ Хохирогчийн эрхийн судалгааны төв. UNDP. "Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал" судалгааны тайлан. 2010.



байгуулалттай гэмт хэргийн хохирогчийг бодитоор хамгаалж байсан олон жишээг би мэднэ. Даанч тэр хүмүүсийн нэр төр, хувийн нууцлалыг хамгаалах үүднээс ил болгож дэлгэх боломжгүй юм” гэжээ.

Мөн энэ талаар Тахрын албанаас “Тахарын албанд хамгаалалт хүсэн хандаж байгаа иргэдийн тоо жил ирэх тусам өсч, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүний аюулгүй байдлыг хамгаалах хэрэгцээ шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байгаа”⁸ гэж мэдэгдсэн. Үүнийг улс орны нийгэм эдийн засгийн байдал, үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо өссөн,⁹ мөн иргэдийн хууль эрх зүйн болон хүний эрхийн талаарх мэдлэг дээшилсэн нөгөө талаар гэрч, хохирогчийг хамгаалдаг тэдэнд туслалцаа үзүүлдэг тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага бий болсонтой холбон тайлбарлаж болох юм.

Гэтэл өнгөрсөн хавар Тахарын чиг үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлнэ гэж яригдаж эхэлсэн. Харин одоо энэ чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлэхээр төлөвлөж байна. Энэ талаар хууль зүйн сайд асан Х.Тэмүүжин хэлэхдээ “цагдаагийн байгууллага байх ёстой орон тооноосоо 1250 албан хаагчаар дутуу байгаа. Төсөв байхгүй учраас орон тоогоо гүйцээж чадахгүй байна. Ийм байхад яаж цагдаагийн байгууллага гэрч хохирогчийг хамгаалах вэ? Тахарын алба байгуулснаар гэр бүлийн хүрээнд гардаг хүчирхийлэл багассан. Гэрч, хохирогчид аюулгүй байдлыг маань хангачихсан юм байна гээд хэргээ үнэн зөвөөр мэдүүлэх болсон”¹⁰ гэжээ. Ийм байхад цагдаагийн байгууллага гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангаж, тэдэнд туслалцаа үзүүлэх ажлын үр нөлөөтэй зохион байгуулж чадах уу? гэсэн асуулт зүй ёсоор урган гарна.

Өнөөдөр хуульч, судлаачдын дунд энэ тогтолцоог татан буулгах нь зөв буруу гэсэн үзэл бодлын маргаан өрнөж байна. Асуудлын гол нь гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага, шинээр бүрэлдэн бий болж буй тогтолцоог татан буулгаж, тухайн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид өөрчлөлт оруулах нь зөв, буруу

⁸ И.Даваажамъяан. /Гэрч, хохирогчийг хамгаалах газрын дарга/. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн байдал, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зарим асуудал. Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл. 38 дахь тал.

⁹ Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээлэлд 2015 онд улсын хэмжээнд 27757 гэмт хэрэг үйлдэгдсэн нь урд оноос 439 гэмт хэргээр буюу 1.6% өссөн, үүнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1356 бүртгэгдсэн нь өмнөх онохоос 280 хэргээр буюу 26% өссөн үзүүлэлттэй байна.

¹⁰ <http://www.polit.mn/content/mail/54933.htm>

эсэхээс үл хамаараад хуулийн хэрэгжилт, гарах үр дагавар, нөхцөл байдлыг үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл нөхцөл байдлыг бүрэн дүүрэн дүгнэж бодит судалгаан дээр үндэслэн хэлэлцэн шийдэлд хүрэх нь зүйтэй бөгөөд хэн нэгэн, хэсэг бүлэг хүмүүсийн сэтгэл хөдлөл, таамгаар энэ асуудлыг шийдэх нь өрөөсгөл билээ. Нөгөө талаасаа эрх зүйн шинэ зохицуулалт, шинэ тогтолцоо, шинэ бүтэц бий болгогчоод 3 жил хүрэхгүй хугацаанд уг тогтолцоог өөрчлөх нь хууль дээдлэх ёсонд харш билээ. Хуулийн институт тогтвортой үйлчилж байж үр дүн нь гарна.

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

Гэрч, хохирогчийг хамгаалах асуудал олон улсын шинж чанартай болохын хэрээр гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгохыг шаардаж байна. НҮБ болон олон улсын бусад байгууллагуудаас батлан гаргасан баримт бичгүүдийн үзэл санааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улс орнууд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар ихээхэн анхаарах болсон. Ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд энэ нь ихээхэн ач холбогдолтой бөгөөд барууны гэгдэх өндөр хөгжилтэй улсууд тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, тусгайлсан хууль тогтоомжийг батлан гаргах замаар гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бий болгосон байна¹¹. Ийм тогтолцоог бүрдүүлэн гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй зарим улс орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтыг авч үзье.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс.

ХБНГУ Гэрч хамгаалах тухай бие даасан хуулиа 1998 онд баталсан юм. Уг хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө практикт гэрчийг хамгаалах тодорхой арга хэмжээнүүдийг авч, багагүй хөрөнгө зарсан байна. Гэрчийн аюулгүй байдлыг хангахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цагдаагийн байгууллага болон хууль сахиулах байгууллагууд хамтран Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх болон бусад хууль, эрх зүйн актаар зохицуулан үйл ажиллагааг зохион байгуулж байжээ. Гэсэн хэдий ч Германы мэргэжилтнүүд асуудлыг бүх талаас нь судлалж үзээд эдгээр хууль тогтоомжийн хүрээнд гэрчийг бүрэн хамгаалж чадахгүй байна гэсэн дүгнэлтэнд

¹¹ Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime. UN. New York 2008, page 7-15, 97-102. <https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf>



хүрчээ. Мөн Шүүхийн шийдвэр гарсны дараа ч өс хонзон санаж гэрчийг айлган сүрдүүлэх явдал гарсаар байв.

Энэ нь тусдаа бие даасан хууль боловсруулах үндэслэл болсон гэж үздэг. Тухайлбал уг хуулиар гэрчийг хамгаалах байгууллага байгуулах; гэрчийн төдийгүй түүний гэр бүл, хамаатан садан, ойр дотны хүйүүсийг хамгаалах арга хэмжээг авах; аливаа мөрдлөгөөс хувийн шинжтэй мэдээ, мэдээллийг хамгаалах; хамгаалалтан байгаа этгээдийн талаарх мэдээллийн санг бүрдүүлж сангийн мэдээ баримтыг задруулах, дамжуулахыг хориглох; хамгаалалтанд байгаа этгээдэд өөрийн иргэний эрхээ эдлэх бүхий л боломжийг олгох; хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх үед гэрчийг хамгаалалтанд авах; гэрчийг хамгаалах арга хэмжээний нууцыг задруулсан нөхцөлд эрүүгийн болон бусад хариуцлага оногдуулах зэрэг зохицуулалтыг хийсэн байна.

Гэрчийг хамгаалах газар бүтэц зохион байгуулалтын хувьд мөрдөн байцаах байгууллагаас хараат бус байх бөгөөд гэрчид учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор шат дараатай хамгаалалтын арга хэмжээг авч, түүний ашиг сонирхолыг дээд зэрэгт тавин хамгаалах үндсэн үүрэгтэй. Тус байгууллага нь гэрчийн хувийн мэдээллийг маш өндөр түвшинд хадгалан, хамгаалдаг. Иймд энэ байгууллагын ажилчид, алба хаагчдад тавигдах шаардлага өндөр байдаг.

Америкийн нэгдсэн улс.

АНУ-н Конгрессоос 1982 онд гэмт хэргийн "Гэрч, хохирогчийг хамгаалалах акт"¹² (The Victim and Witness Protection Act), 1984 онд "Гэрчийн аюулгүй байдлыг сайжруулах акт"¹³ (Witness Security Reform Act) —ыг тус тус батлан гаргасан байна. Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг Холбооны Маршалуудын алба хэрэгжүүлдэг.

Гэрч, хохирогчдыг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойшхи 30 гаруй жилийн хугацаанд 7000 гаруй гэрч, хохирогч, тэдний гэр бүлийн 9000 гаруй гишүүд "засгийн газартай хэлцэл" хийж маршалын албаар хамгаалуулан төрийн хамгаалалтанд орсон мэдээ бий¹⁴. Бусад улс орны хууль тогтоогчид АНУ-ын конгрессоос баталсан хууль, засгийн газраас авч хэрэгжүүлсэн гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрүүдээс баримжаа авч өөрсдийн онцлогт тохируулан эрх зүйн актуудыг батлан гаргах, хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ажлыг эхлүүлсэн байдаг.

¹² www.justice.gov/usao-wdla/programs/victim-witness

¹³ <https://www.justice.gov/usam/usam-9-21000-witness-security>

¹⁴ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 491 дэх тал.

АНУ-ын хорих байгууллагууд Маршалын албаны туслалцаатай гэмт хэргийн хохирогчтой идэвхтэй хамтран, тэднийг дэмжин ажилладаг бөгөөд ялтныг хугацаас өмнө суллах талаар асуудлыг шийдвэрлэхдээ тухайн этгээдийн хохирогчийн саналыг Тусгай комисс буюу Пароул комиссоор (Parole Commission/Board) дамжуулан нууцаар авах ба хохирогч ялтныг сулласан нөхцөл, хугацааны тухай мэдээллийг мөн бичгээр авдаг.

Өнөөдөр АНУ-ын муж улс бүрт гэрч, хохирогчийг хамгаалах талаар хууль тогтоомжийг батлан тусгай чиг үүрэг бүхий байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж байна.

ДҮГНЭЛТ

Дээр дурдсан улс орнуудын гэрч, хохирогч хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалт манай улсын хууль тогтоох байгууллага, засгийн газраас батлан гаргасан хууль, тогтоомжид зохих тусгалаа олсон гэж үзэж болохоор байна. Гэвч бусад улсын гэрч, хохирогчийг хамгаалах талаар хэрэгжүүлж буй "тусгай хөтөлбөрүүдийг" сайтар судлан үзэж үр дүнтэй санааг тусган авч хэрэгжүүлэх нь хуулийн бодит хэрэгжилтийг хангах гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо бүрдэхэд чухал ач холбогдолтой юм.

Эцэст нь дүгнэн хэлэхэд "Өөрийгөө таних гэвэл бусадтай жиш" гэсэн мэргэн үг бий. Монгол Улсын гавьяат хуульч, доктор профессор Б.Чимид "Бусад орны жишгийг судлаагүйгээ "Монголын онцлог" гэж хаацайлах, ойлгоогүйгээ "Монгол ухаан" гэж мунхаглах явдал үзэгдлийг нуугаад яах вэ. Зайлшгүй харгалзах өөрийн онцлог байлгүй яахав гэлээ ч хүн төрлөхтний олон зууны онол, туршлагаар нээж нотолсон нийтлэг жишиг байх шүү дээ"¹⁵ гэжээ. Энэ нь гэрч, хохирогч хамгаалах ажиллагаанд ихээхэн хамаатай.

Гэрч, хохирогчийг "сайн" хамгаалж чадахгүйгээ харуулсан хуучин тогтолцоо руу буцаж орох уу? Дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн цааш хөгжих үү? гэсэн асуудал өнөөдөр бий болоод байна.

Дэлхий нийтийн жишиг ялангуяа бидний өмнө яваа бусад орны туршлагыг харгалзан үзэх нь чухал юм. Тахарын албыг хэвээр үлдээж, агентлагийн түвшинд байлган гэрч, хохирогч хамгаалах чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх нөхцлийг хангах явдал нь цаашдаа гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүмүүст төрийн зүгээс туслалцаа, дэмжлэг үзүүлэх, тэдний аюулгүй

¹⁵ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2002. 150 дахь тал.



байдлыг хангах, хамгаалах соёл, хандлага, тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

САНАЛ

1. Гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэн, бэхжүүлэхэд улс төр, эдийн засгийн баталгааг хангах нь чухал бөгөөд энэ талаар хэрэгжүүлж буй төрийн бодлого тууштай, тогтвортой, хөрөнгө санхүүгийн хувьд бүрэн хангагдсан байх нь чухал. Хуулийн институт тогтвортой ажиллаж байж үр дүн гарах тул уг чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллагын /Тахарын алба/ мэргэшсэн, хараат бус, бие даасан байдлыг хангаж, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлснээр гэрч, хохирогчийн аюулгүй байдал бүрэн хангагдана.

2. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг олон нийтэд сурталчлахаас гадна Шүүх, Прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн алба, Тахарын албаны үйл ажиллагааны уялдааг сайжруулах Гэрч, хохирогч хамгаалах ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан байгуулж журам боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3. Олон улсын байгууллага, гадны улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, урт богино хугацааны сургалтанд алба хаагчдыг хамруулан боловсон хүчнээ бэлтгэх, хууль хэрэгжүүлэгчийн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хэрэгцээ зүй ёсоор тавигдаж байна.



ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ БА ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

THE CRIMINAL LAW REFORM AND THE STATUTE OF LIMITATIONS ON CRIMINAL CASES

О.АМАРСАЙХАН

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх албаны тэнхимийн дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны нэг төрөл нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа гэдэг нь гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан хийсэн гэмт хэргийн ангиллаар ялгамжтай бөгөөд тодорхой нөхцөлтэйгөөр тогтоосон, Эрүүгийн хуулийн 72-р зүйлд заасан, гэмт хэрэг үйлдсэн үеэс хойш гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болох хугацааг хэлнэ.

Хөөн хэлэлцэх хугацааны энэхүү төрлийг Эрүүгийн хуульд хуульчлах үндэслэл, түүнийг тоолох нөхцөл, журам болон бусад асуудлыг зөв тодорхойлох нь онолын болон практик чухал ач холбогдолтой юм.

Abstract: In the Mongolian Criminal Law, the kind of the limitation period is the period for bringing to justice the perpetrators of the crime.

The term of bringing to justice those who have committed crime is the period during which it is possible to prosecute the perpetrators, as well as taking into account the social danger of the act, its extent, mitigating or aggravating nature of the punishment set differently according to the classification of crimes with certain conditions in Art. 72 of the Criminal

Code.

The correct definition the grounds of this variety of limitations for the establishment in the Criminal Code, the conditions and the order of its frames of reference have important theoretical and practical significance.

Түлхүүр үгс: Хөөн хэлэлцэх хугацаа, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа, хөөн хэлэлцэх хугацаа тасрах, хөөн хэлэлцэх хугацаа зогсох, яллагдагчаар татах, шүүхийн шийтгэх тогтоол

Key words: The limitation period, the period of criminal responsibility of the perpetrators, failure of the statute of limitations, a stop of limitation period, indictment, court verdict

Монгол Улсын Эрүүгийн хууль нь тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах зорилтын үүднээс хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтоодог бөгөөд энэ нь шударга, энэрэнгүй, хууль ёсны, түүнчлэн гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд үндэслэдэг.

Энэрэнгүй ёсны зарчмын нэг илэрхийлэл нь эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх тухай асуудал бөгөөд энэ талаар хуульд тодорхой нөхцөл байдлуудыг урьдчилан заасан байдаг нь гэмт хэргийн тухай жинхэнэ материаллаг тодорхойлолт өгч гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх тухай эрүүгийн хариуцлагын зорилгоос урган гардаг юм.

Эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх тухай хуульд заасан тодорхой нөхцөл байдлуудын нэг нь хөөн хэлэлцэх хугацаа бөгөөд нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тодорхой хугацааны дотор хариуцлага хүлээлгээгүй буюу түүнд оногдуулсан ялыг эдлүүлж чадаагүй бол дахин тэр хэрэгт нь хариуцлага хүлээлгэх буюу оногдуулсан ялыг эдлүүлэх шаардлагагүй гэсэн ерөнхий үзэл баримтлалын үүднээс Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааг тогтоожээ.

Иймд хөөн хэлэлцэх хугацааны мөн чанар,



төрөл, тэдгээрийн нийтлэг ба ялгаатай тал, тоолох нөхцөл, журам, эрх зүйн үр дагавар болон бусад асуудлыг зөв ойлгож хэрэгжүүлэх нь гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн гол хэрэгсэл болсон Эрүүгийн хуулийн зорилтыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлнэ. Гэвч 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар тогтоосон зарим хэм хэмжээ ойлгомжгүй, хоорондоо уялдаа холбоогүй, түүнийг амьдрал практикт нэг мөр ойлгож зөв хэрэглэхэд хүндрэл учруулж болохоор байгаа зэрэг нь хөөн хэлэлцэх хугацааны тухай асуудлыг авч үзэх, энэ талаар тогтоосон хэм хэмжээг шинжлэн үзэж боловсронгуй болгох арга замыг эрэлхийлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Нэг. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацааны талаар:

Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны нэг төрөл нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа юм.

Нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хуульд заасан хугацааны дотор хариуцлага хүлээлгээгүй өнгөрсний дараа дахин тэр хэрэгт нь хариуцлага хүлээлгэх нь ашиггүй байдаг. Энэ нь юуны урьд тэр өнгөрсөн хугацаанд гэмт этгээдийн үйлдсэн хэрэг нь цаг хугацааны хувьд хууль зүйн үр дагавраа алдаж, гэмт хэрэг үйлдсэн этгээд засарч хүмүүжсэн байж болох талтайгаас гадна үйлдэгдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсөн хэрэгт хариуцлага хүлээлгэх нь эрүүгийн хариуцлагын /ял/ урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх, хүмүүжүүлэх болон бусад зорилгыг бууруулахад хүргэдэг, мөн үйлдэгдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсний дараа илэрч байгаа гэмт хэргийн нотлох баримтууд зарим талаар баларч бодит үнэнийг тогтооход бэрхшээл учруулдаг тул шүүгдэгчийн эрх ашигт муугаар нөлөөлөх тал гарч болзошгүй зэрэг байдлыг харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацааг дэлхийн улс орнууд Эрүүгийн хуульдаа хуульчлан тогтоодог.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад таталгүй хуульд заасан хугацаа өнгөрсөн бол түүнийг нэхэн эрүүгийн хариуцлагад татах ажиллагаа зогсоогдож эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг бөгөөд энэ нь нэг талаас гэмт хэргийг илрүүлэх ажиллагаанд хойрго хандсанаас болж эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд харшилдаг сөрөг талтай хэдий ч нөгөө талаас эрүүгийн хариуцлагын зорилгоос үндэслэн хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн боловч түүнээс хойш тодорхой

хугацаанд засарч хүмүүжсэнээ зан төлөв, үйл ажиллагаагаараа харуулсан этгээдийг хариуцлагаас чөлөөлж байлган энэрэнгүй ёсны зарчмыг хэрэгжүүлэх эерэг талтай эрүүгийн эрх зүйн онолын болон практикийн чухал асуудал юм.

Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, эрх зүйт, ардчилсан нийгмийн харилцааг боловсронгуй болгох, хууль зөрчсөн аливаа үзэгдлийг цаг тухайд нь илрүүлэн эрс шийдвэртэй тэмцэх зорилттой холбоотойгоор гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөртөл илрүүлэхгүй байж хариуцлагаас чөлөөлөх асуудлыг аль болохоор гаргахгүй байх шаардлага өндөр тавигдаж байгаа өнөө үед төр нь нийгэм, иргэдийнхээ өмнө гэмт хэргийг Эрүүгийн хуульд заасан хугацаанд илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зохих эрүүгийн хариуцлага хүлээлгэх /ял оногдуулах/ үүргийг хуулиар хүлээдэг бөгөөд энэ тухай Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 21.1-т: "Гэмт хэргийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд гэмт хэрэг гарсан байдал, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоохын тулд хуульд заасан бүхий л арга хэмжээ авах үүрэгтэй..." гэж заажээ.

Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрснөөр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх асуудлын үндэслэлийн талаар эрүүгийн эрх зүйн мэргэжлийн эрдэмтдийн дотор эрүүжтэй саналууд байдаг.

Тухайлбал:

Зарим эрдэмтэд гэмт хэрэг үйлдсэнээс хойш өнгөрсөн хугацаанд хэрэгтэн байнгын аймшиг, сэтгэл санааны зовлонд байдаг учраас энэ нь ялтай тэнцүү төлбөр болдог гэж үздэг¹.

А.Н.Трайнин, А.А.Герцензон нарын 2 дахь хэсэг эрдэмтэд удаан хугацаа өнгөрөхөд гэмт хэргийн нийгмийн хор аюул арилдаг гэж үздэг².

В.П.Малков нарын 3 дахь хэсэг эрдэмтэд дээрх үзлийг үндэслэл муутай гэж шүүмжлээд зарим гэмт хэргийн нийгмийн хор аюул үйлдэгдсэнээс хойш тодорхой хугацаа өнгөрөхийн хэрээр багасдаг боловч бусдыг санаатай алах, зандалчлах, эх орноосоо урвах зэрэг онц хүнд гэмт хэргүүд үйлдэгдээд хэдий хугацаа өнгөрч хуучирлаа ч нийгмийн хор аюул нь хэвээрээ хадгалагдана гэж үздэг³.

¹ Г.Совд. "Эрүүгийн хариуцлага, түүний уламжлал, шинэчлэлийн асуудал". Хууль зүйн шинжлэх ухааны докторын диссертаци. УБ., 1992. 224 дэх тал.

² Г.Совд. "Эрүүгийн хариуцлага, түүний уламжлал, шинэчлэлийн асуудал". Хууль зүйн шинжлэх ухааны докторын диссертаци. УБ., 1992. 224 дэх тал.

³ С.Жанцан. "Гэмт хэргийн олонлог". УБ., 1990. 34 дэх



П.М.Мшвенерадзе нарын 4 дэх хэсэг эрдэмтэд гэм буруутай анхны гэмт хэргээс хойш хугат хэрэг шинээр үйлдэлгүйгээр удаан хугацаагаар байж чадсан, түүний улмаас урьд үйлдсэн гэмт хэрэгт нь түүнд ял хэрэглэх шаардлагагүй болсон явдал нь эрүүгийн хариуцлагад татах хугацааны тухай хэм хэмжээг хэрэглэх гол үндэслэл гэж үздэг⁴.

В.Д.Филимонов, В.Е.Смольников нарын 5 дахь хэсэг эрдэмтэд гэмт хэрэг үйлдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсөн учир хэрэг үйлдсэн этгээд нийгэмд аюултай биш болдог гэж үздэг⁵.

М.Тосюр-Издат нарын 6 дахь хэсэг эрдэмтэд хэрэг үйлдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсөн үед нотлох баримт балран алга болж гэрчүүд үйл явдлыг мартдаг учир эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрснөөр хариуцлагаас чөлөөлөх үндэслэл нь процессын асуудал гэж үздэг⁶.

С.Г.Келина, Ю.М.Ткачевский нарын 7 дахь хэсэг эрдэмтэд тодорхой хугацаа өнгөрч улмаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийгмийн хор аюулгүй болох явдал нь эрүүгийн хариуцлагад татах хугацааг хэрэглэх үндэс юм⁷ гэж тус тус үздэг байна.

Гэвч эдгээр үзэл баримтлалаар эрүүгийн хариуцлагад татах хугацааны хэрэглэх үндэслэлийг зөвхөн анхны хэргээс хойш нэлээд хугацаа өнгөрсөн, үүний улмаас ял хэрэглэх шаардлага нэгэнт үгүй болсон явдал гэж үзэх нь учир дутагдалтай байна. Учир нь үйлдсэн гэмт хэргийн буюу гэм буруутай этгээдийн нийгмийн хор аюул эрс багассан, эсхүл нийгэмд аюулгүй болсон явдал эрүүгийн хариуцлагад татах хугацааг хэрэглэх гол үндэслэл болох ёстой.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа нь эрүүгийн хариуцлагын зорилгоос урган гардаг материаллаг шинжтэй ойлголт тул эрүүгийн хариуцлагын мөн чанараас үндэслэн гэмт хэрэг үйлдсэнээс хойш эрүүгийн хариуцлага хүлээлгэх /ял оногдуулах/ хүртэлх хоорондын хугацаа нь хэдий чинээ богино байх тусам эрүүгийн хариуцлагын /ялын/ үр нөлөө төдий чинээ ашигтай байх ба гэмт хэрэг үйлдсэнээс хойш өнгөрсөн хугацаанд гэм буруутай этгээд хүмүүжсэн

тал.

⁴ С.Жанцан. "Гэмт хэргийн олонлог". УБ., 1990. 34 дэх тал.

⁵ Г.Совд. "Эрүүгийн хариуцлага, түүний уламжлал, шинэчлэлийн асуудал". Хууль зүйн шинжлэх ухааны докторын диссертаци. УБ., 1992. 224 дэх тал.

⁶ Г.Совд. "Эрүүгийн хариуцлага, түүний уламжлал, шинэчлэлийн асуудал". Хууль зүйн шинжлэх ухааны докторын диссертаци. УБ., 1992. 224 дэх тал.

⁷ С.Жанцан. "Гэмт хэргийн олонлог". УБ., 1990. 34 дэх тал.

байдал нь түүнд ял оногдуулах /хэрэглэх/ шаардлагагүй болохыг харуулна.

Иймд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрснөөр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай хэм хэмжээг тогтоох гол шалгуур үндэслэл бол: Нэгдүгээрт: Гэмт этгээд хуульд зааснаар тодорхой хугацааны ял хэрэглэж болох гэмт хэрэг үйлдсэнээс хойш тодорхой хугацаа өнгөртөл гэмт хэрэг шинээр үйлдээгүй байх. Хоёрдугаарт: Энэ хугацааны дотор тухайн этгээд болон урьд үйлдсэн гэмт хэрэг нь нийгмийн хор аюулгүй болсон.

Гуравдугаарт: Дээрх нөхцөл байдлуудын улмаас түүнд ял хэрэглэх /оногдуулах/ бодит шаардлагагүй болсон байх явдал мөн. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны энэхүү төрлийг тогтоохдоо дээрх шалгуур үндэслэлийг харгалзсан боловч анхаарч боловсронгуй болгох дараах асуудлууд байна. Үүнд:

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд заасан "Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах хугацаа"-г шинэчлэн найруулсан хуульд "Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа" гэж томьёолсон нь оновчгүй болжээ гэж үзэж байна. Учир нь Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх тухай асуудлыг авч үздэггүй харин гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял оногдуулах, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай асуудлыг л авч үздэг. Иймд энэ нэр томьёог "Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хугацаа", эсхүл "Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах хугацаа" гэж өөрчлөх.

Энэхүү хугацааг тогтоох гол үндэслэл нь гэмт хэрэг үйлдсэнээс хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх явдал байтал түүнийг "Нийтлэг үндэслэл" гэсэн бүлэгт хуульчилсан нь энэхүү хугацааны агуулга, мөн чанартай нийцэхгүй байна гэж үзэж байна. Иймд энэ талаарх хэм хэмжээг "Ял оногдуулах, чөлөөлөх, үндэслэл, журам" гэсэн 6-р бүлэгт хуульчлах.

Шинэчлэн найруулсан хуулийн 1.10-р зүйлийн 2-т: "Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах өдрийг хүртэл тоолно..." гэж заасан нь мөн учир дутагдалтай болжээ гэж үзэж байна. Ингэж энэхүү хөөн хэлэлцэх хугацааны төрлийг гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлэн яллагдагчаар татах өдрийг хүртэл тоолохоор, өөрөөр хэлбэл яллагдагчаар татсан л бол хэдэн жилийн дараа ч хамаагүй, магадгүй 40, 50, 60... жилийн дараа тухайн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдсэн этгээд нь нийгэмд аюулгүй



болж ял оногдуулах шаардлагагүй болсон үед эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох боломжтой байдлаар заасан явдал нь хөөн хэлэлцэх хугацааны мөн чанарт харшилсан, эрүүгийн хариуцлага /ял/-ын зорилготой зөрчилдсөн, түүний эрүүгийн эрх зүйн болон процессын ач холбогдлыг бууруулсан зохицуулалт болжээ гэж үзэж байна. Иймд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл тоолох тухай зохицуулалтыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Шинэчлэн найруулсан хуулийн 1.10-р зүйлийн 2-т: “Яллагдагчаар татсанаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсооно” гэж заасан нь мөн ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг үүсгэж байна. Учир нь хөөн хэлэлцэх хугацаа зогсох гэдэг нь тодорхой үндэслэл байгаа үед хугацаа тоологдохоо болихыг илэрхийлэх ойлголт бөгөөд эндээс хугацааг тоолохыг зогсоосон бол хэзээнээс үргэлжлүүлэн тоолох вэ гэдэг асуудал урган гарна. Гэтэл энэ талаар хуульд ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. Бидний үзэж байгаагаар ийм заалт Эрүүгийн хуульд байх шаардлагагүй юм.

Үүнтэй шууд холбоотой өөр нэг асуудал бол гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох тухай авч үзээгүй явдал анхаарал татаж байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Эрүүгийн хууль, ОХУ, ХБНГУ зэрэг олон орны эрүүгийн хууль тогтоомжид шүүхийн өмнөх шат болон шүүхийн шатнаас гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс зогсоож уг этгээд баригдсан буюу хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолох, харин оргон зайлсан үйлдэл нь бие даасан өөр гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулж байвал хөөн хэлэлцэх хугацаа тасарч, шинээр тоолохоор зохицуулсан байдаг. Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд энэ тухай заагаагүй учир баривчлагдсан, цагдан хоригдсоноос бусад яллагдагч оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа зогсохгүй⁸ ба түүнд хэдэн жилийн дараа ч ял оногдуулах боломжтой болж байна. Энэ нь ял гарцаагүй байх зарчмын үүднээс зөв мэт харагдавч ялын цээрлүүлэх болон бусад зорилго хангагдахгүйд хүрнэ гэж үзэж байгаа тул энэ талаарх зохицуулалтыг зайлшгүй хуульчлах шаардлагатай юм.

⁸Баривчлагдсан, цагдан хоригдсон яллагдагч оргох нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 21.11 дүгээр зүйлд заасан Оргон зайлах гэмт хэрэг учир хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж болох хорих ялын хугацаатай л харгалзуулан тогтоож, бусад ялын төрлийг авч үзээгүй явдал нь хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолоход тодорхойгүй, ойлгомжгүй байдал үүсгэж байна. Учир нь хуулийн этгээдэд торгох, эрх хасах, татан буулгах ял оногдуулахаар хуульд заасан ба ийм ял оногдуулахаар заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн авч үзэх талаар хуулийн 1.10 дугаар зүйлд заагаагүй байна. Иймд энэ талаарх зохицуулалтыг оновчтой байдлаар хуульчлах нь зүйтэй.

Хоёр. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх хугацааны талаар:

Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны нэг төрөл нь шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулиар Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх /ял оногдуулах/ ба эрүүгийн хариуцлага /ял/ нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг.

Иймд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг цаг алдалгүй эдлүүлж эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах нь нийгмийн амин чухал харилцааг гэмт халдлагаас хамгаалах Эрүүгийн хуулийн зорилгыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулсан шүүхийн тогтоолыг биелүүлэлгүй он удаан жил өнгөрсний дараа түүнийг нэхэн биелүүлэхэд эрүүгийн хариуцлагын /ялын/ дээр дурдсан зорилго хангагдах боломжгүй болдог, түүнчлэн энэ хугацаанд ялтан засарч хүмүүжсэн байж болох талтай зэрэг байдлыг харгалзан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх хугацааг улс орнууд Эрүүгийн хуульдаа хуульчлан тогтоодог.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлж болох хугацаа гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэм буруутайд тооцож, түүнд ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болох, шүүхийн шийтгэх тогтоол биелэгдэх, хуулийн хүчинтэй байх, уг тогтоолоор оногдуулсан ялыг хөөн эдлүүлж болох Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлд заасан хугацааг хэлнэ.⁹

⁹ С.Жанцан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол” / Ялын тухай сургааль/. II боть. УБ. 2014. 367 дахь тал.



Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулсан шүүхийн тогтоолыг биелүүлэлгүй хуульд заасан хугацаа өнгөрсөн бол түүнийг нэхэн биелүүлэх ажиллагаа зогсож ялтан ялаас чөлөөлөгдөх бөгөөд шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлээгүй явдал нь гагцхүү ялтны хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлаас шалтгаалсан байх ёстой.

Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, ялтан ял эдлэхэд саад болох өвчнөөр өвчилсөн, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа зэрэг ялтны хүсэл зоригоос үл хамаарах амьдралд гарсан тодорхой өөрчлөлт, нөхцөл байдлын улмаас шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх хугацаа өнгөрсөн үндэслэлээр ялаас чөлөөлж байгаа нь эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны зарчмын бодит илрэл юм.

Шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг оногдуулсан дор нь биелүүлэх юм бол сая түүний хүмүүжүүлэх болон урьдчилан сэргийлэх үр дүн мэдэгдэхүйц сайн байна. Учир нь ял оногдуулах үед гэм буруутай этгээд нийгэмд аюултай, өөрөөр хэлбэл ялын дэглэмийн нөхцөлд байлгаж урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг тул ялыг тэр дор нь биелүүлэх нь ач холбогдолтой. Хэрэв ял шийтгэсэн шүүхийн тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон үеэс ялтны хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас урт удаан хугацааны турш ял эдлээгүй ч гэсэн ял эдлэхээс зайлсхийх оролдлого хийхгүй, гэмт хэрэг шинээр үйлдэхгүй байж чадвал түүнд оногдуулсан ялыг эдлүүлэх шаардлагагүй болно. Ял эдлээгүй ч гэсэн удаан хугацаагаар гэмт хэрэг шинээр үйлдэхгүй байгаа нь тухайн этгээд нийгэмд аюулгүй болсныг гэрчлэх гол үндэслэл юм. Иймд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх хугацааг хэрэглэх гол үндэслэл бол ялтан нийгмийн хор аюулгүй болж засарч хүмүүжсэн байх явдал бөгөөд энэ бүхэн урьд ял шийтгэсэн тогтоолыг нөхөн биелүүлэх явдал зогсоогдох, ялтанг ялаас чөлөөлөх үндэслэл болох ёстой¹⁰.

Манай улс дээр дурдсан үндэслэл, шалгуурыг баримтлан 1926, 1929 оны Шүүх цаазын бичгээс бусад бүх Эрүүгийн хуульдаа энэхүү хугацааг хуульчлан тогтоож байсан ба гадаад орнуудаас ОХУ, ХБНГУ, БНХАУ, Япон, БНСУ зэрэг олон орны эрүүгийн хууль тогтоомжид шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа хуульчлагдсан хэвээр байна.

Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх хугацааг хуульчлаагүй нь онцгой анхаарал татаж байгаа бөгөөд энэхүү хугацааг шинэчлэн

найруулсан Эрүүгийн хуульд хуульчлан тодорхойлолгүй шууд хассан явдал нь ялын зорилготой зөрчилдсөн, бүдүүлэг алдаа гэж үзэж байна. Учир нь энэ хугацаа байхгүй бол ял шийтгүүлсэн л бол ялыг хэдэн жилийн дараа ч эдлүүлэх боломжтой болно. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн хүрээнд зүйрлүүлж хэлбэл 1 сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэсэн шүүхийн тогтоолыг 50 жилийн дараа биелүүлэх нь ямар ч ач холбогдолгүй байх нь ойлгомжтой.

Иймд хөөн хэлэлцэх хугацааны нэг төрөл болох шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх хугацааг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хуульчлан тодорхойлоогүй явдал нь гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн гол арга хэрэгсэл болсон Эрүүгийн хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх тул хөөн хэлэлцэх хугацааны энэ төрлийг тогтоох шаардлага, үндэслэл, ач холбогдлыг дахин судалж, Эрүүгийн хуулийн зорилт, эрүүгийн хариуцлага /ял/-ын зорилготой уялдуулан оновчтой байдлаар хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Г.Гантөмөр, О.Амарсайхан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа”. УБ., 2004.
С.Жанцан. “Гэмт хэргийн олонлог”. УБ., 1990.

С.Жанцан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол” /Ялын тухай сургааль/. II боть. УБ., 2014.

Г.Совд. “Эрүүгийн хариуцлага, түүний уламжлал, шинэчлэлийн асуудал”. Хууль зүйн шинжлэх ухааны докторын диссертаци. УБ., 1992.

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл. 2016. №7

Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. 2002. №5

¹⁰ С.Жанцан. “Гэмт хэргийн олонлог”. УБ., 1990 он. 37 дахь тал.



SENTENCING POLICY FOR THEFT CRIMES IN MONGOLIA—PRACTICAL ANALYSIS AND ISSUES

МОНГОЛ УЛСАД БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛОНОГДУУЛЖ БУЙ ПРАКТИК, АНХААРАХ АСУУДАЛ

Б.ЭНХБОЛД

Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Abstract: Theft offences have been becoming one of the serious problems in Mongolia for last two decades. Almost everybody has experienced to be theft victim. The main purpose of this study is to make analysis and conclusion on current state of sentencing for theft. Information resource was collected from National Police Agency, Research center at Supreme Court, and Judicial research, information, training institute at Judicial General Council. Last five year statistics show that averagely 8900 theft incidents reported in a year at police which is 1036 or 11.7 percent out of all crimes adjudicated. As for sentence type and length, 80 percent of defendants were imposed imprisonment. It reveals that sentence policy has been very strict towards defendants.

Товч агуулга: Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монгол Улсад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг тулгамдсан асуудал болсоор байна. Энэхүү судалгааны ажлаар бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэж буй байдалд дүн шинжилгээ хийхийг зорьсон болно. Судалгааны ажил нь Цагдаагийн ерөнхий газар, Улсын Дээд шүүхийн Шүүхийн

практик судлалын төв болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайланд тус тус үндэслэгдсэн болно. Судалгааны үр дүн сүүлийн 5 жилд цагдаагийн байгууллагад жилд дунджаар 8900 бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг бүртгэгдэж үүнээс 1036 буюу 11.7 (%) нь шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрөл хэмжээг авч үзвэл 80 орчим хувьд нь хорих, баривчлах зэрэг нийгмээс тусгаарлах ял оногдуулж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулж буй ялын бодлого чанга байгааг илтгэж байна.

Кye words: Theft trend, Corpus delicti, punishment, Incarceration, Imprisonment, adjudicated by court.

Түлхүүр үгс: Хулгайлах, гэмт хэргийн бүрэлдэхүүн, ял, баривчлах ял, хорих ял.

1. Introduction

Article 16, Provision 3 of the Constitution of Mongolia states that "Right to fair acquisition, possession, and inheritance of movable and immovable property. Illegal confiscation and requisitioning of the private property of citizens shall be prohibited."¹ It is a fundamental regulation on combating against theft related crimes. Right to possess property was enacted by the Constitution and Criminal Code. Appropriate sentence shall be imposed to anybody who breaches it by possessing any property through criminal acts.

Sufficient number of studies and researches on crimes against property has been conducted by scholars in Mongolia, however focused research on theory and judicial practice of sentencing for theft has not been made yet. I decided to concentrate on sentencing for thefts.

The main purpose of my article is to make analysis and conclusion on current state of sentencing for theft. Within this scope, current state, component, and sentence of the crimes was selected as main objects. Information resource was collected from National Police Agency, Research center at Supreme Court, and Judicial research, information, training institute at Judicial General Council.

2. Current state of theft in Mongolia

Theft offences have been becoming one of the serious problems in Mongolia for last two decades. Almost everybody has experienced to


¹ NPA. (2011). Current conditions of crimes committed in Mongolia: 2006-2010, Ulaanbaatar: National Police Agency of Mongolia



be theft victim. The National Police Agency registered total of 200,972 thefts between 1990 and 2012, an estimated 51.2 percent of the Nation's theft occurred in Ulaanbaatar area while 48.8 percent of theft occurred in rural area. Stealing of livestock and their parts are very common among theft crimes followed by burglary and pickpocketing. Burglary (62 percent) and livestock (31 percent) were the highest rate.

Figure I show theft trends over a 20-year period between 1990 and 2012 for five areas. It should be emphasized at the outset that an examination of theft data on area-by area basis is unlikely to yield reliable conclusions. Overall trend for the region rate for theft has been fluctuating since 1990 and each region for the theft rate increased from 2012 compared to the 1990. Ulaanbaatar rate for theft suggests a relatively strongly upward trend from 1990 to 1995, from under 238 incidents per 100,000 inhabitants to over 884 or increased by 73 percent. But it has been steadily decreasing since 1996 and 259 incidents per 100,000 inhabitants in 2012. The trend for the overall area closely mirrors this, although beginning with lower levels of theft in 1990. As in the case of theft, both Eastern and Central area showed dramatic steady from 1993 to 2002, in recorded cases of theft, from just under 560 incidents per 100,000 inhabitants to around 530 incidents.

Figure I. Trends in reported theft per 100,000 populations, areas



Source: Mongolian National Police Agency

From 2001, the rate of theft escalated in Ulaanbaatar city and the percentage of such crimes amounts up to 48.0 percent and more, and the current trend shows that there will be a considerable increase in the future. Researchers explain this fact as a connection with the mechanical growth of population influenced

by the urbanization process and consider this phenomenon as a negative process.

Theft rates for other areas of Mongolia were in significant or the data were too patchy for clear conclusions to be drawn. A rate of theft is also high in rural areas which can be defined by livestock theft. By the effect of social transition, Mongolia citizens started to privatize own properties including herders own their livestock. In this regard, livestock theft has increased dramatically in rural areas, especially Central and Eastern areas near Ulaanbaatar. Although this kind of crime is relatively lower in Western and Forest areas of Mongolia, trans-border livestock theft becomes more serious issue. The reason is geographical location of Khovd; Bayan-Ulgii and Uvs provinces are directly bordered with Russian Federation.

Nevertheless, theft remains a serious concern in poor and middle-income societies, the data for which have been isolated and presented in figure I; the line for selected areas with high theft rates shows overall increases in theft until the mid-1990s, followed by significant declines. Of interest is the "Top" in the trend line between 1993 and 1997; that was a period of extraordinarily high theft rates in those areas at the time (being on average close to 400 incidents per 100,000 inhabitants, coinciding with a period of significant economic, political and social change in Mongolia). Drop in theft crime in 1998 due to following factors as economic growth, improving of living standards, and development of educational and cultural level of citizens. Therefore, under the expansion of crime prevention of theft, government implemented theft prevention program in 1997 and 2002, parliament adopted a new law called "Prevention of livestock theft" in 2004 claimed a significant impact of reducing the level of crime.

On the other hand, such crimes have tended to be hidden by methods of committing the theft crime and it became more sophisticated, increasing the size of damage, and criminals use vehicles and communication tools widely, cooperating with pre-organized dealt group. Also, police actions towards fighting theft were not scientifically research based, and government actions against these crimes did not have significant results on decrease of theft crimes because of their formality and theft crimes became a common phenomenon in the society. A more detailed look at the statistics and the countries that have provided them, largely those in Mongolia, suggests that in almost all cases transition to democracy



was accompanied by increases in theft. In all cases levels of theft are of great concern to Governments and citizens. The development of property crime forms of theft must be viewed as an issue of particular concern in countries attempting to consolidate hard-won democracies in the context of economic instability.

3. Corpus delicti of theft

Theft crime was legalized and types of punishment were classified by the Article 19, Provision 145 of Special part of Criminal Code about Crime against property (effective since September 1, 2002). Theft was legalized as follows according to the nature and degree of their social danger and gravity of the punishment to be imposed:

Criminal Code, Special part 145.1: If considerable amount of damage caused by stealing of others' property, it shall be punishable by a fine equal to 5 to 50 amounts of minimum salary, 100 to 250 hours of forced labor, or incarceration for a term of 1 to 3 months or incarceration.

Criminal Code, Special part 145.2: Theft committed repeatedly or by a group of persons at an advance agreement that has caused a significant damage, theft with entry of a home, room or another storage place using mechanisms or especially prepared tools, or significant number of livestock theft shall be punishable by a fine equal to 51 to 250 amounts of minimum salary, incarceration for a term of more than 3 to 6 months or imprisonment for a term of 2 to 5 years.

Criminal Code, Special part 145.3: The same crime committed by a group at an advance agreement, depriving the victim of the source of living, causing damage in a large amount, or committed by taking advantage of a public disaster shall be punishable by a fine equal to 251 to 500 amounts of minimum salary or imprisonment for a term of more than 5 to 10 years.

Criminal Code, Special part 145.4: The crime committed by a person previously sentenced for robbery, extortion, and/or assault or by an extremely dangerous criminal or an organized group causing damage in a large amount shall be punishable by confiscation of property or imprisonment for a term of more than 10 to 15 years.

Article 10, Provision 1 of the Criminal Code states that "Committing a crime that contains all the characteristics of a crime specified in this Code shall be the ground of the criminal liability" Corpus delicti consists of four elements

such as object, objective part, subjective part, and subject.

3.1. Corpus delicti of theft /145.1/

Object of theft corpus delicti: It is the right of fair acquisition, possession, and inheritance of movable and immovable property indicated in the Article 16, Provision 3 of the Constitution of Mongolia states.

Objective part of theft corpus delicti: It is about stealing other's property by a) act and omission a hidden way, 2) causing considerable damage, 3) above act or omission must be relationship with considerable damage.

Stealing other's property means illegally taking non-owning property in a hidden way with greedy intention without use of violence and intentional act of spending and using the property or create opportunity spend it without any payment.

The amount of damage shall be determined as follows in Article 29 of Criminal Code: The amount equal to 1 to 50 amounts of minimum salary and wages current at the time of committing the crime as considerable, (1,92,000-9,600,00 national currency or 87,9-4,397 euro); the amount equal to 50 to 125 amounts of minimum salary and wages as substantial (9,600,000-24,000,000 national currency or 4,397-10994 euro); the amount equal to 125 to 200 amounts of minimum salary and wages as large (24,000,000-38,400,000 national currency or 10,994-17,590 euro); and the amount more than equal to 125 to 200 amounts of minimum salary and wages as extremely large (over 38,400,000 national currency or 17590 euro). According to applicable law on determining the minimum wage, it is currently 192,000 tugrug or 87.9 euro and proper sentence will be imposed for those who stole property cost above the minimum wage.

Subjective part of theft corpus delicti: Intentional, greedy intention.

Subject of theft corpus delicti: Reached 14 years, liable Mongolian citizen or foreign citizen or stateless body who has no right to possess, use, or spend the property.

3.2. Circumstances which aggravate liability.

Aggravation of theft is explained as follows by a resolution named "Explaining some provisions under Article 145 of Criminal Code" by Supreme Court made on May 29, 2006.

Criminal Code 145.2

Repeated theft: it means committing theft



twice or more times.

Theft as a group: means two or more persons commit theft without an advance agreement but merging their intention and hands and fulfilling the characteristics of objective parts of the crime.

Prepared theft as a group: means two or more persons make advance agreement on stealing something together.

Theft committed using vehicle: means a culprit prepared vehicle in advance in order to ease illegal acts by quickly reaching and transporting any targeted properties considered difficult to be easily broken.

Specially prepared tools for theft means all types of tool and equipment used for committing theft crime for easing criminal acts, which produced for military, factory, and chemistry purposes and help increase physical force when breaking security protection.

Burglary by trespassing home and warehouse means accessing dwelling and/or warehouse by using similar keys, breaking window, door, or lock with or without using any tools, secretly enter any place and hide when open and/or by using any other methods.

Dwelling means permanent or temporary residential places such as apartment, house, ger (yurt), hotel, and/or cottage.

Warehouse means all facilities designed to temporarily or permanently keep property. Stable, fence, and facility equipped with security lock preventing from potential theft occurrence is considered as warehouse as well.

Theft of considerable number of livestock means stealing of more than 8 camels, cows, or horses or 25 sheep and/or goats through one or several criminal acts.

Criminal Code 145.3

Theft committed by an organized group: A permanent group joining at an advance agreement for the purpose of committing crimes shall be recognized an organized group.

Deprivation of source of living caused by theft: It is not determined by amount of stolen property and its cost but economic significance of victim's life examined and assessed by investigator, prosecutor, and judge.² For instance, if victim's monthly salary and retirement benefit, or only cow/ horse were stolen due to the crime, it will be considered as **aggravate** condition.

Criminal Code 145.4

Theft committed by a person previously sen-

tenced for robbery, extortion, and/or assault: it will be counted as circumstances which aggravate liability if a suspect was previously sentenced due to committing theft crime twice or more or by similar crimes such as robbery or extortion or repeatedly committed theft while not being legally released from punishment as per Article 78 of Criminal Code.

Theft committed by an extremely dangerous criminal or group: If a suspect commits theft again after resolution released about counting him as an extremely dangerous criminal according to applicable clause of Article 24 of Criminal Code, the crime will be considered to be committed by a recidivist.

Theft committed by an organized group: It will be explained that permanent group joining at an advance agreement for the purpose of committing crimes shall be recognized an organized group. /Criminal Code 36.4/ Union of criminals pursuing the purpose of gaining profit, structured into an organization shall be recognized a criminal organization. /Criminal Code 36.5/

3.3. Differentiating sentence classification between theft and other similar crimes:

- Sentence will be imposed for those who stole firearms (except for hunting gun), explosive substances, or narcotic and psychotropic drugs;

- Suspect will be sentenced and considered that he prepared for the crime if he escaped from the crime scene after knowing that he was witnessed by other people and stopped stealing the property;

- Depending upon characteristics of violent or non-violent actions for taking the property or not losing the stolen property after taking it, sentence applicable for robbery or extortion as classified in the Criminal Code will be imposed for the accused;

- If a theft committed by a single person and others involved as partners such as contractor, organizer, an instigator, and an accessory, a sentence will be imposed as per the Article 145 of Criminal Code;

- It will be counted as theft if the accused stole property by taking advantage of children, elderly person, drunk or mentally ill person, disable person (blind or deaf) or sleeping person who were not physically capable to understand or reveal the incident;

- It will be classified as theft if the accused hoped that witness did not understand about his criminal act while taking other's property in a hidden way with greedy intention or ex-

pected the witness would not protest against his criminal act due to close relationship with the witness;

- Sentence classified forextortion will be imposed if the accused continued his criminal act even after knowing that owner of the stolen property witnessed and realized the illegal act at the crime scene and for robbery if dangerously used force against victim's life or body or threatened to attack.²

4. Sentencing for theft

Punishment for theft crime on behalf of state is one of the formations of implementing state policy on combating against theft. Punishment impacts positively when proper sentence is imposed as stated in Criminal Code for theft crimes considering its danger degree. Below data shows sentence types for theft imposed for criminals in last five years.

4.1 Theft adjudicated by the Court

Table-1 shows that total of 6600 theft crimes, which is 21.5 percent of all reported crime, was adjudicated by court between 2011 and 2015 in Mongolia. Since 2012, number of theft crimes resolved by court increased year by year, reaching its peak at 82 crimes or 5.7 percent in 2015. Considering corpus delicti of all adjudicated theft, it can be seen that 9.6 percent was theft with criminal Code 145.1, 87.3 percent was criminal Code 145.2, 145.3, and 2.9 percent was criminal Code 145.4.

Table-1. **Data on theft adjudicated by court (2011-2015)**

Year	Case (145)	(%)	145.1 (%)	145.2 (%)	145.3 (%)	145.4 (%)
2011	1282	(100)	146 (10.5)	1064 (83.0)	55 (4.3)	27 (2.1)
2012	1281	(100)	147 (11.5)	1070 (83.5)	20 (1.6)	50 (3.9)
2013	1283	(100)	98 (7.6)	1111 (86.6)	33 (2.6)	41 (3.2)
2014	1336	(100)	129 (9.7)	1114 (83.4)	53 (4.0)	38 (2.9)
2015	1418	(100)	117 (8.3)	1234 (87.8)	16 (1.1)	37 (2.6)
Total	6600	(100)	637 (9.6)	5593 (84.7)	177 (2.6)	193 (2.9)

Source: Online resource from Judicial General Council

It can be concluded from the above table that number of theft with circumstances which aggravate liability indicated in the Criminal Code 145.2 increased year by year. Clear explanation of common methods of stealing, dwelling and warehouse in Article 145.2 may help increase number of theft adjudicated by court. (Trespassing into dwelling or warehouse, stealing livestock as a group or repeating the crime)

Also, damages caused by theft were clearly legalized in Criminal Code. The damages in most of the committed theft meet the amount of damages indicated in the applicable provision. It contributed to have more number of thefts in this part.

4.2 Sentence types for theft

Table-2 shows the relevant information. As per the last five year study, a total of 10821 persons were punished for stealing property. Out of that, 7010 persons or 64.7 percent were imprisoned, 2073 or 19.4 percent incarcerated, 397 or 3.6 percent imposed forced labor while 685 or 6.26 percent fined.

Table-2. **Sentence types for theft (2011-2015)**

**Sentence type**

	2011		2012		2013		2014		2015	
	2227(100%)		2191(100%)		2077(100%)		2296(100%)		2030(100%)	
Fine	142	(6.3)	151	(6.8)	122	(5.8)	149	(6.4)	121	(6.0)
Forced labor	71	(3.1)	94	(4.2)	88	(4.2)	73	(3.1)	71	(3.4)
Incarceration	429	(19.2)	399	(18.2)	392	(18.8)	450	(19.5)	403	
Imprisonment	1436	(64.4)	1393	(63.5)	1381	(66.4)	1501	(65.3)	1299	
Denied	45	(2.2)	153	(6.9)	94	(4.5)	123	(5.3)	121	(6.0)

Supplemental sentence

Property confiscation	183	(8.2)	201	(9.1)	196	(9.4)	179	(7.7)	186	(9.1)
-----------------------	-----	-------	-----	-------	-----	-------	-----	-------	-----	-------

Source: Online resource from Judicial General Council

In 2015, 121 persons were fined by 645 million tugrug, 8400 hours of forced labor for 71 persons, and as supplemental sentence worth of 12 million tugrug were imposed for 103 persons. 403 persons were incarcerated, which averagely shows incarceration length-2.6 months. As for average length of imprisonment, 63 percent was 2 to 3 years, 20.1 percent-3 to 5 years, 6.2 percent-5 to 8 years, 4.1 percent-8 to 10 years, and 6.6 percent-10 to 15 years.

4.3 Imprisonment sentence for those committed theft

Table-3 shows imprisonment rate for theft. As for last five years, 2853 persons or 40.7 percent were imprisoned out of 7010 criminals while 93 persons or 3.2 percent were commuted their sentence as per the Special part of Criminal Code. 3740 persons or 49.3 percent was suspended their sentence up to 2.1 years. Moreover, 440 juveniles committed theft or 6.2 percent was probated their sentence period (Criminal Code 62), whereas 144 single parents who have children under 3 years or 1.5 percent was also probated their sentence (Criminal Code 63). Also, 133 persons were pardoned from imprisonment.

Table-3. Imprisonment rate for those committed thefts (2011-2015)

No		2011	2012	2013	2014	2015
	Imprisonment sentence	1436 (100%)	1393 (100%)	1381 (100%)	1501 (100%)	1299 (100%)
1	Imprisonment	598 (41.6)	564 (40.8)	555 (40.1)	617 (41.1)	519 (40.0)
	Imposed less sentence (Criminal Code 55.1)	24 (1.6)	13 (0.9)	16 (1.1)	21 (1.3)	19 (1.4)
2	Probation (Criminal Code 61)	681 (47.4)	706 (50.6)	710 (51.1)	765 (51.0)	608 (46.8)
3	Suspended sentence (Criminal Code 62)	98 (6.8)	84 (6.0)	85 (6.1)	83 (5.5)	90 (6.9)
4	Suspended sentence (Criminal Code 63)	33 (2.2)	22 (1.5)	19 (1.3)	20 (1.3)	20 (1.5)
5	Pardon (Criminal Code 77)	26 (1.8)	17 (1.2)	12 (0.8)	16 (1.0)	62 (4.7)

Source: Online resource from Judicial General Council

Above data shows that imprisonment rate is quite high. Imprisonment is legalized for theft in Provision 1, 2, and 3 under Article 145 of Criminal Code especially Provision 4 under the same article states about the imprisonment sentence without optional sanction. Also, Article 52.2 indicates that length of imprisonment is 1 to 15 years however, Article 145.2 states that minimum length of imprisonment is 2 years, which limited the option to impose one year imprisonment sentence for the accused person. Regulation to commute sentence as per the special part of Criminal Code is legalized in Article 55.1, nevertheless application of this regulation on theft crime is relatively low used compared to its application on other crimes. It may be caused by following three fundamental requirements in the applicable legal regulation to commute sentence as stated in the Special part of Article 55.1 of Criminal Code:

- 1) committed a crime first time which is supposed to be imposed imprisonment sentence;
- 2) Restituted the damages;
- 3) Personal condition. Requirement of damage restitution is not usually met by the culprit. Last five year statistics show that 52.5 percent of total number of persons stole property was unemployed, 8.9 percent was drunk while committing a crime, 49.2 percent committed as a group, and 17.2 percent was previously sentenced by court.

Conclusion

1. Crime of stealing property amounts to 38 percent of total crimes committed. Last five year statistics show that averagely 8900 theft incidents reported in a year at police which is 1036 or 11.7 percent out of all crimes adjudicated.
2. As for sentence type and length, 80 percent of defendants were imposed imprisonment. It reveals that sentence policy has been very strict towards defendants. 41 percent of the accused persons serve in prison while 59 percent gets probation or suspension.
3. It has been relatively low to apply the regulation to commute sentence as per the special part of Criminal Code legalized in Article 55.1 because defendants do not retribute the damages or repeatedly commit theft or commit as a group.
4. Average length of imprisonment is 4.3 years in practice. It shows that sentence

policy has been significantly strict. Article 52.2 indicates that length of imprisonment is 1 to 15 years however, provision Article 145.2 states that minimum length of imprisonment is 2 years, which limited the option to impose one year imprisonment sentence for the accused person.

1. *Recommendation*: Flexibility on sentence policy for those who committed theft is needed in practice by reducing length of imprisonment or applying more probation or suspension types of sentence instead. For example, legal regulation to commute sentence is needed to start implementing if defendant restituted the damages or expressed to retribute it. Also, it is necessary to drop the minimum length of imprisonment down to one year.

2.

3. Reference

1. Constitution of Mongolia –published in Issue “State news” 1992, №1
2. Criminal code of Mongolia, published in Issue “State news” 2002.№5
3. Jantsan, S. (2009). Theory of criminal law, doctrines of crime: Admon press, Ulaanbaatar, pp 56-63
4. Jantsan, S.(2013). The nature, actuality and tendency of state policy on fighting against crimes. *The brochure of implementation and tendency of state policy on combating crime, (International Scientific Conference). pp.10-23.*
5. Supreme Court, (2014). Court statistic report 2004-2015. Ulaanbaatar Mongolia: Supreme court of Mongolia.
6. NPA. (2005). Current conditions of crimes committed in Mongolia: 1990-2005, Ulaanbaatar: National Police Agency of Mongolia.
7. NPA. (2012). Current conditions of crimes committed in Mongolia: 2005-2015, Ulaanbaatar: National Police Agency of Mongolia.
8. Judicial research, information, training institute at Judicial General Council. *Online resource from Judicial General Council.* Judcouncil.mn



**ХУУЛЬ САХИУЛАХ ХҮРЭЭНД ЭРҮҮГИЙН
ПРОЦЕССЫН АЛБАДЛАГА ХЭРЭГЛЭХ
АЖИЛЛАГАА: ОНОЛ, ПРАКТИКИЙН
ЗАРИМ АСУУДАЛ**

**CRIMINAL PROCEDURE MANDATORY
MEASURES IN LAW ENFORCEMENT: SOME
ISSUES OF THEORY AND PRACTICE**

Д.БАЯРСАЙХАН

Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор

Товч агуулга: Хууль сахиулах ажиллагаа нь эрүүгийн процессын албадлага хэрэглэх үйл явцтай салшгүй холбоотойн дээр төрийн хуулийг шууд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн албадан захирамжлах үйл ажиллагаа юм. Энэ нь нэг талаас хүний эрхийг хамгаалахад чиглэгддэг бол зарим үед хүний эрхийг хөндөх, хязгаарлах нөхцлийг бий болгоход нөлөөлдөг. Орчин үед эрүүгийн процессын шатанд хүний халдашгүй эрхийг хамгаалах шаардлага өсөн нэмэгдсээр байна. Цаашдаа эрүүгийн процессын эрх зүйн орчин шинэчлэгдэж, хууль сахиулах ажиллагаа тогтвортой хэрэгжихийн хирээр хүний халдашгүй эрхийг тууштай хамгаалах бодит нөхцөл бүрдэнэ.

Abstract: As considered in a whole, human right issue has still been a faced topic with in pre-trial criminal procedure as well as it is necessary to consider on legal status of the participants in the relation of criminal process with inviolable human right.

Under adoption of Criminal Procedure Code in 2002, Mongolia could perform legal reform with relatively advanced regulation removing limited rules of human rights in the criminal process of previous system. But it does not negate that some positive changes appeared

on the pre-trial criminal procedure for nearly 10 years since the effectiveness of Mongolian Criminal Procedure Code of 2002.

In fact, action to resolve the minor case through simplified rule was performed for the first time, types of arresting and restraint measure of suspect was expanded as well as the procedure for the complaint and request by participants in the criminal process improving the possibility of suspect and accused to enjoy their rights were optimized.

Above mentioned subject has been not only faced topic in the Mongolian Legal science but the core issue of theory and practice which is required to be resolved in near future.

Түлхүүр үгс: Хууль сахиулах ажиллагаа, хүний халдашгүй эрх, эрүүгийн процессын албадлага, төрийн гүйцэтгэх эрх мэдэл, эрүүгийн процессын шинэтгэл

Key words: Human right, criminal procedure, mandatory measures, law enforcement, some issues, criminal procedure code in 2002

- Оршил
- Эрүүгийн процессын албадлага ба гадаад орнуудын нийтлэг жишиг хандлага
- Эрүүгийн процессын албадлага хүний эрхээр хязгаарлагдах нь
- Эрүүгийн процессын албадлага дахь тулгамдсан зарим асуудал
- Дүгнэлт

Нэг. Оршил

Сүүлийн жилүүдэд хууль сахиулах ажиллагааны зорилго, зарчмыг хууль ёсны гэхээсээ илүү хүний эрхийн хэм хэмжээ, стандартыг хэрхэн хангаж байгаатай холбон авч үзэх болсон билээ. Хууль сахиулах ажиллагаа нь шууд утгаар нь авч үзвэл бүх хуулиуд бүрэн хэрэгжих явдлыг хангахад чиглэгдсэн байдгаараа төрийн болон төрийн бус бүх байгууллага, албан тушаалтнаас гадна хүн бүр, иргэн бүхэнд хамааралтай ойлголт юм. Харин нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, хуулиар хүлээсэн үүрэг, шаардлагыг хангуулахад зайлшгүй холбогдох утгаараа цагдаагийн болон төрийн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой.

Ямар ч албадлага хүний хүсэл зориг, ашиг сонирхлоос гадуур хүнд хүч хэрэглэн нөлөөлөх онцгой хэрэгсэл болох тул түүнийг хууль ёсны болон хууль бус гэж ялган авч үзэх нь хууль сахиулах ажиллагаанд тавих хүний эрхийн шаардлага, шалгуурыг үнэлж,



тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Хууль бус албадлага нь нэг талаас хуулиар зөвшөөрөгдөөгүй арга хэрэгслээр хэрэгждэгээс гадна хуулиар хориглосон сөрөг үр дагавар бүхий ажиллагаа байдаг. Энэ нь зарим тохиолдолд гэмт үйлдлийн шинж, хэлбэрээр ч илэрч болохыг үгүйсгэх аргагүй.

Хууль ёсны албадлага нь хуулиар тусгайлан зааж, зохицуулсан байхын дээр хуулийн дагуу зүй ёсны шаардлагад нийцсэн, эрх зүйн үндэслэлд тулгуурлах бөгөөд хуулийг сахиулахад шууд чиглэгдсэн байдаг.

НҮБ-аас 1979 онд баталсан **"Хууль сахиулах албан тушаалтны зан үйлийн тухай хууль"**-ийн 1-р зүйлд: "...Хууль сахиулах албан тушаалтнууд ... бүх хүмүүсийг хууль бус үйлдлээс хамгаалж, хуулиар хүлээлгэсэн үүргээ мэргэжлийн шаардлагын үүднээс байнгын өндөр хариуцлагатай биелүүлнэ." 2-р зүйлд: "...Хууль сахиулах үүргээ биелүүлэхдээ бүх хүмүүсийн нэр төрийг хүндэтгэж, хүний эрхийг хамгаалан дэмжинэ..." гэсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19-р зүйлд: "...Төрөөс ...хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэний өмнө хариуцна." гэж заажээ.

Хууль сахиулах ажиллагаа нь хуульд үндэслэгдсэн төрийн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа болохын хувьд хуулийг гуйвалтгүй дагаж мөрдөх шаардлагыг хангуулах, хуулийн заалт, хэм хэмжээг албадан хэрэгжүүлэх үйл явц юм.

Монгол Улсад хэрэгжиж эхэлсэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хууль сахиулах ажиллагаанд холбогдох шинэчлэлт өөрчлөлт чухал байр суурийг эзэлж байна. Хууль сахиулах ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, тухайн байгууллагуудын нийгэм эдийн засгийн баталгааг бүрдүүлэх чиглэлээр тогтолцооны шинжтэй нилээд өөрчлөлт хийгдэж, зарим нааштай хандлага, орчин бий болж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ хууль сахиулах байгууллагуудад нийтлэг хамааралтай Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль батлагдсан хэдий ч мөрдөгдөж эхлээгүйн дээр чиг үүргийн гол суурь хууль болох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль бүрэн эцэслэн батлагдаагүй байгаа билээ. Өөрөөр хэлбэл хууль сахиулах салбарт хийгдэж буй шинэтгэл нь зөвхөн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт төдийгөөр хязгаарлагдаж, чиг үүрэг, үйл ажиллагааны гол хуулиуд батлагдан мөрдөгдөөгүйгээс эрх зүйн орчин нь бүрэн шинэчлэгдсэн гэж

үзэх боломжгүй юм.

Энэхүү сөрөг нөхцөл байдлаас шалтгаалж, материаллаг болон органик хуулиуд процессын хуультай зөрчилдөх, хууль сахиулах чиг үүргийг үр нөлөөтэй, шууд хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгааг үгүйсгэх аргагүй. Ялангуяа гэмт хэргийг таслан зогсоох шуурхай илрүүлэх явцад эрүүгийн процессын албадлагыг зохистой хэрэглэх боломж хязгаарлагдмал, хүний эрхийг зөрчих нөхцөл, хүчин зүйлийг аяндаа бий болгосоор ирсэн нь анхаарал татах болжээ. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль хэрэгжих явцад эрүүгийн процессын хойшлуулшгүй болон таслан сэргийлэх ажиллагаанд ноцтой гажуудал гарч, *(яллах болон эрүү шүүлтийн хүчин зүйлийг бий болгосон)* уг хуулийг сууриар нь бүхэлд нь өөрчлөх шаардлага бий болсон юм. Дээр дурдсан нөхцөл байдлууд нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанаас илүү эрх зүйн орчны гажуудал болон хуулиудын оновчтой зөв зохицуулалт үгүйлэгдэж байгаатай холбоотой.

Судлаач, профессор миний бие энэхүү бэсрэгхэн илтгэлдээ эрүүгийн процессын албадлага нь хууль ёсны дагуух төрийн албадлагын нэг төрөл болохын хувьд хууль сахиулах ажиллагаатай яаж холбогдох хийгээд хүний эрхийн болон эрүүгийн процессын шинэчлэлийн асуудлыг хөндөж, зарим санал, дүгнэлтийг дэвшүүлж, та бүхэнтэй хуваалцахыг зорьсон болно.

Хоёр. Эрүүгийн процессын албадлага ба гадаад орнуудын нийтлэг жишиг, хандлага

Орчин үеийн олон улсын нийтийн эрх зүйд эрүүгийн байцаан шийтгэх албадлагын болон хойшлуулшгүй ажиллагааны явцад хүний халдашгүй эрхийг зөрчих явдал дэлхийн олон улс оронд түгээмэл гарах болсныг онцгойлон авч үзэж, анхаарах болсон байна.

Эрүүгийн процессын албадлага нь хуулиар зөвшөөрөгдсөн хууль ёсны албадлага учраас хэдийгээр гэмт хэргийг таслах зогсоох, урьдчилан сэргийлэх агуулга, зорилгыг илэрхийлдэг хэдий ч хүний халдашгүй эрхийн орон зайд шууд ба шууд бусаар нэвтэрч хэрэгждэг тул ямар хязгаарт, яаж хэрэглэх ёстойг нь олон Улсын гэрээ, конвенцуудаар зохицуулсаар ирснийг хөгжингүй болон хөгжиж буй улс орнууд үндсэн хууль, эрүүгийн процессын хуулиудаар шинэчлэн баталж, тууштай хэрэгжүүлсээр иржээ.



Олон улсын хэмжээнд хийсэнд (*дэлхийн хэмжээний*) судалгаанаас үзэхэд баривчлах, цагдан хорих, үзлэг, нэгжлэг хийх, хураан авах, зорчих эрхийг хязгаарлах зэрэг процессын албадлага хэрэглэх үед хүнлэг бусаар харьцах, шүүхийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр хүний өмчлөх эрхэнд халдах, нотлох баримтгүйгээр сэжиг таамгаар удаан хугацаанд албадан саатуулах, таслах сэргийлэх арга хэмжээ авахдаа хуулийг буруу хэрэглэх зэрэг зөрчлүүд цөөнгүй оронд түгээмэл байдлаар илэрч, тэдгээрийг таслан зогсоох шаардлага тавигдсаар иржээ.

НҮБ-ын Хүний эрхийн Олон улсын суурь конвенцуудаас гадна 2008 онд НҮБ-ын дэмжлэгтэйгээр батлагдсан **“Дэлхийн улсуудын Эрүүгийн процессын загвар хууль”**-д цагдан хорих арга хэмжээг түгээмэл журам болгох нийтлэг байдлаар хэрэглэхгүй байх, албадан саатуулах, цагдан хорих, баривчлах явдлыг онцгой тохиолдолд хязгаарлагдмал байдлаар хэрэглэх тухай заасан байдаг. Түүнчлэн олон сонголт бүхий эрх хязгаарлалтын болон барьцаа, торгууль тогтоохоос гадна цагдан хорих эсэхийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үндсэн дээр шүүхийн тогтоолоор шийдвэрлэж байхаар тусгасан нь бий.

НҮБ-ын гэрээ, конвенц, загвар хууль зэрэг олон улсын баримт бичгээс үзэхэд харьцуулсан судалгаанд ач холбогдол бүхий дараах суурь зарчмууд, хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлал болж тогтсон байна. Үүнд:

□ Процессын албадлага нь зөвхөн нарийвчлан зохицуулсан тодорхой хуулийн дагуу байх;

□ Баривчлах, цагдан хорих үндэслэл нь сэжиг, таамгийн бус, баримтат мэдээллээр илэрч, нотлогдсон бодит нөхцөлүүдэд тулгуурласан байх;

□ Цагдан хорих эсэхийг зөвхөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үндсэн дээр шүүхийн тогтоолоор шийдвэрлэх;

□ Цагдан хоригдсон этгээдийг суллах нөхцөл, журам нь цагдан хорих журамтай адил хуульлагдсан байх;

□ Эрүүгийн процессын албадлагын арга хэмжээний төрлүүд нь олон сонголттой байхаас гадна цагдан хорих явдлыг нэлээд хязгаарлагдмал хүрээнд онцгой нөхцөлд хэрэглэх;

□ Барьцаа, торгууль, тодорхой эрхийг түр хязгаарлах, үүрэг амлалт, баталгаа батлан даалт, гэрийн хорио

тогтоох зэрэг арга хэмжээг түгээмэл хэрэглэх нөхцөлүүдийг хуульчлах;

□ Баривчлагдсан, цагдан хоригдсон хүний заавал эдлэх ёстой эрхүүдийг эдлэх нөхцөлийг нь баталгаатай хангах г.м.

Гадаадын өндөр хөгжилтэй зарим оронд дээрх зарчим, хэм хэмжээнүүдийг даган мөрдөж хэрэгжүүлж ирснээс гадна хүний эрхийг хангуулахад чиглэгдсэн эрүүгийн процессын эрх зүйн орчин нь харьцангуй тогтвортой байдаг нь нийтлэг байна.

ХБНГУ-д сэжигтэн яллагдагчид цагдан хорихоос өөр 10 шахам төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлдгээс мөнгө барьцаалах, гадаад паспорт болон иргэний үнэмлэхийг хураах, гэрийн хорионд (*электрон гавтай*) байлгах, тодорхой ажил гүйцэтгүүлэхээр даалгах зэрэг албадлагыг хэрэглэдэг байна. Германд сэжигтэн яллагдагчийг удаан хугацаанд заавал цагдан хорих явдлыг нэлээд хязгаарласан байдаг. *Германы Эрүүгийн процессын хуулийн 121-р зүйлд* зааснаар цагдан хорих арга хэмжээ нь хуульд заасан үндэслэлээр 6 сар хүртэл байх бөгөөд түүнээс цааш сунгахыг зөвхөн онцгой тохиолдолд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийддэг байна.

БНСУ-д хүнд биш гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах болон цагдан хорих арга хэмжээг авахаас аль болох зайлсхийж, ихэнхдээ онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зарим этгээдийн хувьд тодорхой нөхцөл үүссэн үед хэрэглэдэг ажээ.

Японы Үндсэн хуулийн 40-р зүйлд: “Баривчлагдаж цагдан хоригдсон хүн хэрэв тодорхой хугацааны дараа шүүхийн тогтоолоор хэрэг нь хэрэгсэхгүй болж, гэм буруугүй нь тогтоогдвол төрөөс хохирлоо арилгуулахаар нөхөн төлбөр гаргуулж болно” гэж заажээ.

Италийн Үндсэн хуулийн 13-р зүйлд: “...Баривчлах хойшлуулшгүй, яаралтай шаардлага гарсан үед шүүхийн зөвшөөрөлгүй 48 цаг хүртэл саатуулж, баривчилж болох боловч нотолгооны зайлшгүй нөхцөл хангагдахгүй бол уг хугацааг өнгөрснөөс хойш 8 цагийн дотор нэн даруй суллах арга хэмжээ авна” гэжээ.

Францын эрүүгийн процессын хуулийн 145.1-р зүйлийн “d”-д “...Эрүүгийн хуульд 5 жилээс дээшгүй, наад зах нь 1 жилээс доошгүй хорих ял бүхий гэмт хэрэг үйлдсэн байж болох этгээдийг дээд тал нь 4 сар хүртэл хугацаагаар цагдан хорьж болно. Харин 10 жилээс доошгүй хорих ял эдлэхээр заагдсан хэргийн хувьд онцгой тохиолдолд нэг жил хүртэл сунган цагдан хорино.” гэж



заажээ. Гэхдээ гол үндэслэл нь гарцаагүй бөгөөд бодит нотолгоонд тулгуурласан байх ёстой аж.

ОХУ-ын Эрүүгийн процессын шинэчлэгдсэн хуульд барьцаалах, гэрийн хорионд байлгах арга хэмжээ нэмж тусгасан бол *Аргентины Эрүүгийн процессын хуулийн 284.3-р зүйлд*: "...Баривчлах арга хэмжээг илт гэм буруутай нь газар дээрээ илчлэгдсэн буюу бодит баримтаар нотлогдсон үед авна..." гэсэн байна. Дээр дурдсан орнуудын болон гадаадын ихэнх орны Эрүүгийн процессын хуульд, эрүүгийн процессын албадлагын тогтолцоонд баривчлах болон цагдан хорих арга хэмжээг нийтлэг журам болгон хэрэглэхээс зайлсхийсэн нь түгээмэл байна.

АНУ-ын Дээд шүүхийн 1991 онд гаргасан удирдамжид зааснаар 48 цаг хүртэл шүүхийн зөвшөөрөлгүйгээр цагдаа баривчлах арга хэмжээ авч болно.

Харин шүүхийн зөвшөөрөлтэй, баривчлах, цагдан хорих үед гэрч, хохирогч сэжигтнийг таньж, мэдүүлсэн байхаас гадна шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг явуулж, нотлох баримтыг хэрхэн үнэлэх талаар мэтгэлцүүлсний үндсэн дээр шүүх шийдвэрлэж байхаар дурджээ. *АНУ-ын 1974 оны Шуурхай шүүхийн хуульд* зааснаар Цагдан хорих хугацааг 100 хоногоос хэтрүүлэхгүй байх жишиг, зарчмыг тогтоон мөрдөж иржээ.

Гадаадын хөгжингүй орнуудад хэвшиж тогтсон эрүүгийн процессын хандлага нь нэг талаас хүний эрхийн үнэт зүйлс, түүний халдашгүй байдлыг эрүүгийн процессын бүхий л үйл явцад тууштай хамгаалахад оршдог бол нөгөө талаас эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн хяналтыг үр нөлөөтэй, хүртээмжтэй, оновчтой хэрэгжүүлэхэд голлон чиглэгдэж байгаа нь анхаарал татаж байна.

Гурав. Эрүүгийн процессын албадлага хүний эрхээр хязгаарлагдах нь

Хорин нэгдүгээр зууны эхэн үеэс хүний эрхийн үнэт зүйлс, халдашгүй байдлыг процессын эрх зүйн суурь зарчмуудаар хамгаалж зохицуулах болсон нь эрүүгийн процессын эрх зүйд шинэтгэл хийж буй олон улс орны хууль тогтоомжид тусгалаа олсоор байна. Эдүгээ зөрчилдөөний дараах болон шилжилтийн үеийг туулж буй орнуудын эрүүгийн процесс нь урьдчилан яллах нөлөөлөл бүхий хүний эрхийн хязгаарлалтыг тогтоох аргаар хэрэгжих явдлаас бүрэн ангид байж чадахгүй байгаа билээ. Энэ нь

Пост Коммунист орнуудад ч хамааралтай юм.

Эрүүгийн процессын албадлагыг эрх зүйн бус арга, зарчмаар (*хуульд нийцээгүй агуулгаар*) хэрэглэх нь хүний эрхийг негатив хамаарлаар хязгаарлан зөрчих нөхцөлийг бүрдүүлдэг бол эрх зүйн дагуух буюу хуулийн агуулгад нийцсэн эрүүгийн процессын албадлага нь хүний эрхийг позитив хамаарлаар хамгаалахад чиглэгддэг. Эрүүгийн процессын албадлага нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэвийн саадгүй, шууд хэрэгжих нөхцөлийг хангах гол хэрэгсэл болдог хэдий ч хэргийн үнэн бодит байдлыг тогтоох, гэмт этгээдийг шуурхай олж илрүүлэх зорилгыг хангах үүднээс сэжигтэн, яллагдагчийн эрхийг хөндөх, хязгаарлах нөлөөлөл бүхий ажиллагааг зайлшгүй явуулдаг. Хүний жам ёсны халдашгүй эрхийн орчин, хүрээлэлд нэвтрэх, албадан нөлөөлөх нь эрх зүйн үр дагаврыг ямагт бий болгосоор ирснийг мартах учиргүй билээ.

Английн нэрт хуульч Альберт Дайси (*Disey Albert*) "...Хуулийг тогтоох төдийгүй түүнийг хэрэглэх үйл ажиллагаа нь хүний халдашгүй эрхээр ямагт хязгаарлагдах ёстой" гэж хэлсэн байдаг. Ер нь хууль сахиулах хүрэн дэх төрийн албадлагын бүх процесс хуулийн дагуу байх, тэр тусмаа шударга бус дур зоргийн үйлдлээс ангид байх практик тогтооход хүний эрхийг хамгаалах механизмыг зохистойгоор бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой.

Доктор, профессор Г.Совдын тэмдэглэсэнчлэн "...Хүний халдашгүй эрх нь хүн бүхэнд Үндсэн хуулиар баталгаажуулсан, хөндлөнгийн хэн боловч дур мэдэн халдаж болохгүй туйлын эрх бөгөөд энэ нь эрүүгийн процесст ихээхэн хамааралтай ойлголт юм."

Судлаачдын тэмдэглэснээр эрүүгийн процессын ажиллагаанд хамаарал бүхий хүний халдашгүй эрхийн голлох төрлүүдэд:

- 1) Хүний эрхэмсэг оршихуйн эрх;
- 2) Хүн өөрийн итгэл үнэмшилтэй байх эрх;
- 3) Хүний нэр төрөө хамгаалах, хамгаалуулах эрх;
- 4) Бусадтай чөлөөтэй харьцах эрх;
- 5) Хувийн нууц, хувийн амьдралын салшгүй эрх;
- 6) Орон байрны халдашгүй эрх;
- 7) Эмчилгээ, эрүүл мэндийн нууцын халдашгүй эрх;
- 8) Хувийн тэмдэглэл, хөтлөгчийн нууцын эрх;
- 9) Өөрийгөө өмгөөлөх эрх;
- 10) Шүүхэд гомдол гаргах, хэргээ шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрх
- 11) Эмнэлгийн үйлчилгээ тусламж авах эрх зэргийг эн тэргүүнд хамааруулдаг байна. Эдгээр эрх халдашгүй гэдгийг эрүүгийн процесст



хүлээн зөвшөөрдөг бөгөөд албадлагын арга хэмжээ, нөлөөлөл нь дээрх эрхэнд гүнзгий нэвтэрч халдах нөхцөлөөр хязгаарлагддаг байна.

Эрүүгийн процесс дахь хүний эрхийн хязгаарлалт нь эрх зүйн шалгуур бүхий дор дурдсан арга механизмаар дамжиж хэрэгжинэ. Үүнд:

а) Прокурорын мэргэжлийн удирдлага, хяналт;

б) Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, зөвшөөрлийн систем ба хяналт;

в) Өмгөөлөгч, хуульчдын хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа;

г) Хүний эрхийн болон төрийн бус байгууллагын хяналт, нөлөөлөл г.м.

Америкийн хүний эрхийн хуульч, профессор Дэвид Вейсброд: “Аливаа хүнийг гэмт хэргийн сэжигтнээр болон хохирогч, гэрчээр татахад ...ялангуяа эрүүгийн процессын шатанд оролцогч болсны хувьд тухайн хувь хүний эрх чөлөө нь хөндөгдөх, хязгаарлагдах, тэр тусмаа бусад үндсэн эрхээ алдах өндөр эрсдэлтэй байдаг...” гэсэн нь бий. Гэвч тухайн нөхцөлд хүний эрхийн асуудлыг туйлшруулан ойлгож болохгүй юм. Ер нь тухайн тодорхой хүний эрхийг хязгаарлаж байгаа нь нөгөө хүн мөрдөн шалгах зайлшгүй шаардлагаар эрхийг нь хөндөж, таслан сэргийлэх арга хэмжээ авдаг ба энэ нь шударга ёсны зарчимд нийцэх нь ойлгомжтой.

Эрүүгийн процессын албадлага хэрэглэх ажиллагааны эрх зүйн нөхцөлүүд нь Үндсэн хууль болон НҮБ-ын Хүний эрхийн Олон улсын гэрээ, конвенцуудаар хязгаарлагдах болсныг дурдах нь зүйтэй.

Дөрөв. Эрүүгийн процессын албадлага дахь тулгамдсан зарим асуудал

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн агуулга нь яллан нөлөөлөх ажиллагаанд илүү тулгуурласан байдаг нь өнөөгийн цаг үе, хүний эрхийн шаардлагатай илт зөрчилдөх болсон байна.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тайлан болон НҮБ-ын Хүний эрхийн байгууллагуудаас удаа дараалан гаргасан зөвлөмж, сануулгаас үзэхэд Монгол Улсад хүнд биш хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчийг оргон зайлж болзошгүй үндэслэлээр нийтлэг байдлаар (44,5 хувь) цагдан хорьдог, нотлох баримтгүй буюу бодит шалтгаангүйгээр цагдан хорих хугацааг олон дахин сунгадаг, байр сэлгүүлэн хорьдог, эрх нь хязгаарлагдсан хүнийг эрх зүйн байдлыг нь ашиглан мөрдөн

мөшгөх зэргээр нотлох ажиллагааг явуулдаг нь эрүү шүүлтийн шууд бус хэлбэрийн хүчин зүйлийг бүрдүүлсэн ба гүйцэтгэх болон хөтлөн байцаах аргыг нотлох процесст түгээмэл хэрэглэдэг болохыг нэг бус удаа онцлон тэмдэглэсээр иржээ.

Дээрх сөрөг хандлага нь эрүүгийн процесс дахь хүний эрхийн зөрчлийн илрэл, хүчин зүйл болсоор байгаа нь Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал болж байна.

Эрүүгийн процессын шатанд хүний халдашгүй эрхийг зөрчих, тэр тусмаа эрүүдэн шүүх аргаар хэргийг тулган хүлээлгэх, сэтгэл санааны дарамт шахалт үзүүлэх зэрэг хэрэг, зөрчил гарсаар ирснийг хараат бусаар мөрдөн шалгах үндэсний механизм Монгол Улсад өнөө хир хараахан бий болоогүй байна.

Монгол Улс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийн төслийг 2016 оны УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэж баталсан боловч эцсийн найруулга, редакцыг эцэслэн батламжаагүй өнгөрсөн. Гэхдээ энэ шинэ хууль 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас зарчмын ялгаатай бөгөөд ялангуяа эрүүгийн процессын албадлага хэрэглэх үеийн хүний эрхийн баталгааг хангахад чухал алхам болсныг дурдах ёстой. Шинэ хуулийн төсөлд “Эрүүгийн байцаан шийтгэх албадлага” гэсэн ойлголтыг өөрчилж, таслан сэргийлэх арга болгон шинээр тусгасан ба цагдан хорих арга хэмжээ авах эсэхийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэж байхаар тусгасан нь өмнө нь байгаагүй шинэ хандлага юм. Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх үндэслэлийг оновчтой болгож хуульчилснаас гадна төрлүүдийг нь өргөжүүлж, сонгох нөхцлийг нь тодорхой болгосон нь зөв зүйтэй алхам болсон. Барьцаа авах, торгох, бичиг баримтыг хураах, зорчих эрхийг хязгаарлах, баталгаа гаргуулах зэрэг арга хэмжээг нийтлэг байдлаар хэрэглэхээр тусгасны зэрэгцээ цагдан хорих арга хэмжээг хязгаарлаж, онцгой тохиолдолд хэрэглэх боломжийг бий болгожээ. Энэ хуулийн төсөл шинэ эрүүгийн хуультай яв цав уялдах ёстойгоос гадна тэдгээр хуулийг эцэслэн баталгаажуулж, дагаж мөрдөх хугацааг маш оновчтойгоор шинэчлэн тогтоож, хууль сахиулах үйл ажиллагаатай нягт уялдуулж, үр дүнтэй хэрэгжүүлэх явдал хойшлуулшгүй шаардлага болон тавигдаж байна.

Тав. Дүгнэлт

Эрүүгийн процессын албадлага хэрэглэх ажиллагаа нь шүүхийн өмнөх шатанд заавал хэрэгжүүлэх ёстой нийтлэг журам байх



ёсгүй бөгөөд түүнийг хуулийн зорилгод нийцүүлэхгүйгээр субъектив сэжиг таамгаар хэрэгжүүлэх нь хүний эрхийн стандарт зарчмыг зөрчихөд хүргэж байгаад дүгнэлт хийх ёстой.

Цагдан хорих замаар хөтлөн байцаах аргад тулгуурлаж нотлох ажиллагааг хэрэгжүүлэх нь хүний эрхийн зөрчил төдийгүй эрүү шүүлтийн шууд бус хэлбэрийн хүчин зүйл болох сөрөг үр дагавартайг анхаарах ёстой.

Орчин үед эрүүгийн процессын харилцаанд албадлагын хүчин зүйл нилээд хязгаарлагдах болсноос гадна харьцангуй уян хатан, сонголттой нөхцлөөр зохицуулагдах болсон ба НҮБ-ын Хүний эрхийн олон улсын суурь конвенцийг, эрүүгийн процессын болон хууль сахиулах тухай хуулиудад бүрэн тусгаж хэрэгжүүлэх нь зайлшгүй болж байна.

Цаашдаа хууль сахиулах хүрээнд эрүүгийн процессын албадлага хэрэглэх үеийн эрх зүйн шалгуур, хүний эрхийн шаардлага, стандартыг оновчтой болгох, энэ талаарх эрх зүйн тогтвортой, үр нөлөөтэй орчин бий болгон төлөвшүүлэх нь онол, практикийн чухал ач холбогдолтой юм.

Ашигласан ном, эх сурвалжууд:

1. В.Вандышев Уголовный процесс. М., 2013;
2. Л.В.Головко Альтернативы уголовному преследованию в современном праве. М., 2012;
3. Stephen C Thaman Comparative criminal procedure C., 2004;
4. Volker Krey Germany procedure law. B.B. 2009;
5. Model code of Criminal procedure. Viviene O.Connor and Colette. W.D.C.Boston. 2008;
6. Criminal procedure. A worldwide study. Edited by Craig M.Bradley. C.A.P.N.C. 2007;
7. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын илтгэл, тайлан УБ., (2011-2016);
8. Шударгаар шүүлгэх эрх. Гарын авлага. Эмнести интернейшнл. УБ., 2015;
9. НҮБ-ын Эрүү шүүлттэй тэмцэх хорооны тайлан, зөвлөмжүүд (англи хэлээр) 2011-2016;



CHINESE CASE LAW?
 – PRACTICE AND THEORY OF THE
 CRIMINAL GUIDING CASE SYSTEM
 ХЯТАДЫН ЖИШИГЧЛЭН ШИЙДВЭРЛЭХ
 ТУХАЙ ХУУЛЬ?

– ЭРҮҮГИЙН ГЭМТ ХЭРГИЙГ
 ЖИШИГЧЛЭН ШИЙДВЭРЛЭХ
 ТОГТОЛЦООНЫ ОНОЛ БА ПРАКТИК

WENBO PAN¹

Abstract: In 2011, the Supreme People's Court of China (SPC) introduced the concept of "guiding case system" into its judiciary practice. This establishment of a new system in China has begun a process of judicial reform which has streamlined the procedures of judiciary decisions in China.

However, since this system is relatively new, there currently exists certain problems that must be addressed. As such this article aims to explore and analyze the problems that have arisen due to the creation of a "guiding case system" and to identify what the system should be like in the future. In other words, this article aims to propose recommendations for further improvement of the "guiding case system".

Товч агуулга: 2011 онд БНХАУ-ын Ардын Дээд Шүүх "гэмт хэргийг жишигчлэн шийдвэрлэх тогтолцоо"-г өөрсдийн шүүх практикт нэвтрүүлсэн. Ийнхүү шинэ тогтолцоог байгуулснаар Хятад улс нь шүүхийн шийдвэр гаргах үйл ажиллагааг оновчтой болгох шүүхийн шинэчлэлийг эхлүүлсэн.

Гэвч, тухайн тогтолцоо нь харьцангуй шинэ учраас одоогоор зарим нэг тодорхой асуудлуудыг зайлшгүй авч үзэх шаардлага тулгамдаж байна. Тиймээс тус өгүүлэл нь "гэмт хэргийг жишигчлэн шийдвэрлэх тогтолцоо"-г байгуулснаар тулгамдаж буй асуудлуудыг авч үзэх бөгөөд ирээдүйд ийнхүү тогтолцоо нь ямар дүр төрхтэй байхыг тодорхойлох юм. Өөрөөр хэлбэл, энэхүү өгүүлэл нь "гэмт хэргийг жишигчлэн шийдвэрлэх тогтолцоо"-г цаашид улам боловсронгуй болгох зөвлөмжүүдийг санал болгоно.

Keywords: guiding case system, guiding case,

¹ The author is a doctoral student of the Max Planck Institute for Foreign and International Criminal Law in Freiburg, Germany.

² ХБНГУ-ын Гадаад орнуудын болон олон улсын эрүүгийн эрх зүйн судалгааны Макс-Планкын институтын докторант

judicial interpretation, adjudication, criminal case, criminal law.

Түлхүүр үгс: Гэмт хэргийг жишигчлэн шийдвэрлэх тогтолцоо, гэмт хэргийг жишигчлэн шийдвэрлэхэд баримтлах кейс, шүүхийн ойлголт, шүүхийн шийдвэр гаргах, эрүүгийн гэмт хэрэг, эрүүгийн хууль.

A. Introduction

In recent years, the Supreme People's Court ("the SPC") and the Supreme People's Procuratorate ("the SPP") of China issued several Guiding Cases which have raised public concerns. In terms of criminal offences, the SPC focused more on the criminal substantive law area, while the SPP gave more detailed description of the criminal procedure in its cases. However, the process of the Guiding Case system is just at the beginning, and it is still in its initial stage. Only from these limited Guiding Cases (The researchers of criminal law often focus on the cases which were released by the SPC) to have a glimpse of the whole Guiding Case system may be bloated, but it is still necessary to find the problems and the trend in the possible future from these few Guiding Cases: (1) Is there any practical effect in line with people's expectations of a new system at the beginning of creation? (2) Is it possible to run a better way and to avoid unnecessary detours? Although scholars have pointed out: "the establishment of the Guiding Case system has an important role in promoting the construction of the Rule of Law in China."² Or, "... the SPC's guidance of trials through specific cases will help provide in a timely manner guidance for new types of cases, cases of broad relevance to society and difficult cases. This will further regulate judicial behavior, unify the scales of justice, and have an important effect on regulating the discretionary power of judges."³ This article will pick up a few Guiding Cases, analyze potential problems, and try to point out, what the Guiding Case should be in the future.

B. The simple repetition or to solve the problem?

To produce a new system is to solve old problems. The combination between the Guiding Case system and the existing judicial interpretation system must be taken into account. Whether these two systems will play the same role or they will operate respectively in different areas is the most important issue that

² CHEN Xingliang: To establish far-reaching Guiding Case system, in *Legal Daily*, April 10, 2013.

³ LUO Dongchuan (Director of China Applied Legal Science Research Institute of the SPC), in *Legal Daily*, May 18, 2011.



the Guiding Case system faces. For example, from the Guiding Case No. 3 “PAN Yumei and CHEN Ning bribery case” released by the SPC, researchers found that the 4 main points of the adjudication in this case (R 1.1 – 1.4) completely overlap the existing judicial interpretations (R 2.1 – 2.4):⁴

R 1.1: A state functionary who exploits the advantages of office to seek benefits for an entrusting person and, together with the entrusting person, obtains “profits” in the name of “jointly organizing” a company but does not actually contribute capital or participate in the operation and management shall be punished for accepting bribes.

R 2.1: A state functionary who accepts “profits” in the name of jointly running a company or making any other jointly investment but does not make actual contribution and take part in the management and business operation in order to secure the benefit of the person by making use of his or her official status shall be punished for the acceptance of bribes.⁵

R 1.2: A state functionary who knows that a person has an entrusted matter and yet accepts his property shall be regarded as having promised to “seek benefits for others”. The determination of “accepting bribes” is not affected by whether benefits were actually sought for the other person or whether benefits were actually obtained.

R 2.2: The behavior “seek benefits for others” includes three stages – commitment, implement and achievement. As long as the behavior involves one stage, such as a state functionary depends on an entrusted matter raised by a person, promises to seek benefits for him and accepts his property, it has met the requirement “seek benefits for others.” Knowing that a person has a concrete entrusted matter while accepting his property shall be regarded as having promised to “seek benefits for others.”⁶

R 1.3: A state functionary who exploits the advantages of office to seek benefits for an entrusting person and purchases goods like houses from the entrusting person at obviously below-market prices shall be punished for accepting bribes. The amount of bribes accepted

⁴ CHEN Xingliang: Normative Study on the Guiding Case System, in Law Review, 2012 (3); ZHOU Guangquan: The Criminal Guiding Case System: Challenges and Prospects, in Peking University Law Journal, 2013 (3).

⁵ The SPC / SPP: The Opinions on Issues concerning the Application of Law in the Handling of Criminal Cases involving the Acceptance of Bribes (July 8, 2007), Article 3

⁶ The SPC: The Summary of the Symposium on the Trial of Cases concerning Economic Crimes (November 13, 2003), Article 3 (2).

is calculated in accordance with the difference between the local market price at the time of the transaction and the price actually paid.

R 2.3: A state functionary who accepts an item from a person in any of the following forms of transaction in order to secure benefits for such a person by making use of his or her official status shall be punished for the of acceptance of bribes:

(a) Purchasing any house, automobile or any other item from such a person at a price that is obviously lower than the market price;

...

The amount of bribe shall be calculated as per the difference between the local market price and the actual paid price at the time of transaction.⁷

R 1.4: The determination of the crime of accepting bribes is not affected by the fact that after a state functionary has accepted property, she, due to the investigation of individuals and matters connected to her acceptance of bribes, returns it to conceal the crime.

R 2.4: The return or surrender of an item by a state functionary after acceptance of a bribe for the purpose of covering up the crime because of any investigation of him or her or a related person or matter shall not affect its determination as a crime of acceptance of bribes.⁸

We can say that these 4 main points of the adjudication in the Guiding Case No. 3 merely repeat previous judicial interpretations. It is worth mentioning that, the phrase “seek benefits for others” (in Rule 1.2 and 2.2) has been always on the focus of controversy. Scholars summarized the understanding of “seek benefits for others” as subjective element theory, objective element theory, or the new objective element theory.⁹ Since then, other scholars put forward a new subjective element theory.¹⁰ According to the expression from Article 385 of the Chinese Criminal Law Code, “seek benefits for others” is actually more appropriate to be regarded as the objective element. However, in judicial practice “The Summary of the Symposium on the Trial of Cases concerning Economic Crimes” released by the SPC in 2003 has been pointed out: “Knowing that a person has

⁷ The SPC / SPP: The Opinions on Issues concerning the Application of Law in the Handling of Criminal Cases involving the Acceptance of Bribes (July 8, 2007), Article 1.

⁸ The SPC / SPP: The Opinions on Issues concerning the Application of Law in the Handling of Criminal Cases involving the Acceptance of Bribes (July 8, 2007), Article 9.

⁹ LI Hong: Criminal Law, Law Press, 2012, pp. 955.

¹⁰ See CHEN Xingliang: Judicial Determination of a New Type of Bribery: in the Light of Designating “PAN Yumei and CHEN Ning Bribery Case” as a Guiding Case, in Journal of Nanjing Normal University, 2013 (1).



a concrete entrusted matter while accepting his property shall be regarded as having promised to 'seek benefits for others'." Thus it has confirmed the subjective element theory. The second main point in "PAN Yumei and CHEN Ning bribery case" (Rule 1.2) actually confirms it once again.

It would appear that "PAN Yumei and CHEN Ning bribery case" does not solve old problems, all its main points can be found in previous judicial interpretations and decisions. Therefore, are the Guiding Cases of necessity? Scholars believe that the choice of "PAN Yumei and CHEN Ning bribery case" itself expresses a "political correctness"¹¹, just as the SPC has said in "The Notice of the SPC on Issuing the First Set of Guiding Cases" (December 20, 2011): "This case is highly significant for the punishment of bribe-taking crimes, the effective investigation and punishment of new forms of bribery cases, and the furtherance of the fight against corruption." However, if the Guiding Cases merely duplicate the existing judicial interpretations, when judges face the same problems, the citation of the Guiding Cases will be surely reduced, maybe they are no longer necessary to exist.

At this point, someone will argue: Even though the main points of the Guiding Case duplicate the judicial interpretations, the other parts of it still need to exist. This relates to the question below.

C. Distinguishing technique or the main points?

The Guiding Cases which were released by the SPC include 7 parts in sequence: number and title, keywords, main points of the adjudication, related legal rule(s), basic facts of the case, results of the adjudication and reasons for the adjudication.¹² Main points are really the core of the Guiding Cases. It sums up abstract rules based on the reasons for the adjudication, in order for the citation and reference in future cases. It seems to indicate that only main points of the entire Guiding Case are the most critical content, and the other parts are negligible. In fact, as far as Chinese judges are concerned, for too long they have been using such abstract terms of the statutory law or the judicial interpretations to deal with concrete cases. For them, the main points are sufficient to meet these actual needs, and

¹¹ ZHOU Guangquan: The Criminal Guiding Case System: Challenges and Prospects, in Peking University Law Journal, 2013 (3).

¹² HU Yunteng (Director of the Research Department of the SPC) etc.: The Style and Writing of the Guiding Cases, in People's Court News, April 11, 2012.

the reasons for the adjudication are just explanations of the main points, for reference purpose only.

Олон улсын жишгээс харахад, полиграфын сорилын үр дүнг шүүхийн практикаас гадна банк, санхүү болон бизнесийн салбар, хүний нөөцийн сонгон шалгаруулалт, мэдээллийн сан бүрдүүлэлт, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил зэрэг өргөн хүрээнд ашиглаж байна [8]. Тухайлбал, АНУ, Канад, Япон, Энэтхэг, Польш зэрэг улсад, полиграфын сорилын үр дүнг шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотолгооны түвшинд үнэлж байгаа бол зарим оронд (Израиль, Югослави, Швейцари зэрэг) бусад нотлох баримтын хамтаар чиглүүлэх байдлаар ашиглаж болохоор хуульчилжээ [Хавсралт 1-ийн Зураг 1].

Үүнээс гадна полиграфын үр дүнг ээдрээ төвөгтэй, нууц далд үйлдэлтэй, онц хүнд гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх ажиллагаанд түлхүү ашиглаж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд энэ чиглэлд тодорхой амжилт гаргаж буй орны нэг болох Беларусь Улсын Дотоод хэргийн яамны Эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгээс явуулсан судалгааны үр дүнгээс харахад, 2002-2011 оны хугацаанд, полиграфын тусламжтай нийт 25 мянгаад сорил явуулжээ. Үүний 3400 орчим нь гэмт хэрэг илрүүлэхэд үр дүнгээ өгсөнөөс, 700 гаруй нь хүн амины гэмт хэрэг эзэлж байна [10].

Судлаачдын үзэж байгаагаар, полиграфын сорилын эерэг үр дүнгийн үзүүлэлт 87-

96 хувь, зарим тохиолдолд 100 хувийн магадлалтай байж болохыг тогтоожээ [9].

Полиграфын салбарын эдгээр дэвшилтэй талын хажуугаар хүндрэл бэрхшээл мөн багагүй тулгарч байна.

Манай орны хувьд, хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллага болон полиграфын мэргэшилтэн бэлтгэх сургалтанд хамрагдсан ажилтан, албан хаагчидтай хийсэн уулзалт, ярилцлага, хэлэлцүүлгийн явцад, тэдгээрийн зүгээс гаргасан санал, хүсэлт мөн энэ чиглэлд туурвисан эрдэмтэн, судлаачдын бүтээл, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд хийсэн дүн шинжилгээг үндэслэн, полиграфыг Монгол Улсын хууль сахиулахын практикт нэвтрүүлж, үр дүнтэй ашиглах, цаашлаад уг салбарыг өөрийн орны онцлогт тохируулан сууршуулахад, тулгарч буй хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлыг дараах байдлаар томъёолов. Үүнд:

- полиграф ашиглах хууль, эрх зүйн орчин бүрдээгүй;
- полиграфын чиглэлээр шаардлагатай мэргэшилтэн бэлтгэгдээгүй;
- хэрэгцээтэй техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдаагүй;
- полиграфын сорил явуулах орчин нөхцөл бүрдээгүй;
- байгууллагын орон тооны болон зохион байгуулалтын асуудал нэг мөр шийдэгдээгүйгээс, уг мэргэжлийг хавсруулан гүйцэтгүүлэх зэрэг асуудал зонхилж байна.

Эдгээрээс полиграф ашиглах хууль, эрх зүйн зохицуулалт болон полиграфын чиглэлээр мэргэшилтэн сургаж, бэлтгэх асуудал чухалд тооцогдож байна.

Хууль, эрх зүйн хүрээнд, энэ чиглэлд өнөөдөр УЕПГ-тай зөвшилцөн ЦЕГ-ын даргын 2004 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 169 дүгээр тушаалаар баталсан “Полиграф түр ашиглах журам”-аас өөр эрх зүйн зохицуулалт үгүй байна. Тэгвэл “бодит үнэнийг тогтоох” гэсэн полиграфын тулгуур зарчим нь манай улсын хууль тогтоомжийн үзэл баримтлалтай нийцэж байгааг олон жишээ, баримтаас харж болохоор байна. Тухайлбал, Монгол Улсын ЭБШХ-ийн зорилтыг “аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангахад оршино” гэж тодорхойлсон бол мөн хуулийн 16 дугаар зүйлд “хэргийн байдлыг тал бүрээс нь бодитойгоор тогтоох” [1] гэж тусгасан зэрэг нь “гэмт хэргийн бодит байдлыг уламжлалт



болсон аргаар бус шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нотлон тогтоох ёстой” гэсэн хуулийн үзэл санааны илэрхийлэл юм.

Иймд полиграфын салбарыг тусгай мэдлэгийн хүрээнд хүлээн зөвшөөрч, хууль сахиулах болон шүүн таслах чиг үүрэгтэй байгууллагын практикт нэвтрүүлэх, үр дүнг бусад нотлох баримтын хамт үнэлж, дүгнэхэд, юуны өмнө хууль, эрх зүйн орчин чухал болохыг олон улсын төдийгүй үндэсний хуулийн үзэл баримтлал харуулж байна. Тухайлбал, полиграфыг идэвхтэй шүүмжилж, эсэргүүцэж байсан орны нэг болох, ОХУ-д өнөөдөр дараах субъектуудыг полиграфын сорилд хамруулж байхаар хуулийн төсөлд тусгасан байна. Үүнд:

☞ ① Улсын нууцтай холбоотой мэдээл авах болон мэдээллийн баазад нэвтрэх эрх бүхий иргэд;

☞ ② Дотоод хэргийн яам, Холбооны аюулгүй байдлын газар, Сөрөг тагнуулын газар, Сэтгэцэд нөлөөлөх, мансуурах бодисын эргэлтэнд хяналт тавих холбооны алба, Хууль зүйн яамны харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Батлан хамгаалах яамны салбар нэгжүүд, Гаалийн хорооны салбар нэгжүүд, Төрийн тусгай хамгаалалтын газар, Прокурорын байгууллага зэрэг албанд ажилд орохоор судлагдаж байгаа болон ажиллаж байгаа ОХУ-ын иргэд;

☞ ③ Онц чухал объектын харуул, хамгаалалтын ажилд орохоор судлагдаж байгаа ОХУ-ын иргэд зэрэг байхаар тус тус тусгажээ [2].

Хэдийгээр эрдэмтэн, судлаачдын зүгээс полиграфын үр дүнг нотлох баримтын түвшинд үнэлэх эсэх асуудал маргаан дагуулсаар байгаа ч, энэ чиглэлд хийх судалгаа, шинжилгээний ажлын цар хүрээ байнга өргөжин тэлсээр байна. Тухайлбал, полиграфын сорил явуулах үйл ажиллагаа нь хүний ой санамжинд хадгалагдсан далд, нуугдмал мэдээллийг ил болгож, тэдгээрийг үйл явдлын өрнөл болоод бодит байдалтай тохирч байгаа эсэхийг нягтлахад чиглэсэн цогц ажилбар юм. Тэгвэл уг үйл ажиллагааг гардан гүйцэтгэж буй субьектээс мөн зохих түвшиний тусгай мэдлэг шаардагдана. Иймд полиграфын сорил явуулах үйл ажиллагааг шүүхийн шинжилгээний нэгэн төрөл хэмээн хүлээн зөвшөөрч, үүнийг “криминалистикийн полиграф судлалын шинжилгээ” гэж нэрлэх нь зүйтэй гэж эрдэмтдийн нэг хэсэг нь үзэж байна.

Тэгвэл нөгөө талыг баримтлагчдын зүгээс,

полиграфын сорил явуулах ажилбар нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нэг төрөл болох таньж олуулах ажиллагаа болон криминалистикийн дүр зургийн шинжилгээтэй зарчмын хувьд төстэй. Гэхдээ эдгээр ажиллагааны гол зорилго нь криминалистикийн идентификаци буюу адилтгал (оросоор отождествление гэх) болон онош зүй (диагностика) явуулахад чиглэсэн байдаг бол, полиграфын сорилын үр дүн “магадлал бүхий шинжийг агуулсан байдаг” (оросоор – “носящий вероятный характер”) тул, түүнийг нотолгооны түвшинд үнэлж, ашиглах боломжгүй гэсэн байр сууринаас хандаж байна.

Иймээс гадаадын олонхи оронд, полиграфын сорилын үр дүнг, гол төлөв чиглүүлэх байдлаар, бусад нотлох баримтын хамтаар үнэлж, нотлох ажиллагаанд ашиглаж байна.

Нотлох ажиллагааны гол зорилго нь хэргийн бодит байдлыг хөдлөшгүйгээр тогтооход оршдог. Иймд хавтаст хэрэгт цугларсан нотлох баримт, түүний мэдээлэл хэр зэрэг бодитой эсэхийг нягтлахын тулд, тэдгээрийг тал бүрээс нь бүрэн дүүрэн судалж, шинжлэх шаардлага зүй ёсоор тулгардаг. Тэгвэл полиграфын төхөөрөмжийн тусламжтайгаар хүний ой санамжинд хадгалагдсан мэдээллийг үнэлж, дүгнэх үйл явц мөн энэ зарчмаар явагдах ёстойг олон жишээ баримт гэрчилж байна. Тухайлбал, үүний нэг илрэл нь АНУ-ын полиграф судлалын нийгэмлэгийн нэрийг “Мэдээллийн үнэлгээний академи” болгон өөрчилсөн явдал юм [7].

Судлаачийн зүгээс полиграфын сорилын үр дүнг нотлох ажиллагаанд ашиглахдаа “хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн шалгаж, хөдлөшгүйгээр нотлон тогтооно” гэсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан, бусад ул мөр, эд мөрийн баримтын хамт шалгаж, нягталсан тохиолдолд, харшлах зүйлгүй гэсэн байр суурийг дэмжиж байна.

Энэ чиглэлд мөн манай улсын хууль сахиулах салбарын эрдэмтэн, судлаачид өөрсдийн байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх нь зүйтэй юм. Учир нь тус салбарын хувьд, полиграфын онол, арга зүйг шинжлэх ухааны докторын түвшинд судалж, туурвисан цогц бүтээлтэй билээ [4]. Иймд уг давуу талыг ашиглан полиграфын мэдлэгийг хууль сахиулах салбарт төдийгүй, цаашлаад нийгмийн харилцааны бүхий л хүрээнд нэвтрүүлэх талаар үндэслэл бүхий



санал, зөвлөмж гаргах боломжтой юм.

Полиграфын судалгааны объектын өөр нэг онцлог нь хүний биеийн бүтэц болон сэтгэл зүйтэй холбоотой асуудлыг нэг дор, нэгтгэн судалж буйд оршино. Учир нь хүний ой санамжинд нуугдмал мэдээлэл байгаа эсэхийг тогтоохын тулд, түүний биеийн бүтэц, сэтгэл зүйг цогцоор шинжилж, судлахаас гадна хүний бодол санаа, дотоод ертөнцрүү нэвтрэх шаардлага зүй ёсоор тулгарна. Энэ утгаараа полиграфын судалгаанд танин мэдэхүйн мэдлэг зонхилон шаардагддаг болох нь харагдаж байна [4].

Иймээс хууль сахиулахын практикт шинэ техник технологи, онол, арга зүй нэвтрүүлэхийн зэрэгцээ уг орчин нөхцөлд дасан зохицох чадвартай мэргэшилтэн бэлтгэх шаардлагатай. Учир нь судлаачдын тооцоолсоноор, орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийн хувьсан шинэчлэгдэх үйл явцын давтамж, 5 жил тутамд 50 хувьтай тэнцэх хэмжээний хурдацтайгаар явагдаж байна гэж үзжээ [5].

Манай орны хууль сахиулах салбарын хувьд, полиграф судлалын мэргэшилтэн сургаж, бэлтгэх чиглэлд, гол төлөв ОХУ болон Казахстан Улсыг түшиглэж байна. Тухайлбал, 2013 онд эдгээр улсаас полиграфын сургагч-багш нарыг урьж ирүүлэн, хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллагуудаас гадна бусад төрийн болон төрийн бус байгууллагын нийт 20 ажилтан, албан хаагчийг хамруулан, 14 хоногийн сургалт зохион байгуулан, гэрчилгээ олгожээ. Уг арга хэмжээнд хамрагдсан субъектууд дотроос Хууль сахиулахын их сургууль (цаашид ХСИС гэх), Авилгатай тэмцэх газар (цаашид АТГ гэх), Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (цаашид СЭМҮТ гэх) зэрэг байгууллагууд ОХУ-ын "Поликонис" компанид үйлдвэрлэсэн "Диана-4" загварын полиграфын төхөөрөмжийг худалдан авсанаас гадна энэ төрлийн төхөөрөмжийг Цагдаагийн ерөнхий газар (цаашид ЦЕГ гэх), Тагнуулын Ерөнхий газар (цаашид ТЕГ гэх) тус тус ашиглаж байна. Энэ чиглэлд үүнээс өөр дорвитой ажил хийгдээгүй байна.

Эдгээр нөхцөл байдлаас гадна улсын чиг хандлагад тулгуурлан хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс харахад, полиграфын мэргэшилтэн бэлтгэх сургалтыг гол төлөв түргэлчилсэн буюу эчнээ хэлбэрээр явуулж байна. Үүнээс хамааран энэ чиглэлийн сургалтын хугацаа дунджаар 14 хоногоос 3 сар байна. Харин сүүлийн жилүүдэд, полиграф судлалын чиглэлд ихээхэн анхаарал хандуулах болсон тул,

энэ нь полиграфын сургалтын хэлбэрийг өөрчлөхөд хүргэв. Тухайлбал, Беларусь Улсын хувьд, энэ чиглэлийн сургалтын чанар болон суралцагчийн мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх үүднээс, түргэлчилсэн буюу эчнээ сургалтаас аль болох татгалзаж, сургалтын хугацааг 2,5-аас 3 жил болгон өдрийн хэлбэрт шилжүүлж, төгсөгчдөд Олон улсын полиграфчидын холбооноос хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий гэрчилгээ олгохоор болжээ.

Мөн түүнчлэн дээрх салбаруудад ашиглаж байгаа "Диана-4" төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дунджаар 8 жил бөгөөд "урт хугацаагаар хадгалах тохиолдолд, 6 сар тутамд нэг удаа ажиллуулж, тохиргоо хийнэ" гэсэн шаардлага хангагдахгүй байгаагаас гадна ОХУ-д өнөөдөр "Диана-7" загварын төхөөрөмжийг бүтээж, практикт нэвтрүүлээд байгаа тул уг төхөөрөмжийн техникийн үзүүлэлт болон хүчин чадал хоцрогдоход хүрээд байна [Хавсралт 2-ийн Зураг 1,2].

Судалгааны үр дүнд тулгуурлан, манай орны хууль сахиулах салбарын үйл ажиллагаанд полиграфыг нэвтрүүлж, ашиглахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх оновчтой арга замыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- полиграф хөгжсөн дэлхийн өндөр хөгжилтэй оронд мэргэжлийн полиграфологч буюу полиграф судлалын-мэргэшилтэн сургаж, бэлтгэх;
- хууль сахиулах салбарт полиграф ашиглах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх;
- полиграфын сорилгын асуулгыг технологийн шаардлагын дагуу боловсруулах;
- хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллагуудын бүтцэд, полиграф судлалын бие даасан нэгжийг байгуулах;
- полиграфын сорилгод орчин үеийн дэвшилтэд техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг судалж, ашиглах;
- полиграфын чиглэлээр хийх шинжилгээ, судалгааны ажлын цар хүрээг тэлж, эрдэм шинжилгээний бүтээл, ном, гарын авлага гаргах;
- Хууль сахиулах их сургуулийн хүний нөөц болон материаллаг баазыг түшиглэн "Полиграф судлалын сургалт-судалгааны нэгдсэн лаборатори" байгуулах [Зураг. 4,5] талаар төсөл боловсруулж, хэрэгжүүлэх зэрэг болно.

Эдгээр асуудлыг шийдвэрлэснээр, орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтын нэг болох, полиграф судлалын салбарыг өөрийн орны онцлог, монгол хүний сэтгэл



зүй, зан үйлд тохируулан нутагшуулж, үр дүнг хууль сахиулах салбарын хүний нөөцийг судалж сонгох, мэдээллийн сан бүрдүүлэх, цаашлаад ээдрээ төвөгтэй гэмт хэрэг, зөрчил, маргааныг шалгаж, шийдвэрлэхэд ашиглахын зэрэгцээ хууль сахиулах практикт шинэ техник технологи, арга зүй, арга аргачлал нэвтрэх боломж бүрдэнэ гэж үзлээ.

Иймд энэ чиглэлд хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын цар хүрээг тэлж, уг асуудлыг цогц авч үзэх шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын ЭБШХ /[http: www.legalinfo.mn/](http://www.legalinfo.mn/)
2. Федеральный закон о применении полиграфа. //Государственный бюллетень. Редакция от 07.12.05.
3. Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр. Монгол Улсын Их хурлын 1998 оны 18 дугаар тогтоол. УБ.
4. Болдбаатар Ж. Гэмт хэрэг илрүүлэхэд полиграфыг ашиглах онол, арга зүйн асуудал: Шинжлэх ухааны докторын диссертаци. УБ. 2013.
5. Варламов В. А. Детектор лжи. Изд-во: "ПЕР СЭ" М. 2004.
6. Князев В.М. "Детектор лжи" на страже истины Учеб. пособ. - М.: "Принт-Центр". 2009. – с. 354.
7. Князев В.М. Полиграф и его практическое применение. Учеб. пособ. - М.: "Принт-Центр". 2012. – с. 859.
8. Пеленицын А.Б. Основные трудности и проблемы использования полиграфа в правоохранительной деятельности и кадровой работе и рекомендуемые пути их преодоления /Материалы международной научно-практической конференции "Актуальное состояние и перспективы развития метода инструментальная «детекция лжи» в интересах государственной и общественной безопасности". (2-4 декабря 2008 года).
9. Холодный Ю. И. Криминалистическая полиграфология и ее применение в правоохранительной практике. Информационный бюллетень № 21 по материалам криминалистических чтений «Запросы практики – движущая сила развития криминалистики и судебной экспертизы». Академия управления МВД России. 2003. С. 14-9.


От преступников до приходящих нянь: кого тестируют на детекторе лжи? <http://www.interfax.by/article/93972>. Хэл - орос, чөлөөт веб сайт. 2015.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ХАВСРАЛТ


Хавсралт 1

д/д	Улсын нэр	Полиграф ашиглаж эхэлсэн он
1	АНУ	1921
2	Канад	1923
3	ОХУ	1923
4	Япон	1930
5	Хятад	1940
6	Өмнөд Солонгос	1950
7	Балкан бүсийн улс	1959
8	Израиль	1959
9	Польш	1964
10	Энэтхэг	1973
11	Венгри	1978
12	Турк	1984
13	Беларусь	2008

Зураг 2. Полиграфын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд



Зураг 4.5. Полиграфын өрөөний зохион байгуулалтын бүдүүвч





**ШИНЖИЛГЭЭГ ШҮҮХИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГААС
ГАДУУР
ХИЙЛГЭХЭД ТУЛГАМДАЖ БАЙГАА
АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

**THE PROBLEMS OF REQUESTING OUTSIDE
THE STATE FORENSIC INSTITUTIONS
FOR FORENSIC EXAMINATION, THE AP-
PROACH TO RESOLVE THESE PROBLEMS**

Т.ОЧИРБАТ

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа, докторант

Б.БАТМЯГМАР

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Стратеги, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа, докторант

Товч агуулга: Монгол Улсын шүүхийн шинжилгээний хууль тогтоомжоор шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаар хийлгэх, шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх тухай асуудлыг зохицуулсан.

Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх нь хэрэг шийдвэрлэх ажиллагааны практикт хамгийн тулгамдсан асуудал болж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Үүнийг шийдвэрлэх арга зам нь шинжилгээний байгууллагаас гадуур шинжээчээр томилогдон ажиллах боломжтой, тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжилтний бүртгэлийн тогтолцоог бий болгож ашиглах асуудал юм.

Abstract: Mongolian law of Forensic Services regulates the matter of whether send request of forensic examination to state forensic institute or to outside the state forensic institutions.

According to this research requesting outside the state forensic institutions for forensic examination has become problem for practice of case trial.

The approach to resolve this problem is to create a registration system of specialized expert from outside the state forensic institutions, who can do the forensic examination.

Түлхүүр үгс: шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллаар хийлгэх;

шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх.

Key words: state forensic experts; other experts.

Нэг. Оршил

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан “шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаар хийлгэх” тухай заалт нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд шинжилгээ хийлгэх тулгуур хэм хэмжээ болдог. Харин “шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэх” зохицуулалтын хүрээнд тусгай мэдлэг эзэмшсэн, шинжилгээний байгууллагад ажилладаггүй хүнийг шинжээчээр томилон ажиллуулах боломжтой юм.

Эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг шийдвэрлэх ажиллагааны явцад шинжилгээ хийлгэх хэрэгцээ жил ирэх тутам өсч байгаа нь тоо баримтаас харагдаж байна. Тухайлбал, шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээний тоо сүүлийн 5 жилд 47 хувиар өсчээ. Үүний зэрэгцээ шинжилгээний байгууллагаас гадуур янз бүрийн асуудлаар шинжээч томилох шаардлага нэмэгдэж байгаа нь шүүхийн шинжилгээний практикт тулгамдаж байгаа олон асуудлыг нэг юм. Түүнчлэн шинжилгээний байгууллага болон шинжилгээний байгууллагаас гадуур томилогдсон шинжээч хамтарсан шинжилгээ хийх тохиолдолд түүнийг зохицуулсан хэм хэмжээ, зохион байгуулалтын хэлбэр тодорхойгүй байна.

Энэ судалгааны ажлаар шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх асуудлыг өнөөгийн практикт хэрхэн шийдвэрлэж байгаад дүн шинжилгээ хийх, цаашид эрх зүй, зохион байгуулалтын хувьд хэрхэн шийдвэрлэх нь оновчтой болохыг судалж, санал зөвлөмж боловсруулахыг зорилгоо.

Хоёр. Өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын шүүхийн шинжилгээний хууль тогтоомжид зааснаар шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх, шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх гэсэн хоёр үндсэн хэлбэр байдаг. Шүүхийн шинжилгээний байгууллагаар хийлгэх гэдэг нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд зохих шинжилгээг хийлгэх шийдвэр гаргаж шүүхийн шинжилгээний байгууллагад буюу манай улсын хувьд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд шинжилгээ хийлгэхээр даалгаж байгаа явдал. Харин шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур



шинжлэх ухаан, техник, урлаг, урлахуйн тусгай мэдлэг эзэмшсэн хүнийг шинжээчээр томилон ажиллуулж болно. Үүнийг Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлээр зохицуулсан. Тус зүйлийн 9.1-т заахдаа “шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай шийдвэр /тогтоол, захирамж, хүсэлт/ гаргаж шинжилгээ хийхээр томилогдож байгаа шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил, чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана” гэжээ. Дээрх ажиллагааг явуулсны дараа шинжилгээ хийлгэхэд харшлах шалтгаан байхгүй гэж үзвэл түүнийг шинжээчээр томилж дүгнэлт гаргуулах журамтай.

Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаар хийлгэх тохиолдолд хүндрэлтэй асуудал тохиолдож байгаа ч гэсэн түүнийг улсын хэмжээнд эрхлэн явуулах байгууллага нэгэнт байгаа тул шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх механизм нь тодорхой юм.

Харин шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэх тохиолдолд хүндрэлтэй асуудал нэлээд тохиолдож, энэ нь хэрэг шийдвэрлэх ажиллагаанд бодит бэрхшээл болсоор удаж байгаагийн зэрэгцээ уг асуудлыг тодорхой үндэслэлтэй судлах, цаашид эрх зүйн орчныг сайжруулах, зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байгууллага тодорхойгүй байгаа нь байдлыг улам хүндрүүлсээр байгаа юм. Үүний баталгаа нь сүүлийн жилүүдэд шинжилгээ хийлгэх эрх бүхий субъект болох шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, түүний зэрэгцээ эрүүл мэндийн яам, мэргэжлийн хяналтын газар, барилгын хөгжлийн төв /зарим мэргэжилтнүүд нь шүүхийн шинжилгээнд татагдан оролцдог/ зэрэг байгууллагууд дээрх асуудлаар бие биедээ хүсэлт, шаардлага хүргүүлж байгаагаас харагдаж байна. Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд уг асуудлаар ЦЕГ-ын МБГ, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх, Эрүүл мэнд, спортын яамнаас хандсан албан бичгүүдээс үзвэл шинжилгээний байгууллагаас гадуур хийгдэж байгаа шинжилгээнд анхаарал хандуулахыг хүссэн утгатай байна¹. Тухайлбал Эрүүл

мэнд, спортын яамнаас ШШҮХ-д ирүүлсэн албан бичигт “шүүхийн шинжилгээний төв байгууллагын зүгээс шинжээчээр ажиллах эмч нарыг сонгон гэрээ хийж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 99, 100 дугаар зүйлд заасны дагуу шинжээчийн зардал, ажлын хөлсийг олгож ажиллах боломж, нөхцөлийг судлан шийдвэрлэж өгөхийг хүсье” гэжээ.

Бид энэ чиглэлээр эрүү, иргэн, захиргааны процесс ажиллагааг хэрэгжүүлэгч субъект болох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч нарын дунд анкетын судалгаа хийж үзлээ. Судалгаанд 114 албан тушаалтан хамрагдсаны 51,7 хувь нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, 8,7 хувь нь эрүүгийн хэргийн шүүгч, 21,9 хувь нь захиргааны хэргийн шүүгч, 17,5 хувь нь иргэний хэргийн шүүгч хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан албан тушаалтнуудын 88,2 хувь нь шинжилгээний байгууллагаас гадуур шинжээч томилж дүгнэлт гаргуулахад олон янзын бэрхшээл тулгардаг гэж хариулсан байх бөгөөд тэдгээрийг багцалж үзвэл шинжээчээр томилж ажиллуулах шаардлагатай мэргэжилтнийг олох /58,8%/, дүгнэлт гаргасан шинжээчийн зардлыг төлөх /70,5%/ асуудал зонхилж байна. Мөн хугацаа их шаарддаг, хүнд сурталтай, төлбөрийг шилжүүлсний дараа дүгнэлт гаргаж өгнө гэсэн шалтгаанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулдаг, итгэхэд бэрх, бусдын нөлөөнд автах магадлалтай, хэргийн материал өгч явуулж болдоггүй, хэд хэдэн шинжээч томилсон тохиолдолд нэг дор цуглуулахад хүнд гэх мэт асуудлыг онцлон дурдсан байна.

Шинжилгээний байгууллагаас гадуур ямар чиглэлийн шинжилгээг хийлгэх шаардлага зонхилж байгаа талаар асуултад судалгаанд хамрагдагсдын 80 хувь нь инженерийн чиглэлийн шинжилгээ; 50,5 хувь нь эдийн засгийн чиглэлийн шинжилгээ; 22 хувь нь шүүх эмнэлгийн болон сэтгэцийн; 17,6 хувь нь биологийн; 15,2 хувь нь хөрс судлалын шинжилгээ; 5,8 хувь нь криминалистикийн; 5,8 хувь нь хөдөө аж ахуйн чиглэлийн шинжилгээ гэж хариулжээ. Судалгааны дүнд бас нэг сонирхолтой тоо баримт харагдаж байгаа нь шинжилгээний байгууллагаас гадуур томилогдсон шинжээчийн дүгнэлт нотлох баримтын хэмжээнд хэр зэрэг үнэлэгддэг тухай асуудал юм. Тэдний 12,9 хувь нь нотлох баримтаар үнэлэх боломжгүй байдаг гэсэн бол 55,2 хувь нь зарим үед нотлох баримтын хэмжээнд үнэлэгддэг гэсэн байна. Ямар учраас нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломжгүй байгаа талаар хариулахдаа судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь буюу 29,3 хувь

¹ ШШҮХ-ийн архив. ЦЕГ-ын Мөрдөн байцаах газрын 2016.04.07. 11/2038 тоот албан бичиг, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.03.11. 1/2814 тоот албан бичиг. ЭМСЯам. 2016.04.15. 10/1576 тоот албан бичиг.



нь дүгнэлт ойлгомжгүй байдаг; 27,5 хувь нь асуултад бүрэн хариулт өгдөггүй; 27,5 хувь нь шинжээчийн дүгнэлт бичиг тогтсон стандарт байдаггүй; 15,5 хувь нь шинжилгээ хийсэн арга, аргачлал тодорхойгүй гэсэн бол цөөнгүй хувь нь хөндлөнгийн нөлөөнд автах магадлал өндөр гэсэн байна.

Анхаарал татахуйц бас нэг зүйл байгаа нь “шинжилгээ хийх эрхтэй болохыг илтгэх лицензийн баримт бичиг байдаггүй” гэсэн утгатай хариултыг зарим шүүгчдийн зүгээс өгсөн явдал юм. Бидний үзэж байгаагаар энэ хариулт нь тусгай мэдлэг эзэмшсэн хэнийг ч шинжээчээр томилж болох тухай ойлголт нийгмийн хөгжлийн явцад эвдэгдэж байгааг харуулж байна.

Мөн дээрх асуудлаас гадна шинжилгээний байгууллагын шинжээч шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчтэй хамтарсан шинжилгээ хийх, шинжилгээнд мэргэжлийн туслалцаа авдаг асуудлыг дурдахгүй өнгөрч болохгүй юм. Үүнийг хууль тогтоомжоор зохицуулаагүйгээс тодорхой бэрхшээл байнга үүсч байна. Жишээ нь шүүх эмнэлгийн чиглэлээр шинжилгээ хийхэд зарим нарийн мэргэжлийн эмч нарыг шинжилгээнд оролцуулах шаардлага тулгардаг. Шүүхийн шинжилгээний байгууллагад шүүх эмнэлгийн чиглэлээр, түүний дотор хэргийн материалаар хийсэн шинжилгээний 10 орчим хувьд нь нүдний, дүрс оношлогооны, эх барих, гэмтэл, хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийг шинжээчээр оролцуулах шаардлага тулгарчээ. Ийм тохиолдолд шинжилгээний байгууллага эрх бүхий этгээдээс ирүүлсэн шинжилгээг хийхээс “түдгэлзэж” буцаахаас аргагүйд хүрдэг бөгөөд, цаашилбал мөрдөн байцаагч зохион мэргэжилтнийг олж томилохоор ЭМСЯаманд хандах, үүний дараа мэргэжилтнээр санал дүгнэлт гаргуулан шинжилгээний байгууллагад хүлээлгэн өгөх, улмаар шинжилгээний байгууллага нэгдсэн дүгнэлт гаргах зэрэг үе шатыг дамжих болж байна. Дээрх үе шатанд “түдгэлзэж” гэж тодотгосны учир нь Шүүхийн шинжилгээний тухай хууль тогтоомжид байгаа шинжилгээ хийхээс татгалзах тухай ойлголтоос огт өөр шалтгаанаар шинжилгээг буцааж байгаа, өөрөөр хэлбэл бүрэн буцаагаагүй гэдгийг илэрхийлж байна.

Гурав. Судалгаа, туршлага

Нөхцөл байдлаас дүгнэлт хийхэд шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй этгээдийг шинжээчээр томилж шинжилгээ хийлгэх, шинжилгээний байгууллага тухайн байгууллагад ажилладаггүй мэргэжилтэнтэй хамтарсан /бүрэлдэхүүнтэй, комплекс/ шинжилгээ хийх эрх зүйн орчныг бий болгох

зайлшгүй шаардлагатай болох нь илэрхий байна. Энэ ажлын хүрээнд зохих шинжилгээг хийлгэхэд шаардлагатай тусгай мэдлэгийн хүрээг /мөн шинжилгээний байгууллагад ажилладаггүй мэргэжилтний тусгай мэдлэг/ тодорхойлох арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх субъектийн асуудлыг зайлшгүй авч үзэх ёстой.

Энэ нь практик ажилтнуудад хамгийн тулгамдсан асуудал болж байгаа боловч манай эрдэмтэн, судлаачид онол, арга зүй, эрх зүй-зохион байгуулалтын талаас нь авч үзсэн судалгааны ажил ховор байна. Доктор Бө.Бат-Эрдэнэ судалгааны ажлын хүрээнд авч үзэхдээ “Монгол улсын эрүүгийн процессын хууль тогтоомжоор шинжээч томилж байгаа этгээд шинжилгээг шинжилгээний байгууллагаар² эсвэл шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэж байгаагаас үл хамааран шинжээчийн мэдлэгийн хүрээг тодорхойлох шаардлагатай болдог. Энэ нь тухайн хүмүүсийн ажлыг улам төвөгтэй болгох нь гарцаагүй”³ гэсэнтэй бид санал нэг байна.

Энэхүү тулгамдаж байгаа асуудал зөвхөн Монгол Улсын шүүхийн шинжилгээний практикт тохиолдож байгаа асуудал биш гэдэг нь бусад улс орнуудын туршлагаас харагдаж байна. Ийм учраас эх газрын эрх зүйн тогтолцоотой, хуулийн байгууллагын систем, түүхэн хөгжил ойролцоо улс орнууд тулгарч буй бэрхшээлийг даван туулж байгаа туршлага бидэнд тус болох нь эргэлзээгүй. Энэ асуудлыг эрх зүй, зохион байгуулалтын хувьд шийдэж, тодорхой үр дүнд хүрч байгаа зарим улсаар жишээ авъя. Эстони улсын Шүүхийн шинжилгээний тухай хуульд шинжээчийн эрх зүйн байдал, шүүхийн шинжилгээний төрийн байгууллагын эрх хэмжээг зохицуулснаас гадна “officially certified expert” буюу албан ёсоор баталгаажсан шинжээч, түүний хөлсийг хэрхэн төлөх тухай⁴ асуудлыг нарийн зохицуулсан байна. Шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчид эрх олгох, цуцлах, нэрсийн жагсаалтыг нийтэд мэдээлэх, нэвтрэх эрх олгох, ашиглах зэрэг харилцааг дээрх хэм хэмжээний актаар зохицуулжээ.

Мөн ОХУ дээрх асуудлыг шийдэх оролдлогыг 20-иод жилийн өмнөөс хийж эхэлсэн байх бөгөөд тухайн үед мөрдөн байцаагчдын дунд явуулсан судалгаагаар судалгаанд хамрагдагсдын 26 хувь нь

² Судалгааны ажил 2009 онд батлагдсан Шүүхийн шинжилгээний тухай хууль мөрдөгдөж эхлэхээс өмнө хийгдсэн тул шүүхийн шинжилгээний байгууллагаар шинжилгээ хийлгэх заалтыг 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар авч үзсэн байна.

³ Б.Бат-Эрдэнэ. Статус специалиста и эксперта в судопроизводстве Монголии. М., 2009. 48 дахь тал.

⁴ Forensic examination act of Estonia. 2002.01.01. Бүлэг 3, 5.



шинжилгээний байгууллагаас гадуур шинжээч томилох тохиолдолд тэднийг олж сонгох нь бэрхшээлтэй байдаг талаар хариулж байжээ⁵. 2001 онд баталсан ОХУ-ын "Төрийн шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай"⁶ хуулийн 15 дугаар зүйлд шинжилгээний байгууллагын дарга "шинжилгээ хийхэд шаардлагатай тусгай мэдлэг бүхий, тухайн байгууллагад ажилладаггүй шинжээчийг оролцуулж өгөх хүсэлтийг шинжээч томилсон этгээдэд гаргах эрхтэй" гэж заасан байна. Мөн түүнчлэн "шинжилгээ хийлгэхийг даалгасан тогтоол, захирамжид заасан өөр байгууллагыг оролцуулан шүүхийн шинжилгээ хийх ажиллагааг зохион байгуулах" эрхийг шүүхийн шинжилгээний байгууллагын даргад олгосон нь өнөөдөр манай улсын хуулийн байгууллагуудад тулгамдаж байгаа асуудлыг шийдэхэд нэн шаардлагатай туршлага болж байна.

Харин одоо хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа ОХУ-ын "Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухай" хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал нь одоо мөрдөгдөж байгаа хуулиас эрс ялгаатай байх бөгөөд зөвхөн шүүхийн шинжилгээний төрийн байгууллагын үйл ажиллагаа бус шүүхийн шинжилгээний улсын хэмжээний үйл ажиллагааг хамарсан дэд бүтцийг бий болгох санаа агуулж байна. Төсөлд шинжээч томилох эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх зорилгоор шинжилгээний байгууллагаас гадуур шинжээчээр томилогдох боломжтой мэргэжилтнүүдийн бүртгэл хөтлөх, зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, аттестатчилал явуулах, зардлыг олгох зэрэг харилцааг зохицуулах заалт⁷ орсон нь шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ томилох тулгамдсан асуудлыг нэлээд хэмжээгээр хөнгөвчлөхөөр төсөөлөгдөж байна. Тухайлбал төслийн 18 дугаар зүйл /шүүхийн шинжээчийн улсын бүртгэл/-д шинжилгээ хийх үйл ажиллагаанд хяналт тавих, шинжээч томилох эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх зорилгоор тусгай мэдлэг эзэмшсэн, шинжилгээ хийх эрх авсан хүмүүсийн талаарх мэдээллийг шүүхийн шинжээчдийн улсын бүртгэлд оруулахаар заасан байна.

АНУ, Канад, Австрали зэрэг англосаксоны эрх зүйн бүлд хамаарах эрх зүйн тогтолцоотой улс орнуудад "шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх",

⁵ Муженская Н. Е. Производство судебных экспертиз вне государственных судебно-экспертных учреждений. "Законность". 2011. N 12.

⁶ "О государственной судебно-экспертной деятельности в Российской Федерации". 2001.

⁷ "О судебно-экспертной деятельности в Российской Федерации". Проект. 2016.

"шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх" гэсэн ойлголтыг төрийн шинжилгээний байгууллага, хувийн шинжээч гэдэгтэй дүйцүүлэн ойлгож болно. Монгол Улсад шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэх тухай хуульчлан заасан боловч түүнийг хэрхэн гүйцэтгэх тухай нарийн журам байдаггүй. Харин "АНУ-д хувийн шинжээчийн үйл ажиллагааг процессын хуулиар зөвшөөрсөн байдаг нь шинжилгээ хийх үйл ажиллагааны гол ялгаатай тал юм. Төрийн шинжилгээний байгууллагын шинжээч болон хувийн шинжээч нар нь Шинжээчдийн хорооноос олгодог адил тэгш тусгай зөвшөөрөл авсан байх журамтай байдаг. Тэдний гаргасан дүгнэлтийг шүүх адил тэгш байдлаар авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгдөг"⁸ гэж доктор Г.Ганзориг тодорхойлжээ.

Мөн төрийн шинжилгээний байгууллагаар шинжилгээ хийлгэх зорилгоороо ялгаатай байна гэж бид үзэж байна. Жишээлбэл, "АНУ-д эрүүгийн хэрэгт анхны шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааг мөрдөн байцаах байгууллагын хүсэлтээр төрийн байгууллагын харьяа шинжилгээний байгууллага гүйцэтгэдэг. Түүнийг яллагдагч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл шинжилгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий шинжээчийг хөлслөн авч яллагдагч тал хөлсийг төлж шинжилгээ хийлгэдэг байна"⁹. Харин Монгол Улсын хувьд шинжилгээний төрийн байгууллагад зохих шинжилгээг хийх чадавхтай лаборатори, тусгай мэдлэгтэй шинжээч байхгүй тохиолдолд ихэвчлэн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэж байна.

Энд бид АНУ-ын туршлагыг бусад улсынхаас илүү байна гэж шууд дүгнэх боломжгүй байна. Учир нь, хэрвээ эдгээр туршлагыг судалж нэвтрүүлэх шаардлагатай гэж үзвэл тухайн улсын төрийн байгуулал, эрх зүйн тогтолцоо, шүүхээр хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зарчмын ялгаатай байдлыг зайлшгүй харгалзан үзэж, болгоомжтой хандах шаардлагатай юм.

Дөрөв. Асуудлыг шийдэх оролдлого

Манай улсын хувьд дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байгаа жишээ цөөнгүй байна. Тухайлбал 2016 оны 3 сараас 9 сар хүртэл хугацаанд шинжилгээний байгууллагаас гадуур шинжээч томилох журмаар хийлгэсэн инженер техникийн 37, амьтан судлалын 1, ургамал судлалын 1 шинжилгээг хийхэд шүүхийн шинжилгээний байгууллага арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг

⁸ Г.Ганзориг. Хүний эрх, эрх чөлөө-шүүхийн шинжилгээ. Өгүүлэл. УБ. 2015.

⁹ Мөн тэнд.



үзүүлж ажиллажээ. Эдгээр шинжилгээг хийхэд юуны өмнө хуулийн ямар заалтыг үндэслэсэн болохыг анхаарах ёстой. Үүнийг инженер техникийн шинжилгээн дээр жишээ авч үзье. Инженер техникийн шинжилгээний дийлэнх хувь нь барилга-инженерийн шинжилгээ бөгөөд тэдгээрийг Захиргааны хэргийн шүүхээс ирүүлсэн байна. Шинжилгээ хийх үйл ажиллагааг үе шат, хуулийн зохицуулалтаар нь бүлэглэж үзвэл:

1. Захирамж гаргах үе шат /ЗХШХШТХ-ийн 40 дүгээр зүйл, ШШТХ-ийн 8 дугаар зүйл буюу “Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаар хийлгэх”/;

2. ШШҮХ-ийн эрх бүхий албан тушаалтан /ШБМХ/ тухайн шинжилгээг хийхэд шаардлагатай тусгай мэдлэгийн хүрээг тодорхойлох /зохицуулсан хэм хэмжээ байхгүй/;

3. Шүүхийн шинжилгээний байгууллага тухайн байгууллагад ажилладаггүй боловч зохих чиглэлээр тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжилтний нэрийг санал болгох. Ингэхдээ ихэвчлэн хамтын ажиллагаатай эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зэрэг байгууллагад ажилладаг хүний нэрийг хүргүүлнэ /зохицуулсан хэм хэмжээ байхгүй/;

4. Шүүхээс дээрх мэргэжилтнүүдийг судалж, татгалзах шалтгаан байхгүй гэж үзвэл шинжээчээр нэр заан томилж дахин захирамж гаргах /Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйл/;

Ингэхдээ шинжилгээнд шүүхийн шинжилгээний байгууллагын зүгээс шинжээч оролцуулж арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг захирамжид тусгах /зохицуулсан хэм хэмжээ байхгүй/;

5. Шүүхийн шинжилгээний байгууллага гадуур томилогдсон шинжээчид арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэн ажиллаж, шинжилгээ хийх үе шатыг баримтлан, шинжилгээг зохих арга зүйн дагуу явуулж, шинжээчийн дүгнэлтийг шаардлага хангахуйц байдлаар гаргаж байгаад хяналт тавьж ажиллана. Мөн шинжилгээний байгууллагаас гадуур томилогдсон шинжээчийн ажилласан цаг, зарцуулсан материал, үнэ тарифт хяналт тавих /зохицуулсан хэм хэмжээ байхгүй/;

6. Шинжилгээний байгууллагаас гадуур томилогдсон шинжээчийн ажлын хөлс, шинжилгээний бусад зардлыг гаргуулах хүсэлтийг шүүхэд хүргүүлэх /зохицуулсан хэм хэмжээ байхгүй/;

7. Шүүх тухайн хэргийн нэхэмжлэгчээс зардлыг гаргуулан шинжээчид шилжүүлэх¹⁰ /ЗХХШТХ 44 дүгээр зүйл/;

¹⁰ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн

Дээрх байдлаас дүгнэж үзвэл хуулиар зохицуулагдаагүй зарим харилцааг шүүгчийн захирамж, байгууллага хоорондын албан ёсны хүсэлтээр зохицуулж байгаа байдал харагдаж байна. Энэ асуудлыг өнөөгийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бүрэн шийдвэрлэх боломжгүй байгаа тул эхний ээлжинд журмаар зохицуулах боломжтой гэж үзэж, судалгааны явцад “Орон тооны бус шинжээч ажиллуулах журам”-ын төслийг боловсруулсан. Уг төсөлд тусгаснаар журмын зорилго нь шинжилгээний байгууллагаас гадуур шинжээч томилоход арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, шинжилгээний байгууллагад ажилладаггүй мэргэжилтнийг шинжээчдийн бүрэлдэхүүнд оруулж дүгнэлт гаргуулах, зохих шинжилгээ хийхэд мэргэжлийн туслалцаа авах нөхцөл, журмыг тогтооход оршиж байгаа юм. Энэхүү журмын төсөл дараах 8 зүйлээс бүрдэж байна. Үүнд:

☐ Нэг. Нийтлэг үндэслэл
☐ Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

☐ Гурав. Орон тооны бус шинжээчдийн мэдээллийн сан бүрдүүлэх
☐ Дөрөв. Шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэхэд орон тооны бус шинжээчийг томилох

☐ Тав. Орон тооны бус шинжээчийг шинжилгээний байгууллагын шинжээчдийн бүрэлдэхүүнд оруулж дүгнэлт гаргуулах

☐ Долоо. Орон тооны бус шинжээчийн гаргах баримт бичиг

☐ Найм. Шинжээчийн зардал
Хамгийн гол нь дээрх журмыг гаргаж хэрэгжүүлэхэд хуульд заасан үндэслэл чухал гэдэг нь ойлгомжтой. Иймд 2016 онд шинээр боловсруулж УИХ-ын чуулганаар хэлэлцсэн Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийг дагалдан гарах Шүүхийн шинжилгээний тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд¹² дээрх журмыг батлан гаргах эрхийг хуулиар нээж өгсөн байна. Өөрөөр хэлбэл, Шүүхийн шинжилгээний тухай зүйлийн 8 дугаар зүйлийн 8.4-д “Шинжилгээ хийх журмыг шинжилгээний төрлөөс хамааран Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална” гэснийг “Шинжилгээ хийх журмыг

44 дүгээр зүйлийн 44.2-т зааснаар шинжээчийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, дараа нь хэргийн оролцогчоор нөхөн төлүүлэх заалттай боловч улсын төсөвт шинжээчийн зардлыг тусгаагүйгээс нэхэмжлэгчээр шууд төлүүлсэн байна.

¹¹ Энэ ойлголтыг бусад улсад янз бүрээр тодорхойлж, нэрлэж байна. Жишээ нь “officially certified expert” гэх мэт. Манай улсын хувьд уламжлалт ойлголтоор “орон тооны бус” эсвэл “гэрээт шинжээч” гэсэн ч болох юм.

¹² Шүүхийн шинжилгээний тухай хуулийн нэмэлт өөрчлөлт. Төсөл. 2016.



шинжилгээ хийх хэлбэр, шинжилгээний төрлөөс хамааран Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж найруулсан явдал юм.

Шинжилгээний төрлөөс хамаарч батлагдсан журам бол криминалистик, шүүх эмнэлэг, эдийн засгийн шинжилгээ хийх журмууд юм. Харин “шинжилгээ хийх хэлбэр” гэсэн ойлголтыг тусгасан явдал бол шинжилгээг шинжилгээний байгууллагад хийх, гадуур хийх, түүнээс гадна бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийх, комплекс шинжилгээ хийх тухай гүйцээн зохицуулсан журмуудыг гаргах хуулийн гаргалгаа бий болно гэсэн үг юм. Гэхдээ энэ бол эрх зүйн зохицуулалтыг бүрэн дүүрэн сайжруулах алхам яагаад ч биш гэдэг нь ойлгомжтой. Зөвхөн ойрын зорилтыг л шийдвэрлэх төдий хэрэг юм. Иймд цаашид шүүхийн шинжилгээ явуулах үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомжийг цогцоор нь авч үзэж шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт, санал

Судалгааны үр дүнд шинжилгээний байгууллагаас гадуур шинжээч томилох явдал нь шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд хамгийн тулгамдсан асуудал болж байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Үүнийг шийдвэрлэхийн тулд шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй, шинжилгээ хийх боломжтой мэргэжилтнүүдийн бүртгэлийн тогтолцоог бий болгож шүүхийн шинжилгээний төв байгууллагад хариуцуулах, шинжилгээний байгууллагаас гадуур томилогдсон шинжээчийн зардлыг олгох тогтолцоо бүрдүүлэх эрх зүй, зохион байгуулалтын өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна. Энэ саналыг дэлгэрүүлэн авч үзвэл:

☐ Орон тооны бус /гэрээт шинжээч/ шинжээчийн улсын бүртгэлийг бий болгож ашиглах. Энэ үйл ажиллагааны хүрээнд шүүхийн шинжилгээ хийх боломжтой мэргэжилтнүүдийг судлах, шалгаруулах, зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, аттестатчилал явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

☐ Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, орон тооны бус шинжээчээр шинжилгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах дэд бүтцийг тодорхой болгох, өөрөөр хэлбэл зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;

☐ Орон тооны бус шинжээчид шинжлэн магадлахуйн зохих мэдлэг олгох, давтан сургалт явуулах богино хугацааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

☐ Шинжилгээний үнэ тариф боловсруулж, орон тооны бус шинжээчийн ажлын хөлс олгох нөхцөлийг бүрдүүлэх;

Дээрх санаа нь шинжилгээний байгууллагыг цаашид өргөжүүлэх шаардлагагүй, зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий шинжээч, хувийн лабораторийг дэмжинэ гэсэн санаа бус юм. Шүүхийн шинжилгээний байгууллагад одоо хийгдэж байгаа уламжлалт шинжилгээнүүдээс гадна зарим төрлийн шинжилгээний лабораторийг өргөтгөх, шинээр байгуулах нь зүйн хэрэг. Яагаад гэвэл дээрх шинжилгээнүүд жил ирэх бүр өсч, тасралтгүй хийгдэх хэрэгцээг бий болгож байгаа юм. Харин үргэлж хийгддэггүй боловч хэрэгцээ гарч байдаг шинжилгээнүүдийг хийж дүгнэлт гаргах мэргэжилтнүүдийн судалгаа, бүртгэлийг шүүхийн шинжилгээний төв байгууллагад бий болгож, шинжилгээ хийх дэд бүтцийг боловсронгуй болгосон тохиолдолд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж шүүхийн шинжилгээг хуулийн дагуу, шуурхай, батлагдсан арга аргачлалаар явуулах, шинжээчдийн хараат бус байдлыг хангах нэг нөхцөл бүрдэх боломжтой гэж үзэж байна. Энэ ШШҮХ-д Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс даалгасан инженер техникийн чиглэлийн шинжилгээг хийж байгаа туршлагаас харагдаж байна.



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙГДЭЖ БУЙ ШИНЭТГЭЛ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨНИЙ ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГА

THE CURRENT REFORM OF THE POLICE AND THE PUBLIC ATTITUDE TOWARDS ITS IMPACT

Б.БАЯНМӨНХ

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаа судлалын тэнхимийн дэд профессор, цагдаагийн хошууч

Товч агуулга: Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим нь авилга, ашиг сонирхлоос ангид байж, мэдээллийн ил тод байдлыг хангасан, иргэндээ ээлтэй үйлчилгээ үзүүлж, амар тайван аюулгүй орчинг бүрдүүлэх явдал гэж үзэж болно.

Цагдаагийн байгууллагын шинэчлэлийг нийгмийн захиалга гэж судлаачийн хувьд үздэг бөгөөд энэ нь нийгмийн хөгжлийн зүй тоглоо дагаж байнга өөрчлөгдөж шинэчлэгдэж байх ёстой.

Өөрчлөлт, шинэчлэл тасралтгүй тогтмол явагдаж байж энэ байгууллагын үйл ажиллагаа нийгмийн дэвшилтэд хөгжлийн тэр түвшинд хүрч ажиллах боломжтой болно. Энэ үүднээс шинэчлэл, түүний үйл явцын үе шат, хүрэх үр дүн болон цагдаагийн байгууллагын шинэчлэл, түүний үр нөлөөнд олон нийтийн хандлага ямар байгаа талаар энэхүү илтгэлээр илэрхийлэхийг хичээлээ.

Abstract: The current Mongolian police force is expected to operate with the following principles in mind; to be free from corruption and self-interests, to be transparent to the public, to provide citizens with a friendly service, and to create a safe and peaceful environment for its people.

As a researcher the current reform that is transpiring within the police force should be viewed as a shift that is being initiated by the changing needs of society and that in terms of social progress and development this is a necessary phase that should occur regularly.

In order to reach a point where social progress and development has reached an advanced level, reforms should be continuously implemented. In this regard, this article aims to explore how the public perceives this reform through analysis of the implementing stages, outcomes and impacts on society.

Түлхүүр үгс: Шинэчлэл, хандлага, үе шат, зүй тогтол, үр дүн, хууль сахиулах байгууллага, цагдаагийн байгууллага.

Key words: Reform, attitude, stage, rule/regimen, outcome, law enforcement organization, police.

УДИРТГАЛ

Зорилго: Энэхүү илтгэлийн зорилго нь аливаа нэг өөрчлөлт, шинэчлэлийн үйл явцын үе шат, дамжлагын талаарх судлаачийн хувьд үзэл бодлоо хүргэх, түүнчлэн цагдаагийн байгууллагад хэрэгжиж байгаа өөрчлөлт, шинэчлэлийн үр нөлөөнд хандах олон нийтийн хандлага ямархуу түвшинд байгааг тодорхойлох, түүнчлэн шинэчлэлийн үр дүнг дээшлүүлэх чиглэлээр санал гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргэх явдал юм.

Шинэлэг тал: Цагдаагийн байгууллагад шинэчлэлийн бодлого хэрэгжиж эхэлснээс хойш уг өөрчлөлт, шинэчлэлийн үр нөлөө иргэд, олон нийтэд ямархуу байдлаар хүрсэн болон түүний үр нөлөөнд хандах олон нийтийн хандлагын талаар дагнан асуулгаар судалгаа авч байгаагүй бөгөөд анх удаа олон нийтийн хандлагыг тодорхойлохыг оролдсон нь энэхүү илтгэлийн шинэлэг талыг тодорхойлж байна.

Судлагдсан байдал: Цагдаагийн албаны тухай хууль батлагдахаас өмнө 2011, 2012, 2013 онд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа иргэд, олон нийтэд хэрхэн хүрч байгаа талаарх “Хэрэглэгчийн судалгаа”, 2012 онд “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл”, 2014 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Хууль зүй судалгааны төв”-ийн явуулсан “Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа” зэрэг судалгаанууд явагджээ.

Гэхдээ “Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа” нь Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2014 онд явагдсан учир шинэчлэлийн



бодлого, хуулийн хэрэгжилтийн үр нөлөө хэрэглэгчид хэрхэн хүрсэн нь төдийлөн бүрэн гүйцэд гараагүй байх магадлалтай билээ.

Үндсэн хэсэг: Аливаа улс орон төрөө үргэлж шинэчилж, сайжруулах жамтай. Төр хэрхэн сайжирч буй нь Үндсэн хуулийн өөрчлөлтүүдээр харагддаг байна. Өмнөд Солонгосын үсрэнгүй хөгжлийн нууц нь төрийн шинэчлэлдээ байсан гэж олон орон үздэг нь тухайн улсын эдийн засаг нь биш төр нь шинэчлэгдэж хурдтай байснаараа үсрэнгүй хөгжлийг авчирсан гэж үздэгтэй салшгүй холбоотой юм.

Улс орны шинэчлэл төрийн шинэчлэлээс эхэлдэг, төрийн шинэчлэл нь Үндсэн хуулийн шинэчлэлээс эхэлдэг гэж үздэг.

Төр гэдэг ард түмний хамтын ухамсрын суурин дээр бүтээгддэг байгууллага бөгөөд улс төрийн ухамсартай иргэдтэй үед л хөгжил дагаж байх учиртай. Ухамсартай иргэдтэй байна гэдэг ард түмнээ дээдэлсэн сайн Үндсэн хуультай, нийгмээрээ нэг хүсэлтэй бөгөөд хоорондоо хамтын гэрээгээр зохицуулагдсан орчин бүрдэнэ гэсэн үг юм.

Ийм нөхцөлд л жинхэнэ нийгэм бүрэлдэн тогтдог. Адилхан ёс суртахуунтай, адилхан хүмүүжилтэй, нэг зүг рүү тэмүүлсэн тэмүүлэлтэй хүмүүсийг нийгэм гэж нэрлэдэг. Нийгэм бол зөвхөн хүмүүсийн бөөгнөрөл биш юм.

Төр бол ухамсрын суурин дээр үндэслэгдэн мэдлэг дээр суурилан босож ирдэг. Төрөө шинэчлэх нь маш өргөн хүрээгээр яригдах асуудал билээ.

Шинэчлэл гэдэг шилжилт хөдөлгөөн хийж, цалинг нэмэгдүүлж, ажлын байрыг сайжруулаад болчих асуудал биш юм. Үүнд удирдлагын арга барил хамгийн голлох үүрэгтэй юм.

Бид өнөөдөр цөөхөн хүний хүрээнд асуудлыг шийддэг хурц босоо биш, багаараа хэлэлцэж асуудлыг шийдвэрлэдэг хамтын системийг нэвтрүүлсэн нь маш том ололт юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд багийн гишүүдэд эрх шилжүүлэх, итгэл үзүүлэх, хамтдаа хариуцлага хүлээдэг байх системд шилжиж чадсан байх ёстой.

Өнөөдөр бид шинэчлэл гэдэг нь чухам юу вэ гэдгийг сайн бодох хэрэгтэй байна. Зарим хүн “Шинэчлэл гэдэг нь сайтар мартагдсан зүйлийг дахин сэргээж хэрэгжүүлэх” гэж хэлсэн байдаг. Энэ нь магадгүй тухайн цаг үед ийм хэмжээний шинэчлэл шаардлага бий болсонтой холбоотойгоор гарсан байх магадлалтай юм.

Хүн ч бай, улс ч байсан гурван цагийн хэлхээсэн дээр хөгждөг. Өөрөөр хэлбэл, ахмад, дунд, залуу үеийн алтан хэлхээг авч

явах, алтан дунджыг олох, түүнийг тойрсон асуудлыг авч үзэх нь хөгжлийн бодлогыг тодорхойлох маш чухал үйл явц билээ.

Өнөөдөр бид ядаж 10-15 жилийн дараа Монгол Улсын хөгжилд хэрэгтэй зүйл хийхээс биш тулга тойрсон хэрүүлийг шинэчлэл гэж хэлэхгүй. Үүгээр юуг хэлэх вэ гэхээр залуус маань их зүйл унш, олон улсын чиг хандлагыг судлах, туршлагыг нь хуулах бус сайн судлах нь чухал болоод байна.

Шинэчлэл гэдэг нь алсыг харсан эх үйлсийн эхлэл гэж хэлж болно. Үнэхээр аливаа нэг салбарт шинэчлэл хийх гэж байгаа бол тухайн салбарын шат шатны давхаргыг хамарсан цогц байдлаар хийвэл үр дүн нь өндөр байна.

Шинэчлэл /reform/-ийг макро түвшний өргөн хүрээг хамарсан өөрчлөлт шинэчлэлтийг хэлдэг бол микро түвшинд өрнөж буй шинэчлэлүүдийг иноваци гэж ойлгож бас болно.

Шинэ санааг амьдралд хэрэгжүүлэхийн гол ач холбогдол нь илүү нэмүү өртөг, үр ашиг, бүтээмж, нийгмийн үнэ цэнэ бий болгодогт оршдог гэж товчхон хэлж болно. Энэ утгаараа иноваци нь хувь хүн, өрх гэр, байгууллагын түвшинд төдийгүй улс үндэстэн, бүс нутаг, дэлхийн хөгжлийн суурь гэж хэлж болохуйц ач холбогдолтой.

Харин шинэлэг зүйлийг хүмүүсийн сайн сайхан амьдралын төлөө, хүний хөгжлийг гол зорилгоо болгосон, нийгмийн эрх тэгш байдал, тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлэх нь чухал.

Шинэчлэлийг хэн дэмжинэ, тэр хүн энэхүү үйл явцын идэвхтэй оролцогч нь байх болно. Хандлага, харилцан буулт, хариуцлага, үүргээ ухамсарлах зориг, алсын хараа, алдаагаа ойлгож, зөв үнэлсэн ажил хэрэгч уур амьсгалд шинэчлэл амжилт олно.

Шинэчлэл бол ганц хүний зоргоор хийдэг ажил биш. Энэ бол нийгмийнхээ бодит шаардлагыг мэдэрсэн, үзэл санаа нэгтэй, жинхэнэ сорилтыг давах сэтгэлийн хаттай, хамтын зорилгоо тодорхойлсон хүмүүсийн хамтран манлайлж, олон түмний итгэл дэмжлэгийг олж хийх ажил юм.

Шинэчлэлийн зорилго нь захиргааны зардлыг хямдруулж, тогтворжуулах замаар үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, үйлчилгээг иргэдэд ойртуулж, тэдний эрэлт хэрэгцээг хангах, захиргааны үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгоход чиглэгдэх ёстой. Энэ утгаараа төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэл нь улс төр, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн хөтөч нь болдог байна.

Монгол Улсын хөгжлийн зорилтуудыг



хэрэгжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээлүүдийг даван туулахын тулд хийх шаардлагатай шинэчлэлийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол төрийн албаны шинэтгэл юм.

Өнөөдөр төрийн албаны шинэтгэлийн ихэнх хөтөлбөр нь мэргэшсэн тогтвортой байх (мерит) зарчимд суурилсан, улс төрийн намуудаас хараат бус төрийн албыг байгуулах буюу бэхжүүлэх явдлыг гол зорилгоо болгож байна.

Төрийн албаны шинэтгэлийн амжилт ололт, бүтэлгүйтэл нь засаглалын институцийн болон улс төрийн нөхцөл байдал, төрийн албан хаагчдын чадавхаас ихээхэн шалтгаалдаг.

Монгол Улсад 1990 онд эхэлсэн нийгмийн бүх хүрээг хамарсан ардчилсан өөрчлөлт шинэчлэлт дор дурдсан 4 шатыг дамжин өөрчлөгдөн шинэтгэгдэж байна. Энэхүү өөрчлөлт, шинэтгэлийн шат тус бүр нь өөрийн онцлогтой чиглэсэн тодорхой зорилго, зайлшгүй хэрэгжүүлэхийг шаардсан үйл ажиллагаатай байсны дээр төрийн албан хаагчдаас шинэ орчин нөхцөлд дасан зохицож ажиллах сэтгэлгээг шаардаж байлаа. Үүнд:

Дөрвөн үе шат¹-тайгаар хэрэгжиж байгаа Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн үр дүнд төрийн албан хаагчдын өгч байгаа үнэлгээ нь хэдийгээр эерэг тал руугаа хандаж байгаа хэдий ч төрийн албаны үйл ажиллагаа доголдолтой, нийгмийн болоод нийт иргэдийн нийтлэг эрх ашгийн төлөө бус хувин сонирхол, улс төрийн ашиг хонжооны төлөө ажилладаг, хариуцлагагүй, ажил мэргэжлийн ур чадвар сул, хээл хахуультай, хүнд суртал бүхий төрийн алба байна гэсэн шүүмжлэл нийгэмд байсаар байна.

Төрийн албаны шинэтгэлийн зарчим, үнэт зүйлс нь шинэтгэлийн бодлого, стратеги зорилтуудыг тодорхойлох суурь үндэс нь болно. Шинэчлэлийг дүр эсгэсэн байдлаар бус, сууриас нь харж салбар бүр дээр тогтсон бодлоготой байж хийнэ.

Өнөөдөр цагдаагийн байгууллага дээр хэрэгжиж байгаа шинэчлэлийг хүмүүс янз бүрээр харж байна. Судлаачид, улс төрийн зүтгэлтнүүд, залуус, иргэд олон нийт өөр өөрийн мэдлэг, боловсрол, туршлага, төсөөллийн хэмжээнд харж байна.

Нэг талаас дүрэм журмын шинэчлэл гэж Төрийн байгууллын шинэ тогтолцоог бүрдүүлэх 1-р шат (1990-1993)

Төрийн захиргаа, төрийн албаны шинэ тогтолцоог бүрдүүлэх 2-р шат (1994- 2000)

Төрийн албаны чадавхи, үйл ажиллагааных нь үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх 3-р шат (2000 – 2008)

Улс төрийн нөлөөллөөс ангид төрийн мэргэшсэн, тогтвортой албыг төлөвшүүлэх шат (2008 оноос хойшхи)

харж байхад, нөгөө талаас сахилга бат, зохион байгуулалт, нээлттэй байдал гэж харж байна. Бүр зарим нь хүний нөөц, албан тушаалтанд хариуцлага тооцох, солих, огцруулахаас эхэлсэн гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллага дээр явагдаж байгаа шинэчлэгдэх үйл явц тодорхой үе шаттай, зохион байгуулалттай, үзэл бодлын харилцан буулт шаардсан үйл явц гэж хэлж болно.

Шинэчлэлийг алсыг харж, ойрын бэрхшээлийг тооцож эрсдэл гаргаж хийдэг ажил гэдгийг олон орны жишээ харуулдаг. Шууд авч хэрэгжүүлдэг бэлэн жор гэж үгүй. Харин шинэчлэлийг орон орны туршлага, өөрийн орны нөхцөлийг нэг бүрчлэн сайтар тооцож, улс төр, нийгэм, эдийн засаг, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог нөхцөл байдал, хэтийн төлөвийг харгалзан үзэж хийх ажил юм.

Үзэл, үзэл санаа, концепцын цоо шинэ шинэчлэл (платформ) салбар байгууллагад хэрэгтэй. Үйл ажиллагааны алдаа, дутагдал, эрх зүйн цоорхойг хэн нэгэн тодорхой хүнд бурууг тохон косметик шинэчлэл хийж хариуцлага тооцсоноор салбар байгууллагын шинэчлэл амжилт олохгүй.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын шинэчлэл өөрчлөлтийг хийхийн тулд шинэчлэлийн бодлогыг цогц байдлаар хэрэгжүүлэх үе шаттай хөтөлбөр, төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх чадварлаг менежерүүдээс бүрдсэн баг шаардлагатай байна. Өөрчлөлт жижиг зүйлээс, хөгжил дотроосоо эхэлдэг.

Цагдаагийн байгууллага дан ганц хууль сахиулах үйл ажиллагааны бодлого, чиглэлээ өөрчлөөд хуучин арга барилаараа ажилбал энэ нь өөрчлөлт биш гэж үзэж болно.

Арга барилаа өөрчлөх хэрэгтэй ч дан ганц арга барилаа өөрчлөөд хуучин бодлогоороо ажлаад байвал бас өөрчлөлт биш, үр дүнтэй ажиллаж чадахгүй. Тиймээс бодлогоо өөрчлөх хэрэгтэй. Дан ганц бодлогоо өөрчлөхөөс гадна түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц байхгүй бол бодлого хэрэгжихгүй.

Тиймээс бүтцээ өөрчлөх хэрэгтэй. Бүтцээ өөрчлөөд хүнээ хөгжүүлэхгүй бол бүтэц оновчтой байж чадахгүй. Тиймээс хүнээ хөгжүүлэх хэрэгтэй. Дан ганц хүнээ хөгжүүлээд орчинг нь бүрдүүлээгүй бол хүний нөөцөө ашиглаж чадахгүй.


Тиймээс хүнээ хөгжүүлэхээс гадна үйл ажиллагаа, арга барил, бодлого, бүтэц, орчинг хамтад нь өөрчлөх хэрэгтэй. Өөрчлөлт эерэг, хөгжил цогц байх ёстой

юм.²

Дээрх бүгдээс харахад шинэчлэл нь жижиг гэлтгүй бүхий л зүйлд хүрч өөрчилж байж жинхэнэ өөрчлөлт шинэчлэлт болно.

Цагдаагийн байгууллагад явагдаж байгаа шинэчлэл нь дараах үе шаттайгаар явагдаж байгаа боловч зарим тохиолдолд алгасах, дутуу орших байдал гарсаар байна.

Учир нь зарим тохиолдолд шинэчлэл нь хүссэн үр дүнд хүрэхгүй байх, хэрэгжүүлэх арга, хэлбэр нь оновчгүй байх явдал гарсан билээ. Тухайлбал: бүтэц оновчгүй, хувцасны чанар эдэлгээ муу гэх мэт.



Өнөөдөр цагдаагийн байгууллагад хэрэгжиж байгаа шинэчлэл олон нийтэд хэрхэн хүрч байгаа талаар 200 иргэнээс анкет асуулгын аргаар авч шинжилгээ хийж үзэхэд бидний хүссэн хариулт гарч ирсэнгүй нь бид нэгийг бодоход хүргэж байна. Өөрөөр хэлбэл иргэд, олон нийтэд цагдаагийн байгууллага дээрээ хэрэгжиж байгаа өөрчлөлт, шинэчлэлт муу мэдрэгдсэн, шинэчлэлийн үйл явцын талаарх мэдээллийг хүргэх тал дээр учир дутагдалтай байна гэж үзэж болохоор байна.

Бид цагдаагийн байгууллага дээр хэрэгжиж байгаа шинэчлэл, түүнд олон нийтийн зүгээс хандаж байгаа хандлагын түвшинг тогтоож, цаашид хийх шинэчлэлийн бодлого, арга зүй дээрээ өөрчлөлт хийх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь өнөөдрийн шинэчлэлд чухал асуудал болоод байна.

Цагдаагийн байгууллага дээр хэрэгжиж байгаа өөрчлөлт, шинэчлэлийн талаар олон нийтийн хандлага ямар байгаа талаар бидний авсан судалгааг графикаар авч үзвэл: Судалгаанд оролцогчдын насны байдлыг авч үзвэл 15% нь 18-25, 38% нь 26-35, 25% нь 36-45, 22% нь 45-аас дээш насны иргэд эзэлж байна.

Хүйсийн харьцааг авч үзвэл судалгаанд оролцогчдын 38% нь эрэгтэй, 62% нь эмэгтэй иргэд байна. Харин ажил эрхлэлтийн байдлыг нь авч үзвэл 13% нь төрийн байгууллага, 5% нь төрийн бус байгууллага, 47% нь хувийн компанид, 22% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 13% нь ажилгүй иргэд хамрагдсан байна.

² “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. УБ., 2014. №3

График №1



График №2



График №3



График №4




График №5





График №6



График №7



Дээрх судалгааны дүнг нэгтгэн авч үзвэл цагдаагийн байгууллагын шинэчлэлийн үр нөлөө иргэд олон нийтийн дунд төдийлөн сайн мэдрэгдээгүй гэж үзэж болохоор байна. Судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагчдын 17% нь “Буруу”, 16% нь “Цагаа олоогүй”, 24% нь “зөв боловч буруу арга хэлбэрээр явагдсан” гэж хариулж нийт оролцогчдын 57% нь хангалтгүй үнэлсэн нь бид энэ тал руугаа анхаарлаа хандуулах шаардлагатай болсныг харуулж байна. /график №1/

Түүнчлэн судалгаанд хамрагчдын 80% нь Цагдаагийн байгууллагад явагдаж байгаа шинэчлэлийн үр нөлөө бидний ажиллаж, амьдарч буй орчинд мэдрэгдээгүй гэсэн нь олон нийтийн хүсэн хүлээж байгаа тэр зүйл рүү хүрч чадахгүй байгааг харж болохоор байна. /график №3/

Олон нийтийн 48% нь цагдаагийн байгууллагыг “үйлчилгээний”, 31% нь “цэрэгжсэн” байгууллага байхыг хүсч байгаагаа илэрхийлсэн байна. /график №4/ Энэ нь нэг талаараа цагдаагийн байгууллагыг иргэдэд хууль зүйн тусламж үйлчилгээг анхан шатанд үзүүлдэг гэсэн хандлагаар үйлчилгээний, харин гэмт хэрэг, зөрчилтэйтэй тэмцэх ажилд голлох үүрэгтэйгээр оролцдог гэдэг утгаараа эрх мэдэлтэй, хүчирхэг байхыг хүсэж цэрэгжсэн байхыг хүсдэг байна.

Нөгөө талаараа Дээрх 2 хандлагын аль алиных нь шинжийг тусгасан шинэ хандлага бий болгох хэрэгцээ шаардлага байгааг

харж болно.

Мөн судалгаанд оролцогчдын 45% нь “бүх шатанд”, 37% нь удирдлагын түвшинд шинэчлэл түрүүлж хийгдэх ёстой гэж үзсэн нь өөрчлөлт, шинэчлэлт бодлого тодорхойлдог удирдлагын түвшинд түрүүлж явахыг хүсэж байгаагаас харж байна. /график №6/

ДҮГНЭЛТ, САНАЛ

Судалгаанд хамрагдсан иргэд, олон нийт цагдаагийн байгууллагад ямар шинэчлэлт явагдсан талаар төдийлөн сайн мэдэхгүй байгаа нь энэ ажлын цар хүрээ зөвхөн байгууллагын хэмжээнд явагдаад өнгөрөх магадлалыг бий болгож, үр нөлөө нь олон нийтэд төдийлөн сайн хүрч чадахгүй байна гэж үзэж болохоор байна.

Шинэчлэл гэдэг урьд нь хийсэн ажлыг тэр чигт нь үгүйсгээд дахин шинээр хийх явдал биш, харин тэрхүү хийсэн ажлыг улам засан сайжруулж, зөв чиглэлд хөтлөн оруулах замаар тавьсан зорилгодоо хүрэх тасралтгүй хийгдэж байх ёстой ажил билээ.

Тиймээс бид шинэчлэлийг хүрэх үр дүнгээ сайтар тооцоолж, хэрэгжүүлэх арга зүйгээ зөв тодорхойлж, олон түмний дэмжлэг болон алба хаагчдын сэтгэлгээний өөрчлөлтийн тусламжтайгаар хийвэл зорилгодоо хүрч болох гарц байгаа гэж үзэж байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагад инновацийн бодлого амжилттай хэрэгжүүлэх замаар дэвшилтэт технологийг ашиглан, хууль сахиулах үйл ажиллагааны чанараа сайжруулж болно. Ингэснээр нийгмийн эрэлт хэрэгцээг хангах, амар тайван аюулгүй орчин бий болгох, зардал хэмнэх, аль болох бага хүч хэрэгсэлд тулгуурласан зөв оновчтой арга зүйг ашигласнаар гэмт хэрэг, зөрчлийг бууруулж, хүссэн үр дүндээ хүрч болох юм.

Иймд цагдаагийн байгууллагын өөрчлөлт шинэчлэлийн үр нөлөөг дээшлүүлэх, хүссэн үр дүнд нь хүргэх үүднээс дараах хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:


1. Цагдаагийн байгууллагын өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц, түүний нөлөө, үр дүнд иж бүрэн шинжилгээ хийж, гаргасан алдааны оношыг зөв тогтоох судалгааны баг ажиллуулах;
2. Өөрчлөлт шинэчлэлтэд хандаж байгаа алба хаагч болон иргэдийн сэтгэлгээний хандлага, хүсч буй зүйлийг судалж тогтоох;
3. Өөрчлөлт шинэчлэлтэд нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйл, түүний шалтгаан нөхцөлийг судлан тогтоох судалгаа хийх;
4. Судалгаанд суурилсан өөрчлөлт,




шинэчлэлтийн бодлогыг гаргаж, бүх шатны түвшинд нээлттэй байдлаар хэлэлцүүлэх замаар хэтийн төлөвөө зөв тодорхойлох;

5. Гадаад орнуудад хэрэгжсэн өөрчлөлт, шинэчлэлтийн чиглэлээр хийсэн ажлуудыг судалж, өөрийн орны хөрсөнд бууж болохуйц үр дүнтэй арга замуудыг сонгон авч эрдэмтэн судлаачдаар хэлэлцүүлэх замаар оновчтой арга, хэлбэрийг эрэлхийлэх;
6. Цагдаагийн байгууллага өөрчлөлт, шинэчлэлтийн хүрээнд хийгдсэн олон дэвшилт ажлуудаа иргэд, олон нийтэд сурталчлах замаар нийгмийн байр сууриа бэхжүүлэх, үр нөлөөг түгээх ажлыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага бүр зохион байгуулах.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

 “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. УБ., 2014. №3.

 “Цагдаагийн байгууллагын шинэчлэлийн үр нөлөөнд хандах иргэд, олон нийтийн хандлага” судалгаа. УБ., 2016.



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА, ХЭЛБЭР, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

POLICE METHODS, FORMS, AND REGULATION WAYS TO IMPROVE A CURRENT SITUATION ON PUBLIC SAFETY OPERATIONS

П.ЭНХТОГТОХ

Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга, туслах комиссар

Товч агуулга: Өнөөдөр дэлхий дээр тохиолдож байгаа байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, түүнчлэн хүний хүчин зүйлээс хамааралтай осол, сүйрэл, эмх замбараагүй байдал, террорист халдлага, бүс, нутгийн мөргөлдөөн жилээс жилд өсөж, түүнээс учрах хор уршиг, үр дагавар улам бүр нэмэгдэж байна.

Олон нийтийн аюулгүй байдалд заналхийлж байгаа аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хор уршигийг нь нэмэгдүүлэхгүй байх, арилгах явдал нь дэлхийн улс орнуудын өмнө тулгамдаж байгаа асуудлын нэг болж байна.

Миний бие цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн нэг болох олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй зарим асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар энэхүү илтгэлээр илэрхийлэхийг хичээлээ.

Abstract: Today, number of natural catastrophes, disasters, as well as the manmade injuries, devastations, disorders, terrorist attacks, regional and local conflicts and their harmful consequences are increasing on each year in the world.

As a result, international law enforcement agencies are challenging to decrease these threatens and addressing effective preventions, interruptions, operations of public safety.

This paper examines that one of the police tasks is public safety and its methods, forms, regulatory issues, and then try to express some ways to resolve them.

Түлхүүр үгс: Цагдаагийн байгууллага, олон нийтийн аюулгүй байдал, нийтийг хамарсан арга хэмжээ, үйлдвэрийн осол аваарь, байгалийн гамшиг, тэсэрч дэлбэрэх, химийн хорт бодис.

Key words: Police, public security, public events, industrial accidents, natural disasters, explosions, toxic chemicals.

ҮНДСЭН ХЭСЭГ

Даяаршиж буй өнөөгийн нийгэмд хүн бүр айл аюулгүй, амар тайван орчинд ажиллаж, амьдрахыг хүсэн мөрөөддөг боловч тэр нь зарим хэсэгт биелдэг ч ихэнхидээ тэр бүр биелдэггүй, биелэх боломж төдийлөн хомс байдаг байна.

Аливаа нийгэмд төрийн үндсэн үүрэг нь иргэдээ гадна, дотнын аюул заналхийллээс хамгаалж, эрх, ашиг сонирхлыг нь хангах явдал байдаг. Ардчилсан нийгэмд хүний аюулгүй байдлыг хамгаалах гэдгийг хүний жам ёсны эрх, эрх чөлөөг чандлан хамгаалах утгаар ойлгодог.

Аюулгүй байдлыг хангах энэхүү онцгой үүргийг хүлээснийхээ төлөө төр нийгэмд шүүх, цэрэг, цагдаа гэх мэт албадлагын институцуудыг ажиллуулах замаар онцгой эрхийг эдэлдэг.

Өнөөдөр хүн төрөлхтөн дэлхийн хэмжээний болон бүс нутгийн олон аюул заналтай тулгараад байна. Гэтэл бид үүнийг мэддэг боловч ухаардаггүй.

Аюул занал бол яг таг тодорхойлж болдог ойлголт биш бөгөөд байнга өөрчлөгдөж байдаг, энэ ойлголтыг янз бүрийн утгаар хэрэглэдэг, мөн тэр нь маш олон утгаар авч үздэг байна.

Гэхдээ аюул заналыг цаг ямагт явцуу утгаар ойлгож, мэдэгдэм бодит шинжтэй болгон ойлгож ирсэн уламжлал амь бөхтэй оршиж ирсэн. Энэ нь объектив байдалд тэмүүлж ирсэн олон жил ноёрхсон позитивист хандлага болон түүнчлэн байгалийн ухааны аргуудыг улс хоорондын харилцааг судлахад хэрэглэж ирсэнтэй холбоотой юм.¹

Манай улсад ган, зуд, аадар бороо, мөндөр, хүчтэй цасан шуурга, үер зэрэг байгалийн аюулт үзэгдлийн давтамж, эрчим

¹ Ц. Дашзэвэг., д. Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудал. УБ., 2004. 7 дахь тал.



эрс нэмэгдэж, улмаар хүний амь насаа алдах, улс орны эдийн засагт учруулсан хохирлын хэмжээ сүүлийн 20 гаруй жилд 2 дахин нэмэгдсэнийг судлаач мэргэжилтнүүд тогтоосон байна.

Энэ нь зөвхөн Монгол Улсын төдийгүй дэлхийн улс орнуудын тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа бөгөөд учруулах хор аюулын хэр хэмжээ, давтамж, хүрээ, далайц нь улам бүр өссөөр байгаа нь тулгамдсан асуудлыг улам бүр нэмэгдүүлж байна.

Түүний улмаас жил бүр олон оронд хэдэн зуун мянган хүн амь насаа алдаж байгаагийн зэрэгцээгээр хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засагт нь ихээхэн хохирол учруулсаар, хөнөөлийнх нь цар хүрээ өргөжин тэлж, давтамжийн хугацаа нь ойртон, эрсдэл, эмзэг байдлын үнэлгээний шалгуур босгыг нэмэгдүүлсээр байна.

Олон нийтийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангаж байгаа төрийн бодлоготой салшгүй холбоотой бөгөөд бодлого, чиглэлийг хэр зөв оновчтой тодорхойлж, түүний хэрэгжилтийг хэрхэн хангаж чадаж байгаагаас олон нийтийн аюулгүй байдал хангагдах үндсэн суурь нөхцөл бүрдэнэ.

Монгол Улс хэтдээ учирч болзошгүй аюул занал, түүнээс урьдчилан сэргийлэх арга механизмын талаар цэгцтэй нэг мөр ойлголт, бодлогыг боловсруулан, аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс, аюулгүй байдлыг хангах арга зам, түүний баталгаа зэргийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа тодорхой тусгасан байдаг.

Тухайлбал, 2010 оны 07 сарын 15 өдрийн УИХ-ын чуулганы 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалд “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллагыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн² гэж заажээ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэгтэй байгууллагуудын нэг бол цагдаагийн байгууллага билээ.

Өнөөдөр цагдаагийн байгууллага 2013 онд шинэчлэгдэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйл /Олон нийтийн аюулгүй байдлыг хангах/-д заасан дараах үүргийг хэрэгжүүлж байна. Тухайлбал:

²Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалын 3.3.

- Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал болон бусад объектыг хамгаалах, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх;

- Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах;

- Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах;

- Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомжид заасан үүрэг гүйцэтгэх;

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах;

- Нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалт хийх;

- Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх³.

Аливаа улс орон нийгэм, эдийн засагн хөгжин дээшлэхтэй зэрэгцэн гадаад оронтой харилцах, хамтын ажиллагаа нь улам өргөжин тэлж байдаг жамтай.

Манай улсын гадаад хамтын өргөжин тэлэхийн хэрээр олон улсын чанартай хурал, зөвлөлгөөн, спортын уралдаан тэмцээн, соёл урлаг зэрэг олон талт нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдах нь улам нэмэгдэх хандлагатай болж байна.

Зөвхөн 2015-16 ондИХ Монгол Улс байгуулагдсаны 810, Ардын хувьсгалын 95 жилийн ой, Үндэсний баяр наадам, гадаадын өндөр хэмжээний зочин төлөөлөгчдын айлчлал, “Даншиг наадам, хүрээ цам, Өндөр гэгээний соёлын арга хэмжээ,Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын ассамблей, Ази Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт гэх мэтчилэн олон улсын болон улс, бүс нутгийн чанартай олон томоохон арга хэмжээнүүд зохион байгуулагдсан байдаг.

Зөвхөн 2015 онд улсын хэмжээнд2305 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдсан бөгөөд уг арга хэмжээнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах хамгаалалтад давхардсан тоогоор 56603 цагдаагийн алба хаагч, 6390автомашин, 27756 тусгай хэрэгсэлтэйгээр 164647 цагийн үүрэг гүйцэтгэсэн байна.Үүнээс Улаанбаатар хотод 1144 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 39269, хөдөө орон нутагт 1161 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор

³ Төрийн мэдээлэл. 2013. №29



17334 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэсэн байна.

Хамгаалалтыг төрлөөр нь авч үзвэл: Улсын хэмжээнд Үндэсний их баяр наадам болон аймаг, сумын баяр наадмын 315 удаагийн хамгаалалтад 5287, улс, бүсийн даншиг наадам, хурдан морины уралдааны 167 удаагийн хамгаалалтад 6617, урлаг спортын арга хэмжээний 462 удаагийн хамгаалалтад 7654, төрийн тусгай хамгаалалт болон гадаадын зочин төлөөлөгчдийн айлчлалын үеийн 862 удаагийн хамгаалалтад 28833, бусад төрлийн 499 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд давхардсан тоогоор 8212 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэсэн байна.

Нийт зохион байгуулагдсан арга хэмжээг төрлөөр нь графикаар авч үзвэл:



Түүнчлэн 2015 онд төв, орон нутагт зохион байгуулагдсан 140 удаагийн жагсаал, цуглааны үеийн олон нийтийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтанд давхардсан тоогоор 5616 цагдаагийн алба хаагч, 422автомашинтайгаар 2740,9 цагийн үүрэг гүйцэтгэсэн байна.


Нийт зохион байгуулагдсан жагсаал, цуглааныг хэлбэрээр нь авч үзвэл: 31 удаагийн жагсаалын үед давхардсан тоогоор 2165, 81 удаагийн цуглааны хамгаалалтад 2803, 12 удаагийн улс төрийн суултад 170, 2 удаагийн өлсгөлөн зарлах үед 86, 3 удаагийн ажил хаялтад 273, 11 удаагийн санал, асуулгад 119 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэж зохион байгуулагч оролцогч, сонирхогч иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажиллажээ.




Зохион байгуулагдсан нийт жагсаал, цуглааны 91 буюу 65% хувьд нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасны дагуу зохион байгуулагчид нь сум, дүүрэг, нийслэлийн Засаг даргад хүсэлтээ өгч бүртгүүлэн үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд зохион байгуулсан байна.

Түүнчлэн 2015 онд зохион байгуулагдсан 2305 удаагийн нийтийг хамарсан арга

хэмжээний хамгаалалтыг 2014 оны мөн үетэй харьцуулбал 1499 нэгжээр буюу 65 %-иар өссөн байна.



2015 онд зохион байгуулагдсан 140 удаагийн жагсаал, цуглааныг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулбал 25 нэгжээр буюу 17,8 %-иар өссөн байна.



Бид энэхүү илтгэлдээ хуульд заасан олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаануудынхаа зарим хэсгийг оруулсаныг анхаарах нь зүйтэй болов уу?

Өнөөдөр цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааны талаар бүгдийг оруулж бичвэл ихээхэн цаг орох учраас зөвхөн 2015 онд хийж гүйцэтгэсэн ажлуудын зарим хэсгийг танилцуулах үүднээс багцлан авч орууллаа.

2015 онд дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүн объектуудад 1561548 хүн, 370216 тээврийн хэрэгсэл шалган нэвтрүүлж, 385650 хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж ажилласан байна.

Мөн тэсэрч дэлбэрэх бодис, тэслэгэний хэрэгслийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг 25 аж ахуйн нэгжтэй байгуулсан "Тээвэрлэлтийн хамгаалалтын гэрээ"-ний дагуу нийт 580 удаагийн хамгаалалтыг зохион байгуулсан байна.

Түүнчлэн мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин 19 аймгийн 81 сумын нутагт давхардсан тоогоор нийтдээ 205 удаа гарч, тухайн бүс нутагт Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасан: "...хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед хорио цээрийн дэглэмийг сахиулах" чиг үүргийг хэрэгжүүлж, Онцгой байдал, мэргэжлийн хяналт болон бусад төрийн



байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, давхардсан тоогоор цагдаагийн 8186 алба хаагч хамтран ажиллаж, хорио цээрийн дэглэм тогтооход оролцон, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллага олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй холбогдол бүхий Монгол Улсын 15 хууль, цагдаагийн байгууллагын тодорхой үйл ажиллагааг нэгтгэн зохицуулсан журамд тусгагдсан олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн 17 журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Мөн сүүлийн жилүүдэд цагдаагийн албаны тухай хуульд заагаагүй боловч бусад хууль тогтоомжоор эрх олгогдсон нутгийн захиргааны байгууллагын удирдлагаас өгсөн үүргийн дагуу хууль бусаар гар аргаар алт олборлох иргэдийг албадан тараах ажиллагаанд цагдаагийн байгууллагын алба хаагчид голлох үүрэгтэй оролцох болсон билээ.

Хууль бусаар гар аргаар алт олборлох үйл ажиллагаа манай орны хэд хэдэн аймгийн тодорхой бүс нутаг дэвсгэрийг хамран өргөжиж, байгаль орчинд онц их хэмжээний хохирол учруулж, Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын холбогдох зүйл, хэсгүүд зөрчигдсөөр байна.

Орон нутгийн төр захиргаа, мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагаас хууль бусаар ашигт малтмал, гар аргаар алт олборлох олборлогч иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр тухай бүр арга хэмжээг авч байгаа боловч нөхцөл байдал сайжрахгүй, зохион байгуулалтад орж бүлэглэн дайрах, тавьж буй шаардлагыг эсэргүүцэх, нийтийн эмх замбараагүй байдалд уриалах, цагдаагийн ажилтнуудын биед халдаж, гэмтээх зэрэг ноцтой үр дагавар агуулсан үйлдлийг хийх болсон.

Зөвхөн өнгөрсөн онд л гэхэд хөдөө, орон нутагт хууль бус, гар аргаар алт олборлогч иргэдийн бүлэг, бөөгнөрөл үүссэн тухай нийт 80 удаагийн дуудлага, мэдээлэлд цагдаагийн байгууллагаас 111 тээврийн хэрэгсэл, 651 цагдаагийн алба хаагч нар оролцон тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргын албадан тараах захирамжаар 22 удаа, 34 удаагийн шаардлага, мэдэгдэл хүргүүлж, 48 удаа албадан тарааж, хууль бус гар аргаар байгалийн ашигт малтмал олборлоход ашиглаж байсан 111 ширхэг багаж хэрэгслийг хураан авч,

шийдвэрлэсэн байна.

Дээрхи бүгд явуулсан үйл ажиллагаануудыг нэгтгэн авч үзвэл цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь дараах арга, хэлбэрүүдээр явагдаж байна гэж үзэж болно. Үүнд:

- Объект хамгаалах;
- Нийтийг хамарсан арга хэмжээнд оролцогчдын аюулгүй байдлыг хамгаалах;
- Төрийн өндөр албан тушаалтан болон гадаадын өндөр, дээд зочин төлөөлөгчдийг хамгаалах;
- Хорио цээрийн бүсэд дэглэм, хэв журам сахиулах;
- Тэсэрч, дэлбэрэх бодисын эргэлтэнд хяналт тавих;
- Олон нийтийн аюулгүй байдалд заналхийлсэн аливаа үйлдлийг таслан зогсоох;/нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, террорист халдлага, хууль бус жагсаал, цуглааны албадан тараах г.м/
- Бусад хууль тогтоомжоор хүлээлгэсэн ажиллагаа /хууль бус гар аргаар алт олборлогчдыг албадан тараах, албадан нүүлгэх/;

Цаашдаа цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд энэхүү үйл ажиллагааг зохицуулсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд судалгаа, дүн шинжилгээ хийж, эрх зүйн хийдлийг арилгах, үйл ажиллагааныхаа арга зүйг улам боловсронгуй болгох, шинжлэх ухаан, техник технологийн сүүлийн үеийн дэвшлүүдийг ашиглан, бага хүч хэрэгслээр үйл ажиллагаагаа зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Бид өнөөдөр нийтийг хамарсан арга хэмжээний үеийн олон нийтийн аюулгүй байдлыг хангахад алба хаагчдынхаа хүчинд тулгуурлан, сүүлийн үеийн дэвшилтэд техник, хэрэгсэл /нисдэг камер, дрон/-ийг үр дүнтэй ашиглаж байгаа хэдий ч хүрэлцээ хангалтгүй байна.

Тиймээс 2-6 хүний суудалтай /4-6/ ширхэг автожир /бага оврын нисдэг тэрэг/ бүхий “Агаараас дэмжлэг үзүүлэх нэгж”-ийг шинээр байгуулж, цагдаагийн албаны үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэх ажиллагаанд үр дүнтэй ашигласнаар хяналт шалгалт сайжирч, олон нийтийн аюулгүй байдал хангагдах нэг нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, хүн малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэм сахиулах ажиллагаанд оролцох алба хаагчдын ашиглаж хамгаалах



хувцас хэрэглэл, техник хэрэгсэл /хувцас, амны хаалт, хорт утааны баг, бээлий, каск малгай, гутал, аврах хантааз, завь, цасны мотоцикл, газар, уснаа явагч тусгай техник, суудлын болон ачааны автомашин... гэх мэт/-ийн нөөцийг бүрдүүлж, ашигласнааралба хаагчдын аюулгүй байдал хангагдаж, тухайн чиг үүргийг бүрэн биелүүлэх чадамж бүрдэнэ.

Монгол Улсад одоогийн байдлаар тодорхой терроризмын аюул, занал үүсэн бүрэлдээгүй байгаа боловч үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд терроризмтой тэмцэх, ялангуяа терроризмын суурь үндэс бий болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж, тухай бүр нь илрүүлж, таслан зогсоох шаардлагатай байна.

Хууль сахиулах байгууллагуудын ажилтан, албан хаагчид террорист гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй хүмүүсийг өөрийн анхааралд авч, "индикатор" буюу шинж тэмдгээр нь тодорхой хугацааны давтамжтай тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Түүнчлэн терроризмын үзэл суртал, суртал ухуулгад автагдах эрсдэл бүхий нийгмийн тодорхой хэсэг бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх, өөрийн байгууллагын албан хаагчид болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдад экстремизм, радикализмын үзэл санаа, шашны үзэл санаа, суртал ухуулгын талаар тогтмол мэдээлэл хийж, мэдлэг олгох нь чухал бөгөөд өөрийн байгууллагын албан хаагчдад хувь хүн, радикалист болон экстремистүүд, террорист этгээд, бүлэг, бүлэглэл, байгууллагын үзэл, тэдгээрийн бүтэц, үйл ажиллагааны онцлогийн талаар ололын болон практик сургалт зохион байгуулж, тэдгээрт тохирсон урьдчилан сэргийлэх болон хяналт тавих ажлыг төлөвлөн зохион байгуулах нь өнөөгийн зайлшгүй хийх ёстой ажлуудын нэг болоод байна.

Терроризмтой тэмцэх ажлын хамгийн чухал хэсэг нь терроризмоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээлэл цуглуулах, нарийвчилсан судалгаатай байх явдал байдаг.

Тухайн олон улсын арга хэмжээний аюулгүй байдал, арга хэмжээнд оролцогч төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах, аливаа террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх хамгийн чухал ажил бол мэдээ мэдээлэл цуглуулах явдал юм. Олон улсын томоохон хурлын аюулгүй байдлыг болж буй газар оронд хамгаалах нэг хэрэг, харин болохоос өмнө урьдчилан мэдээ мэдээлэл цуглуулах нь үндсэн ажил болно.


Ялангуяа цуглуулсан мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, террорист үйлдлийн шинж тэмдгийг илрүүлэхэд ихээхэн анхаарч ажиллах шаардлага тулгарч байна.


2016 оны 07 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Ази Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт"-ын аюулгүй байдлыг хангах зорилгоор "Нэгдсэн удирдлагын төв Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл, Шуурхай удирдлагын штаб Төрийн тусгай хамгаалалтын газар, Цагдаагийн ерөнхий газар дээр тус тус байгуулагдан ажилласан.


Шуурхай удирдлагын штабт ирүүлэх мэдээ, мэдээллийг утас, хэт богино долгионы станц, мессеж хэлбэрээр болон Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, Нэгдсэн удирдлагын төв, Төрийн тусгай хамгаалалтын шуурхай удирлагын штабтай хамгаалалт, аюулгүй байдлын талаарх онцлог мэдээ, мэдээллийг дүрс царайгаар таних утас, нууцлалтай дотоод сүлжээгээр тус тус шуурхай дамжуулж ажилласан.

Гэвч өнөөдөр гадаадын олон орны хууль сахиулах байгууллагуудын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны арга, хэлбэр, тэргүүн туршлагыг тодорхой хэмжээгээр судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа боловч шаардлагатай хувцас, хэрэглэл, техник, хэрэгсэл хүрэлцээтэй хэмжээгээр авах боломж бололцоо дутмаг байгаа нь өнөөдрийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Тиймээс олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үр нөлөөг улам сайжруулах үүднээс дараах хэдэн саналыг дэвшүүлж байна.

 Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааны арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд иж бүрэн судалгаа шинжилгээ хийж, тулгамдаж байгаа асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох мэргэжлийн судалгааны баг ажиллуулах;

 Гадаадын улс орнуудын олон нийтийн аюулгүй байдлыг хангах төрөлжсөн байгууллагуудтай харилцан, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар практикаар туршигдсан туршлагыг өөрийн орны хөрсөнд буулгах ажлыг зохион байгуулах;

 Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хамрах хүрээг нарийвчлан тодорхойлж, ажил үүргийн давхардлыг арилгах арга хэмжээ авч, эрх зүйн хийдлийг арилгах.



ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛД ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫГ ТУСГАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

CONSIDERATIONS TO REFLECT PUBLIC OPINION TO CHALLENGES ENCOUNTERED TO THE LAW ENFORCEMENT ORGANIZATIONS

Ч.ДАВААСҮРЭН

Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК-ийн Судалгаа хөгжил хариусан захирал, Бизнес удирдлагын магистр, МУИС-ийн Бизнесийн сургуулийн докторант.

Ттовч агуулга: Олон нийтийн санаа бодол гэдэг бол тухайн нэг асуудлаар нийгмийн дийлэнх хэсгийн илэрхийлж буй үзэл бодол, хандлага, итгэл үнэмшлийн нийлбэр цогц юм. Олон нийтийн санаа бодол нь нийгмийг цогцлоох, өөрчлөх чухал хүч болдог. Олон нийтийн санаа бодлын судалгааг хууль санаачлах, батлуулах, хуулийн хэрэгжилтийг хангуулахад ашиглаж болно. Энэхүү нийтлэлд олон нийтийн санаа бодлын судалгаа нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай хэрхэн холбогдож болох, түүнийг хэрхэн ашиглах, хууль сахийлах байгууллагатай үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн сана бодлын судалгаанд тулгарч буй асуудлыг авч үзлээ.

Abstract: Public opinion is an aggregate of the individual views, attitudes, and beliefs about a particular topic, expressed by a significant proportion of a community. Public opinion is vital power to shape and change community. Public opinion research could be used for drafting and lobbying laws and promoting law enforcement. This article concludes how law enforcement organizations and public opinion research are related, how it could be used for the law enforcement organizations and general issues encountered in public opinion research, which could be relevant to the

law enforcement organizations.

НЭГ. ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Дэлхийн улс орнуудын практикаас харахад хууль сахиулах үйл ажиллагаа нь нэлээн өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүний нийт иргэдэд шууд мэдрэгдэх хууль сахиулах, аюулгүй байдлын хосолсон шинжтэй үйлчилгээг цагдаагийн байгууллага гүйцэтгэдэг. Гэхдээ хууль сахиулах байгууллагууд нь өөрийн зорилго чиг үүргээс хамаараад янз бүр байдаг. Тухайлбал, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хоёрны нэг нь иргэнд үйлчилдэг захиргааны байгууллагын шинжтэй нөгөө хэсэг нь хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэх шинжтэй байдаг.¹

Иргэд, үйлчлүүлэгчдийн санаа бодлыг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх нь иргэдэд үйлчилдэг төрийн байгууллагын нэг чиг үүрэг байх ёстой. Нөгөө талаар аливаа хууль тогтоомжийн төслийг боловсруулахад иргэд олон нийтийн санаа бодлыг тусгах нь хуулийн хэрэгжилтэд эерэг үр нөлөөг өгөх болно. Түүнчлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх нь хууль сахиулах байгууллагын салшгүй нэг хэсэг байдаг. Тухайлбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь “гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ”² гэж тодорхойлогдож байгаа бөгөөд “гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ”³ гэж ангилж авч үзсэн байдаг.

Тэгэхээр хууль сахиулах байгууллагын

¹ Г.Оюунболд. “Хууль сахиулах ажиллагааны шинэтгэл”. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. УБ., 2014. №1.

² Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль. 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт.

³ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль. 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт.



үйл ажиллагаанд олон нийтийн санаа бодлыг судлах, үр дүнг үйл ажиллагаандаа тусгаснаар хуулийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Олон нийтийн санаа бодол бол нийгмийг цогцлоон бий болгох, өөрчлөхөд нөлөөлөх чухал хүч юм. Мэргэжлийн түвшинд сайтар зохион байгуулж, олон нийтэд түгээсэн судалгааны үр дүн олон нийтийн дуу хоолойг бүгдийн анхаарлын төвд аваачих чухал хэрэгсэл болдог.

Гэсэн хэдий ч олон нийтийн санаа бодлыг судлахад анхаарах ёстой асуудлууд байгааг дараагийн бүлэгт авч үзэх болно.

ХОЁР. ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГАА, ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХЭРЭГЛЭЭ

Олон нийтийн санал бодол (Public opinion) хэмээх нь тодорхой асуудлаар нийгмийн зонхилох хэсгийн илэрхийлж буй хувь хүмүүсийн үзэл бодол, хандлага, итгэл үнэмшлийн нийлбэр юм⁴. Тухайн асуудлаар нийгмийн тодорхой бүлэг буюу олон нийт (эх олонлог)-ийг төлөөлж чадах жижиг хэсэг (түүвэр)-ийн санаа бодлыг олж тодруулах үйл явцыг олон нийтийн санаа бодлын судалгаа (public opinion poll or public opinion research) гэж тодорхойлдог. Олон нийтийн санаа бодлын судалгааны арга зүй нь социологийн судалгааны нийтлэг ойлголт, арга зүйд тулгуурладаг бөгөөд улс төр, нийгэм, хүн болон угсаатан судлал, сэтгэл судлал зэрэг бусад судалгааны чиглэлүүдтэй уялддаг.

Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн санаа бодлын судалгааг дараахь чиглэлд авч ашигладаг. Үүнд:

1. Тухайн асуудлаар олон нийтийн санаа бодлыг олж тодруулан, хуулийн үндэслэл, үзэл баримтлалд тусгах, нөлөөллийн болон лобби арга хэмжээнд ашиглах. Өөрөөр хэлбэл, асуудлыг олон нийт, шийдвэр гаргагчдын анхаарлын төвд хүргэхэд олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүн чухал ач холбогдолтой.

2. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн өгч буй үнэлгээ, сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлж, үйл ажиллагааны олон нийтийн хүлээлтэд нийцүүлэн ажиллах.

3. Хууль сахиулах байгууллагын талаарх олон нийтийн дүнд бий болсон дүр төрхийг (public image of the law enforcement) олж илрүүлэх, эерэг сэтгэгдэл

дүр төрхийг бий болгох кампанит ажлуудыг хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлох.

4. Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг олж илрүүлж, урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, ойлголт ухамсрыг дээшлүүлэх (public awareness) арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ашиглах.


5. Тодорхой асуудлаар олон нийтийн мэдлэг, хандлага, ойлголт, туршлагыг олж илрүүлэн түүнийг өөрчлөх нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.


Хууль сахиулах байгууллагуудын хувьд олон нийтийн санаа бодлыг судалж, үйл ажиллагаандаа ашиглах нь хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд болон нийгэмд үйлчилж байгаа институцийнхээ хувьд зайлшгүй хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэг болж байна. Манай хууль сахиулах байгууллагуудын энэ чиг үүргийн хэрэгжилт харьцангуй учир хангалтгүй байгаа нь хүний нөөц болон хөрөнгө санхүүгийн дутагдалтай байдал, судалгааны ажлыг хийх мэдлэг чадавхи бүрдээгүй, судалгааны үр дүнг ойлгож ашиглах хандлага дутагдалтай зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Гэсэн хэдий ч хууль сахиулах байгууллага болон үндэсний судалгааны байгууллага, институцтай хамтран ажиллах хамтын ажиллагааг сайжруулж чадвал уг асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.


Олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүнг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд ашиглахтай холбоотойгоор тулгамдаж буй асуудлуудыг дараагийн бүлэгт авч үзлээ.

ГУРАВ. ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙН ШИЙДЭЛ


Олон нийтийн санаа бодлын судалгаа нь дараахь үе шатуудаар хэрэгждэг бөгөөд судалгааны хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг энэ үе шатны дагуу авч үзлээ.


 Судалгааны аргачлал арга зүйг боловсруулах (Survey designing);

 Судалгааны түүврийн хүрээ, аргыг тодорхойлж, түүвэрлэлтийг хийх (Sampling design);

 Судалгааны хэрэгсэл – асуулга, удирдамжийг боловсруулах (Survey instrument design);

 Судалгааны мэдээллийг цуглуулах (Data collection);

 Мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ (Data analysis);

 Судалгааны үр дүнг танилцуулах, тайлагнах (Reporting and release).

Судалгааны аргачлал арга зүйг

⁴ <https://www.britannica.com/topic/public-opinion>



Боловсруулах: Манай нөхцөлд ихэнхдээ судалгааг гэдгийг нэг асуулга боловсруулаад, хүмүүсээр бөглүүлж аваад үр дүнг нь нэгтгээд гаргахыг судалгаа гэж ойлгох тал байдаг. Гэтэл судлах гэж буй асуудал, судалгааны гол асуудлыг агуулсан судалгааны объект буюу түүврийн нэгжийн шинж чанараас шалтгаалаад судалгааны өөр өөр аргачлал арга зүйг дангаар нь болон хослуулан ашиглах шаардлага гардаг. Энэ хүрээнд зөвхөн тоон судалгааны аргыг дангаар нь ашиглах бус чанарын судалгааны аргууд болох фокус бүлгийн ярилцлага (Focus Group Discussion (FGD)), гол мэдээлэгч нартай хийх ганцаарчилсан ярилцлага (Key Informants Interview (KII) or In-Depth Interview (IDI)), ажиглалт, туршилт судалгаа, кэйс шинжилгээ болон баримт бичгийн судалгаа (Desk review)-ны аргуудыг ашиглах хэрэгтэй.

Түүнчлэн тухайн асуудалд хандах сэтгэл хөдлөлийн хандлага (emotional)-ын цаана

Шигтгээ 1: Авлигын эсрэг хуульд заасны дагуу Авлигатай тэмцэх газар Авлигын индексийг 2 жил тутам гаргаж олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээсэн байдаг. Авлигын индексийн судалгааны арга зүйг 2009 онд боловсруулсан бөгөөд авлигын индексийг тооцохдоо авлигын талаарх олон нийт (иргэд, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид)-ийн төсөөллийн судалгаа (тоон судалгаа), шинжээчдийн төсөөллийн судалгаа (KII) болон авлигын гэмт хэрэг зөрчлийн мэдээлэл, төрийн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үнэлгээ зэрэг бусад мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ (баримтын шинжилгээ)-ний үр дүнд үндэслэн тооцож ирсэн.

байгаа бодит хандлага (rational)-ыг нь илрүүлэх нь олон нийтийн санаа бодлыг тодорхойлох судалгааны хүрээнд авч үзэх шаардлагатай асуудал болж байна. Олон нийт тухайн асуудлын талаар бодитой ойлголт мэдлэг байхгүй нь судалгааны үр дүнд шууд нөлөөлөх тал байдаг. Орон нутгийн захиргааны байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөндөө иргэдийн саналыг авч тусгасан хэдий ч уг үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхлэхэд иргэдийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарч байсан тохиолдол байдаг.

Шигтгээ 2: Нийслэлийн Засаг даргын тамгын газраас Азийн сан болон Стэнфордын их сургуулийн Зөвлөлдөх ардчиллын төвтэй хамтран 2015 онд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүд дээр иргэдийн саналыг авсан. Ингэхдээ Стэнфордын их сургуулийн Зөвлөлдөх

ардчиллын төвөөс боловсруулсан Зөвлөлдөх санал асуулгын аргыг ашигласан. Эхний шатны судалгаанд хотоос хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл хөтөлбөрийг иргэдэд ямар нэг мэдээлэл өгөхгүйгээр шууд эрэмбэлүүлэн үнэлүүлсэн (Pre-polling). Үүний дараа нийт судалгаанд оролцогчдын тодорхой хэсгийг сонгон авч төсөл хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хэлэлцүүлсний дараа дахин санал асуулгын судалгаа (Post-polling)-г авахад үр дүн өмнөхөөс нилээд өөрчлөгдөж гарсан. Иргэд метро гэх мэт хөрөнгө их шаардагдах төслийг өмнө нь сонгож байсан бол хэлэлцүүлэгийн илүү үр ашигаа өгөх барилгын материалын үйлдвэрлэлийн парк байгуулах зэрэг төслийг сонгох болсон.

Судалгааны түүвэрлэлт: Судалгааны нэгжийг тодорхойлох, тэдгээр нэгжийн мэдээллийг багтаасан түүврийн хүрээг бэлтгэн, төлөөлөх чадвартай түүврийг хийх нь судалгааны үр дүнд шууд нөлөөлдөг. Социологийн судлаачдын хувьд энэхүү түүврийн төлөөлөх чадвар гэдэгт төдийлөн анхаарал хандуулахгүй байх тал ажиглагддаг. Судалгааны түүвэрлэлтийн асуудалд ач холбогдол өгөөгүйгээс шалтгаалан түүврийн гажуудал үүсдэг. Энэ тохиолдолд “олон нийт ингэж үзэж байна” гэж дүгнэх боломжгүй болно.

Шигтгээ 3: Дэлхийн банкнаас хийсэн нийслэлийн зүгээс иргэдэд үзүүлж буй үйлчилгээ чанар хүртээмж, иргэдийн оролцооны байдлыг тодруулах судалгааг хийхэд зөвхөн нийслэлд бүртгэлтэй иргэд бус нийслэлд шилжин ирээд бүртгэлгүйгээр амьдарч байгаа иргэдийг хамруулах шаардлагатай болсон. Иймд хороон дээр байдаг Хүн ам, өрхийн бүртгэлийг судалгааны түүврийн хүрээ болгон ашиглах боломжгүй болсон. Иймд талбарт суурилсан түүврийн хүрээ буюу нийслэлийн гэр хороолол дахь хашаа, сууцны сансраас авсан зургийг дөрвөлжин нүднүүдэд хуваасан талбаруудыг түүврийн нэгж болгон сонгож авч тэр талбар дээр амьдарч байгаа өрхийг судалгаанд хамруулсан.

Шигтгээ 4: Найрсаг байдлын судалгааны та хэр найрсаг хүн бэ гэсэн асуултуудад судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь өөрийгөө найрсаг гэж тодорхойлж байгаа хэдий ч Улаанбаатарчууд, Монголчууд хэр найрсаг вэ гэдэгтэй санал нийлж байгаа хүмүүсийн эзлэх хувь өөрийгөө найрсаг гэж үзэж байгаа хувиас бага байсан. Түүнчлэн тухайн хүний найрсаг эсэхийг илрүүлэхийн



тулд тодорхой нөхцөлд хэрхэн хандах вэ гэдэг байдлаар задалж асуусан асуултуудын үр дүнг нэгтгэн гаргахад шууд асуусан асуултын үр дүнгээс мөн буурч гарч байсан.

Судалгааны асуулгыг боловсруулах:

Олон нийтийн санаа бодол, туршлага, хандлагыг илрүүлэхэд асуултыг шууд тавих нь учир дутагдалтай байдаг. Сүүлийн үед тухайн нэг асуудалд хандах хандлагыг илрүүлэхдээ түүний бүрэлдэхүүн хэсгүүдээр задлан асуух, хандлага туршлагыг илрүүлэхдээ бусад хүмүүсийн хувьд асуух байдлаар тухайн хүний хандлагыг тодорхойлох зэрэг аргуудыг ашиглаж байна.

Судалгааны мэдээлэл цуглуулалт:

Судалгааны мэдээлэл цуглуулалтын шатанд судлаачийн ёс зүйн асуудал, мэдээлэл цуглуулалтын арга болон мэдээллийн чанарт тавих чанарын хяналтын учир дутагдалтай байдлаас үүдэн гарах асуудлууд тулгардаг. Судалгааны бүхий л үе шатанд судалгаанд оролцогчийн мэдээллийг нууцлалыг хадгалах, судалгааг сайн дурын үндсэн дээр авах гэх зэрэг ёс зүйн дүрэм журам шаардлагатай болдог.

Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологи, техник технологийг дэвшилг судалгааны мэдээлэл цуглуулалтад өргөнөөр ашиглах болсон. Ингэснээр мэдээллийн чанарт тавигдах хяналт сайжрах, мэдээлэл цуглуулалтыг богино хугацаанд үр дүнтэй хийх, судалгаанд оролцогчийн санаа бодлыг илүү бодитойгоор олж илрүүлэх зэрэг боломжийг олгож байна. Тухайлбал сүүлийн үед судалгааны мэдээлэл цуглуулалтад дараахь дэвшилтэт арга техникүүдийг ашиглаж байна. Үүнд:

- **Таблетаар судалгааны мэдээллийг цуглуулах** (CAPI буюу Computer Assisted Telephone Interview). Таблетаар буюу ухаалаг төхөөрөмжөөр мэдээллийг цуглуулснаар мэдээлэл цуглуулалт, оруулалт, шалгалтын үйлдлийг нэг хийх, цаасны хэрэглээг бууруулах, мэдээллийг богино хугацаанд хүлээн авч шалгах, ярилцлагын бичлэгийг хийж мэдээлэлтэй тулгаж шалгах, ярилцлага хийгдсэн байршлыг тодорхойлох, зураг дүрс, видео зэрэг визуаль элементийг судалгааны асуулгад ашиглах зэрэг олон давуу талыг олгох болно.

- **Утсаар судалгаа авах** (CATI буюу Computer Assisted Telephone Interview). Утсаар судалгааг авснаар богино хугацаанд орон зайн хязгаарлалтгүйгээр мэдээллийг цуглуулах боломжтой болно.

- **Нейро маркетингийн судалгааны арга техникийг ашиглан судалгаа авах.** Энд тухайн нэг зурагт

хуудас, сурталчилгааны материал дээр судалгаанд оролцогчийн анхаарал хэрхэн төвлөрч байгааг тодорхой хүний нүдний хүүхэн харааны хөдөлгөөнийг бүртгэх Eye tracking технологи болон хүний анхаарал, сэтгэл хөдлөлийн түвшинг илрүүлэх EEG (Electroencephalography) зэрэг технологийг дурдаж болно.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, танилцуулах: Олон нийтийн санаа бодлын судалгааны үр дүн нь тухайн асуудлыг олон нийт, шийдвэр гаргагчдын анхаарлын төвд аваачих, тухайн асуудалд хандах олон нийтийн хандлагыг өөрчлөхөд чухал ач холбогдолтой гэж дээр дурдсан. Тиймээс судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийх, үр дүнг харуулахдаа дараахь асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд:

- Тооны хүчийг ашиглах, тухайн асуудлыг илүү тодруулж харуулахын тулд харьцуулсан харьцангуй үзүүлэлтийг тооцож дүгнэж хэлэх гэх мэт. Монгол Улсын хүн амын 29.9% нь ядуу гэж хэлэхээс илүүтэй "гурван хүн тутмын нэг нь ядуу" гэж хэлэх нь илүү хүрч байх жишээтэй.

- Тодорхой нэг дүрийг ашиглан түүх өгүүлсэн байдлыг асуудлыг гаргаж тавих. Ингэснээр тавьж буй асуудлыг уншигч, үзэгчдэд илүү ойр хүргэх боломжтой болдог.

- Инфографик ашиглан олон тооны мэдээллийг нэг дор ойлгомжтой байдлаар үзэгчдэд хүргэх. Тухайлбал, уншигч, үзэгчид үгнээс дүрслэлийг илүү хурдан ойлгож хүлээж авдаг гэх мэт.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Хууль сахиулах байгууллагын тулгамдсан асуудалд олон нийтийн санаа бодлыг тусгах асуудлууд гэсэн энэхүү илтгэлийн хүрээнд дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны тодорхой хэсэг нь иргэд олон нийтэд үйлчлэхэд чиглэгддэг. Иймд иргэд олон нийтийн санаа бодол, санал хүсэлтийг сонсож үйл ажиллагаандаа тусгах хууль сахиулах байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн нэг байх ёстой.

- Хууль санаачлан батлуулах, батлагдсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангуулахад олон нийтийн санаа бодол чухал үүрэгтэй.

- Хууль сахиулах байгууллагуудын хувьд энэ чиглэлд тодорхой хэмжээгээр анхаарч ажиллаж байгаа хэдий ч олон нийтийн санаа бодлын судалгааг



хэрэгжүүлэхэд тодорхой асуудлууд тулгарч байна.

- Иймд хууль сахиулах байгууллагуудын хувьд энэ чиглэлийн судалгааны байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагаанд нэвтэрсэн дэвшилтэт шинэлэг арга зүйд суурилсан, хууль сахиулах байгууллагын онцлогийг тусгасан аргачлал арга зүйг боловсруулан ажиллах хэрэгтэй.

- Судалгааны үе шат бүрт тухайлбал, судалгааны аргачлалыг боловсруулахаас эхлүүлэхэд судалгааны үр дүнгийн тайлан, танилцуулга бэлтгэх хүртэлх үе шат бүрт тулгамдаж байгаа, анхаарах асуудлыг энэхүү илтгэлд ерөнхий байдлаар тодорхой жишээ, шийдлийн хамт тусгасан бөгөөд эндээс хууль сахиулах байгууллагын чиглэлээр судалгаа хийж буй судлаачид үйл ажиллагаандаа анхаарч авч үзэх шаардлагатай.

- Олон нийт, иргэдийн санаа бодлыг илэрхийлэх тул олон нийтийн санаа бодлын судалгаанд нийгмийн бүхий төлөөллийг бүрэн хамруулсан төлөөлөх чадвартай түүврийг хийхэд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй.

- Хууль сахиулах байгууллагын асуудлаар олон нийтийн санаа бодлыг сонсож судлах нь өвөрмөгц онцлог талтай, судалгаанд оролцогчдын хувьд өөрсдийн бодол санааг шууд, нээлттэй илэрхийлэхгүй байх талтай.

- Тиймээс судалгааны асуулгыг боловсруулахдаа асуудлыг задлан асуух байдлаар тухайн хүний хандлагыг олж илрүүлэх, судалгааны мэдээлэл цуглуулалтад орчин үеийн дэвшилтэт техник технологийг ашиглах шаардлагатай болж байна.

Мэдээллийн өнөөгийн эрин зуунд олон нийт маш их хэмжээний мэдээллийн дунд оршиж байгаа бөгөөд судалгааны үр дүнг энгийн ойлгомжтой байдлаар олон нийт, зорилтот